

АНУ-д болсон чуулганы үед заасан лекцүүд

Ли Хонжи

Гарчиг

Нью Йорк хотод заасан Фа лекц (1997 оны 3 сарын 23)
Сан Франциско хотод заасан Фа лекц (1997 оны 4 сарын 6)
Нью Йорк хот, уулзалтын үеэр заасан Фа (1997 оны 3 сарын 22)

Нью Йорк хотод заасан Фа лекц

1997 оны 3-р сарын 23

Холоос гадна бас далайгаар тусгаарлагдсан болохоор та нартай уулзах амаргүй байдаг. Гэхдээ та нар намайг биечлэн харж чадахгүй ч гэсэн бясалгаж байх л юм бол, үнэндээ би чиний хажууд байж байдаг. Хэрэв чи бясалгаж байх л юм бол би чамайг эцэст нь хүртэл хариуцах болно, түүнчлэн би чамайг хором бүрт харж хандаж байдаг. (Алга ташив) Хэн боловч үүнийг ингэж хийхгүй бол буруу номын бясалгал зааж байгаатай адил, муу зүйл хийж байна, тэнгэрийн нууцыг хамаагүй задруулж байна гэсэн үг. Мэдээж, та нар үүнийг бодит туршлагаасаа аль хэдийн мэддэг

болсон болохоор би үүнийг дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагагүй. Би зөвхөн хийх боломжтой зүйлийн талаар л ярьдаг, боломжгүй зүйлийг ярьдаггүй. Тиймээс Дафа зөв замаар дэлгэрч байгаа.

Та бүхэнтэй хамгийн сүүлд уулзахад ийм олон хүн байгаагүй. Мэдээж, ажлаасаа болоод энд ирж чадаагүй олон хүмүүс байгаа. Би та нартай хамгийн сүүлд уулзсанаас хойш олон хүн Дао-д орж Фа-г олж авсан байна. Энэхүү Фа ингэж маш хурдан дэлгэрч, ийм өргөн цар хүрээтэй тархаж байгаа нь Дафа-гийн хүч чадалтай холбоотой юм. Үүний зэрэгцээ, Дафаг тараах явцад бидний баримталсан зам зөв байсан. Бид сурагчдынхаа болон нийгмийн өмнө үнэхээр хариуцлагатай хандаж ирсэн учраас ийм үр дүнд хүрч чадсан юм. Та нартай уулзах боломж ховор байдаг, учир нь надад АНУ-д ирэхэд амаргүй, виз авах шаардлагатай, тиймээс нэлээд төвөгтэй байдаг, харин одоо уулзаж чадсан болохоор та нарын зарим асуудлыг шийдвэрлэхэд чинь туслахын тулд би чадах бүхнээ хийхийг хүсч байна. Та нар асуумаар байгаа бүх асуултаа тавьж болно, би та нарт хариулья. Энэ боломжийг их үр дүнтэй ашиглаж та нарын ээдрээтэй, хэцүү зарим асуултыг шийдвэрлэхэд болон Дафаг АНУ-д илүү үр дүнтэй дэлгэрүүлэхэд тусалъя. Би уг нь сурагчидтайгаа зарим тодорхой асуудлаар ярилцахыг хүссэн, гэхдээ өчигдөр та нарын заримд “тусгай завшаан” олдсон. Тэд өчигдөр эрт ирсэн болохоор би тэдний зарим асуултанд хариулсан. Гэхдээ өнөөдөр харамсах хэрэггүй. Өчигдөр сонсож чадаагүй хүмүүс асууж болно, би та нарт хариулья.

Би энэ цагийг ашиглан бясалгалтай холбоотой асуудлаар ярина, өөрөөр хэлбэл Фа ярина. Энэ хугацаанд та нар маш хурдан дээширсэн гэдгийг би мэднэ, үнэндээ маш хурдан. Өнгөрсөн удаа би АНУ-аас Хятадад буцаж очоод Хятад дахь сурагчиддаа АНУ бол онцгой газар, тэнд олон гайхалтай хүмүүс, ялангуяа олон гайхалтай Хятад хүмүүс байдаг гэж хэлсэн. Эдгээр хүмүүс төрөлхийн суурь сайтай, Дафа-гийн талаар гүн гүнзгий ойлголттой, хурдан ойлгоцтой, өөрсдийн түвшингээ хурдан ахиулж байна. Та нарт ийм давуу талууд байна. Гэхдээ тайвшрах хэрэггүй, учир нь та нарт янз бүрийн зууралдсан сэтгэл, саад бэрхшээлүүд байна,

үүнийг даван туулах хэрэгтэй, тэгвэл та нар илүү хурдан сайжирч чадна.

Одоо би өвчний карма-ны талаар ярьж, энэ бол Фа-г гүнзгий түвшинд сураагүй манай олон сурагчдын бодлогоширсон асуудал юм. Гэхдээ би бясалгагчид өвчнийг хэрхэн даван туулах ёстойг номондоо аль хэдийн тайлбарласан. Энэ талаар өөр өнцгөөс дахин ярьж. Үнэндээ бол, бясалгагчид бид өөрсдийгөө энгийн хүмүүстэй андуурах ёсгүй. Эрт цагт хэн нэгэн лам болоход хүмүүс түүнийг энгийн хүн гэж үздэггүй байсныг та нар мэднэ, аль хэдийн хагас бурханд тооцогддог байсан. Тэгэхээр хүн, бурхан хоёрын хооронд ямар ялгаа байдаг вэ? Хүнд сэтгэл хөдлөл байдаг (чин)-маш хүчтэй сэтгэл хөдлөлтэй. Хүн төрөлхтөн яг энэ сэтгэл хөдлөлийн нөлөөнд энэ ертөнцөд амьдардаг. Сэтгэл хөдлөлгүйгээр чи энэ ертөнцөд амьдарч чадахгүй. Чамд юу таалагддаг, ямар хобби сонирхол байдаг, чамайг юу аз жаргалтай болгодог, юу уурлуулдаг, гэр бүлийн хайр, эхнэр нөхрийн хайр, үр хүүхдээ хайрлах, юу хийхийг хүсдэг, юу хийхийг хүсдэггүй, зарим төрлийн зүйлд дуртай байх, зарим зүйлд дургүй байх гэх мэтчилэн энэ бүгд хүний сэтгэл хөдлөлөөс үүсдэг. Энэ сэтгэл хөдлөлгүйгээр энгийн хүний нийгэм гэж оршихгүй байх байсан. Энэ сэтгэл хөдлөлийн дунд хүмүүсийн энгийн хүний төлөв байдалд нийцүүлэн хийдэг зүйлийг буруу гэж үзэж болохгүй. Хүмүүсийн ойлголт бүгд буруу байсан гэж яагаад өнгөрсөн үеийн олон хүмүүс хэлдэг байсан бэ? Тэгж хэлсэн хүмүүс энгийн хүн биш болсон байсан, тэд хүмүүсийг өөр түвшнээс хардаг байсантай холбоотой юм. Гэхдээ тэд энгийн хүмүүсийн дунд байдаг болохоор, чи тэднийг буруу гэж хэлж болохгүй. Өчигдөр миний хэлсэнчлэн, энэ хүний нийгэм хэдий аймшигтай боловч энэ нь нэг түвшин, бүх сансар ертөнцийн дээрээс дооших түвшингүүдийн хамгийн доод түвшин, орчлон ертөнцийн мөн чанар болох Дафа-гийн хамгийн доод түвшин дэх илрэл. Хүний энэ түвшин оршихгүй байж болохгүй. Энэ түвшинд бясалгах боломжгүй гэсэн үг биш, мөн хүн болгон Буддад бясалгах бас боломжгүй. Хүний нийгэм оршин тогтнохгүй байх боломжгүй, зүгээр л ийм байдлаар оршин тогтнодог юм. Энэ бол маш онцгой орчин бөгөөд өндөр түвшний хүмүүсийг төрүүлж чаддаг. Тиймээс

чи хүмүүсийг дээд түвшний өнцгөөс харахад өөр байдаг. Тийм ч учраас бясалгагч хүний хувьд, чи юу ч харсан, юутай ч холбогдсон бай, тохиолдсон зүйлээ энгийн хүний үзэл бодлоор дүгнэж болохгүй гэж би хэлсэн. Тиймээс чи өөрийгөө илүү өндөр шалгуураар барих хэрэгтэй.

Энгийн хүн өвдвөл эмнэлэгт хандахгүй эсвэл эм уухгүй байх нь энгийн хүмүүсийн зарчимд нийцэхгүй, энэ дэлхийн зарчимд нийцэхгүй бөгөөд хүмүүс үүнийг хүлээн зөвшөөрч чадахгүй: “Мэдээж хүн өвдвөл эм уух хэрэгтэй.” “Мэдээж хүн өвдвөл эмнэлэгт хандах хэрэгтэй.” Хүмүүс үүнийг ийм байдлаар шийддэг бөгөөд энэ нь буруу биш юм. Гэхдээ бясалгагчийн хувьд чи энгийн хүнтэй өөрийгөө андуурч болохгүй. Үүнийг нухацтайгаар хэлбэл чи хүн биш болсон. Миний сая хэлсэнчлэн хүмүүс янз бүрийн сэтгэл хөдлөл, хүсэл эрмэлзлэлтэй байдаг бөгөөд сэтгэл хөдлөлөөр л амьдардаг. Бясалгалын явцад чи эдгээр зүйлийг аажимдаа хөнгөн авч үздэг болно, үүнээс аажмаар салсаар бүрэн орхино. Хүмүүс эдгээр зүйлсийн төлөө амьдардаг, харин чи тэгэхгүй. Чи хүнтэй адилхан байж болох уу? Чи адилхан биш. Тийм бол чи энгийн хүний асуудлыг шийдвэрлэдэг, өөртөө ханддаг зарчмаас өөр дээд түвшний зарчмыг яагаад дагахгүй гэж? Уг нь ийм л байх ёстой юм. Тиймээс бясалгагч бидний бие махбодийн хаа нэг газар таагүй мэдрэмж төрвөл үүнийг би өвчин биш гэж хэлсэн. Гэхдээ энгийн хүмүүсийн өвчин гэж үздэг байдал нь бясалгагчийн биед нүгэл гадагшилж байхад мэдрэгдэх байдалтай ижил байдаг. Энгийн хүнд үүний ялгааг хэлэх хэцүү. Тиймээс бясалгал нь ухамсрыг (ву) онцолдог. Хэрэв тэр байдал нь адилгүй байсан бол хүн бүр бясалгана, ухамсарлах асуудал байхгүй болно. Хүний биед зөвхөн тааламжтай байдал гардаг бол, тэнгэрийнхэн шиг үл ялихгүй таагүй байдал л мэдэрдэг бол хэл дээ, хэн бясалгахгүй байх билээ? Хүн бүр бясалгана биз дээ, гэхдээ энэ нь тооцогдохгүй, бясалгалд тооцогдохгүй. Түүнээс гадна ямар ч ухамсарлах зүйл байхгүй учраас, хүмүүст ингэж бясалгахыг зөвшөөрөхгүй. Тиймээс бясалгахад юу нь үнэн, юу нь худал болох нь тодорхойгүй нөхцөлд чамайг сорино, асуудалд яаж хандахыг чинь харна. Өөрийгөө бясалгагч гэж үзэж байна уу, эсвэл энгийн дундаж хүн гэж үзэж

байна уу гэдгийг чинь харна. Энэ нь чамайг бясалгаж чадах эсэхийг мэдэхийн тулд биш гэж үү? Мэдээж, чи энгийн харагдана, гаднаа энгийн хүнээс ялгарахгүй, гэхдээ үнэн хэрэгтээ чи бясалгагч хүн.

Өчигдөр би Буддын Фа бясалгалын талаар ярьсан. Бясалгал бол орчлон ертөнцөд хамгийн чухал зүйл юм. Хүн төрөлхтөн дээд түвшинд гарч Архат, Бодьсадва, Будда, Бумба (Дао) эсвэл Бурхан болохыг хүсдэг, Хэрэв нүглээр дүүрэн биетэй хүн Бурхан болно гэвэл үүнийг та нар ноцтой асуудал гэж хэлэхгүй гэж үү? Чи эдгээр асуудлыг дээд түвшний хатуу шалгуураар харж, зөв бодлоор өөрийгөө барьж байх ёстой биш гэж үү? Хэрэв чи эдгээр асуудлыг энгийн хүний өнцгөөс харж байвал чи өөрөө энгийн хүн биш гэж үү? Чамд Будда болох боломж олгоно гэдэг бол ноцтой асуудал, гэтэл чи өөртөө хүний байр сууринаас хандсан хэвээр, мөн эдгээр зүйлийг хүний зарчмаар дүгнэсээр л байна. Тэгвэл энэ нь нөлөө үзүүлэхгүй, чи үүнд нухацтай хандахгүй бол бясалгаж чадахгүй. Будда, Дао, Бурхад бол өнөөгийн лам хуврагууд болон өнөөгийн хүмүүсийн бодож байгаа шиг биш. Будда, Бурхад энгийн хүний сэтгэл хөдлөл, энгийн хүнийх шиг бодол, энгийн хүмүүсийн юмсыг ойлгодог шиг ойлголт огт байдаггүйг та нар мэднэ. Тэдний сэтгэн бодох нь огт өөр бөгөөд юмсыг хүнийх шиг ойлгох үзэл бодлоос ангид байдаг. Одоо хүмүүс Будда, Бодьсадва нарыг хүн шиг үздэг болсон, тэднийг хүнийх шиг сэтгэл хөдлөлтэй, хүмүүнлэг мэтээр боддог болсон. Зарим хүмүүс сүм хийдэд очиж Буддад мөргөж хүж өргөхдөө, тэнд бясалгах эсвэл хүндэтгэл үзүүлэх зорилгоор очдоггүй, харин юм гуйдаг, Будда нараас зууралдсан сэтгэлээрээ юм гуйдаг. Бодоод үз дээ, энэ нь ямар муухай бодол вэ!

Урьд өмнө хүмүүс Буддад хүндэтгэл үзүүлэн мөргөдөг байсан. Өөрөөр хэлбэл, тэд өөрсдөдөө зориулж ямар нэг зүйл гуйхын оронд, харин Будда нарт хүндэтгэл үзүүлэх гэж, Будда нарт мөргөн залбирал үйлдэх гэж, эсвэл Будда нар нигүүлсэнгүй бөгөөд хүн төрөлхтнийг бүхэлд нь хамгаалдаг болохоор, өөрсдийгөө Буддад бясалгуулж өгөөч гэж мөргөхөөр очдог байсан. Гэтэл өнөө үед

хүмүүс ийм байхаа больсон. Урьд хүмүүс Будда эсвэл Бодьсадвагийн талаар үргэлж зөв ариун сэтгэлээр боддог байсан, тэднийг агуу гайхамшигтайгаар сэтгэлдээ дүрслэн “Будда” эсвэл “Бодьсадва” гэдэг үгийг их хүндэтгэлтэйгээр дууддаг байсан. Харин өнөөгийн хүмүүст ийм ойлголт байхгүй болсон. Хүмүүс Буддын талаар амаа нээн дур зоргоороо ярьдаг болсон, Будда, Бодьсадва гэсэн үгс амнаас нь унах мэт хайхрамжгүй ярьцгаадаг. Тэр ч байтугай Будда-г хүссэнээрээ зурж сийлээд хаа хамаагүй дуртай газраа байрлуулдаг. Бүр Будда Амитаба, Гэгээн Мария нарын зураг хөргүүд хүртэл оршуулгын газруудаар дүүрэн байдаг. Энэ нь үнэхээр, хүмүүс Бурхдад үхэгсдийг харж ханд гэж зааж байгаатай адил, хүмүүс энэ тэрийг хий гэж Бурхдад тушааж байгаа мэт. Тэгсэн санаа биш үү? Бүгдээрээ бодоод үз дээ: Бурхан бол үнэхээр ариун бөгөөд агуу юм, гараа нэг даллаад л бүх хүн төрөлхтөнд аз жаргал авчирч чадна, бас нэг даллаад л бүгдийг сүйрэлд хүргэж чадна. Гэтэл чи тэдэнд ингэж хандана гэж үү? Хэрэв тэд хүмүүст нигүүлсэл үзүүлдэггүй байсан бол, хүмүүс тоомсоргүйгээр муу зүйл хийхэд л тэр даруйдаа ул мөргүй устгагдах байсан. Хүмүүс одоо үүнийг ойлгохгүй байгаа болохоор ийм үйлдэл хийж зүрхэлж байна. Тэд үнэндээ Буддуудыг доромжилж байна. Яг л миний урьд хэлсэнтэй адил юм. Би урьд та нарт рестораны цэсэнд хүртэл “Хашаан дээгүүр давж ирсэн Будда” гэх мэтийн нэртэй хоол байдаг гэж ярьж байсан. Буддад өнгө, амтны ямар ч зууралдал байдаггүй. Будда хоолны амтат үнэр авангуутаа хоол идэхээр хашаан дээгүүр үсрэн орж ирнэ гэж хэлж байгаа нь Будда-г хамгийн муухайгаар доромжилсон хэрэг биш гэж үү? Мөн “Архатын цагаан хоол” гэх мэт хоолнууд байдаг. Архатад ч гэсэн энгийн хүний өнгө, амтны зууралдсан сэтгэл байдаггүй. Гэсэн ч чи “Архатын цагаан хоол” хэмээх хоолыг Архатын иддэг хоол гэж хэлж байгаа нь түүнийг доромжилж байгаа хэрэг биш үү? Тэд энгийн хүмүүсийн хоолыг заваан гэж үздэг. Тэдний сэтгэлгээ хүнийхээс өөр. Хүмүүс одоо өнгө мөнгө, хүсэл сонирхолдоо хөтлөгдөн Бурхан, Будда нарт ийм байдлаар хандаж байна. Будда, Дао, Бурхдад хүнийх шиг сэтгэлгээ, энгийн хүнийх шиг бодол санаа байдаггүй юм. Гэхдээ миний саяхан хэлсэнчлэн хүмүүс Буддад мөргөх гэж очихдоо чин хүндэтгэл

бишрэл, бясалгах зүрх сэтгэлээр биш, харин Буддагаас юм гуйдаг: “Хүү төрүүлж өгөөч, хөрөнгө мөнгөтэй болгож өгөөч, гамшиг сүйрлээс зайлуулж өгөөч, гай зовлонг минь арилгаж өгөөч...” Тэдний хүсдэг зүйлс бүгд иймэрхүү л байдаг. Гэхдээ Будда нар эдгээр зүйлд оролцдоггүй, харин тэд хүмүүст дээдийн аврал үзүүлдэг. Хэрэв чи үхэшгүй мөнхрөгч шиг амьдарч, энгийн хүмүүсийн дунд бүх талын тохь тух эдэлж, хангалттай их мөнгөтэй, гай гамшиг, ямар ч өвчин зовлонгүй байсан бол, чи Буддад бясалгах эсвэл Бурхан болохыг хүсэх ч үгүй байх байсан. Маш их тав тухтай болчихвол, чи одоо аль хэдийн Бурхан болсон байна. Гэхдээ ийм байх боломжгүй.

Хүмүүс төрлөөс төрөлдөө нүгэл хийдэг. Хүний өөрийн нүгэл нь түүнд хүнд бэрхшээл, зовлон шаналал, гай зовлон, мөнгөний гачигдал, энэ төрөлд нь юм уу эсвэл дараагийн төрөлд нь тохиолдох олон төрлийн өвчинг авчирдаг. Нүглээ төлсний дараа л чамд аз жаргал, сайн сайхан ирнэ. Хэрэв буруу үйл хийснийхээ өрийг төлөхгүй бол үүнийг зөвшөөрөхгүй, энэ бол орчлон ертөнцөд оршдог зарчим. Чиний өмнөх амьдралд болон дараагийн амьдралд тохиолдсон зүйлсийг, чи хоёр өөр хүнтэй холбоотой асуудал гэж бодож магадгүй юм. Чухамдаа бусад оршихуйнууд чамайг харахдаа, чиний бүхэл оршин тогтнолын явцыг хардаг юм (ганцхан нэг амьдралыг чинь биш). Энэ нь чи нойрноосоо сэрээд, өчигдөр хийсэн зүйл чинь өнөөдөр хийсэн зүйлтэй ямар ч хамаагүй, өчигдөр хийсэн зүйлийг чи өөрөө хийгээгүй гэж хэлэхтэй адил юм. Гэхдээ бүгдийг нь чи хийсэн, тэд хүний амьдралыг ингэж л хардаг. Тиймээс би сая энэ санааг хэлэх гэж гол ярианаасаа хазайлаа: Чи эдгээр зүйлийг энгийн хүний ойлголтоор авч үзэж болохгүй. Энгийн хүн өвдвөл эм уух хэрэгтэй. Гэхдээ би чамайг бясалгагч гээд эм битгий уу гэж хориглохгүй. Гэхдээ бид бясалгалын талаар ярьж байгаа биздээ? Бид ухамсрын талаар яриагүй гэж үү? Чамайг бүх зүйлийг ухамсарлахыг шаардаагүй. Чи өөрөө хэр ухамсарлаж чадахаар л бол. Хэрэв хэн нэгэн би чадахгүй нь гэж хэлэхэд, "Үгүй ээ, би энэ зууралдсан сэтгэлийг орхиж чадахгүй, би эм уух ёстой. Хэдийгээр би бясалгадаг ч гэсэн эм уухгүй бол болохгүй" гэхэд би энэ асуудлыг юу гэж үзэх вэ?

Түүний ухамсар доройгоос болж сорилтыг давж чадаагүйд нь надад зөвхөн харамсахаас өөр арга байхгүй. Тэр өөрийгээ сайжруулж төгс гэгээрлийн зам руу том алхам хийж болох байсан, гэтэл тэр энэ алхмыг хийж чадаагүй. Энэ бол харамсалтай, гэхдээ би түүнийг цаашид найдваргүй болсон гэж хэлээгүй, бас эм уусны дараа бясалгах огт боломжгүй болсон гэж хэлээгүй. Хүн бүрийн ухамсарлах чадвар өөр өөр байдаг, мөн хүн бүрийн төрөлхийн өгөгдөл бас өөр байдагтай холбоотой юм. Зөвхөн сайжирч байж л энэ сорилтыг даван шинэ ойлголтыг олж авна. Хэрэв чи энэ асуудалд сайжирч чадахгүй, бүрэн ухамсарлаж чадахгүй бол энэ тал дээр чи энгийн хүн хэвээр байна гэсэн үг юм. Гэхдээ чамайг огт сайн биш гэж байгаа юм биш.

Эм уух, нүглийг арилгахын хоорондох харилцааны талаар та нартай илүү тодорхой ярилцъя. Төрөл төрөлдөө хуримтлагдсан нүгэл нь өвчин үүсэх шалтгаан болдог гэж би дөнгөж сая хэлсэн. Нүгэл (карма) гэж чухам юу вэ? Бусад орон зайнуудад оршиж байгаа нүглийн ширхгүүд нь жижигхэн байх тусам, түүний үрэл нь жижиг байх тусам, илүү их хүчтэй байдаг. Энэ нь бидний орон зайд нэвчин орж ирэхэд бичил организм, хамгийн бичил вирус болдог. Тэгэхээр чи өвчинг тохиолдлоор гардаг гэж хэлэх үү? Үүнийг орчин үеийн анагаах ухаан, эсвэл орчин үеийн шинжлэх ухаанаар ойлгож чадахгүй, энэ нь молекулаас тогтсон хамгийн том ширхгүүдийн давхаргаас бүрдэх энэхүү гадаргуйн орон зайд илэрсэн үзэгдэл гэж л ойлгогдоно. Тиймээс үүнийг өвчин, хавдар, аль нэг газрын халдвар, үрэвсэл эсвэл өөр ямар нэгэн зүйл гэж үздэг. Гэхдээ өнөөгийн шинжлэх ухаан хүмүүст өвчин үүсч буй үндсэн шалтгааныг олж харж чадахгүй, үүнийг үргэлж энгийн хүмүүсийн ойлгож чадах хязгаарлагдмал шалтгаанаар тайлбарладаг. Мэдээж, хэн нэгэн өвчин тусахад энэ нь ихэвчлэн ертөнцийн энэ түвшний зарчимд нийцдэг, ихэвчлэн энэ ертөнцөд өвчин эмгэгийг өдөөх гадаад хүчин зүйлс оршдог. Тэгээд энэ нь гадаад хүчин зүйлсийн нөлөөн дор дэлхийн зарчим, нөхцөл байдалд нийцсэн болдог. Гэхдээ үндсэн шалтгаан ба өвчин нь энэ орон зайд оршдоггүй. Чи эм уухад зөвхөн гадаргуу дахь өвчин, вирусыг л устгаж байгаа юм. Эм бол гадаргуйн вирусыг үнэхээр

устгаж чаддаг. Бясалгагчийн гон энерги нь вирус ба нүглийг автоматаар устгадаг. Харин эм бол бусад орон зайнуудаас гадаргуйд нэвтэрч гарч ирсэн нян вирусыг л устгадаг. Тэгэхэд нөгөө талд байгаа бүх зүйлс амьтай учраас вирус-нүгэл үүнийг мэдээд гарч ирэхээ болино. Ингээд чамд эм уугаад эдгэрсэн мэт болдог. Гэхдээ энэ нь тэнд хуримтлагдсаар л байдаг. Хүн төрлөөс төрөлдөө энэ зүйлсийг хуримтлуульж байдаг гэсэн үг. Хуримтлал тодорхой хэмжээнд хүрэхэд, тэр хүн эдгэршгүй болдог, тэр нас бараад бүрмөсөн устгагдана. Тэр амиа алдана, үүрд амиа алддаг. Энэ бол үнэхээр аймшигтай. Тиймээс би та нарт энэ учир холбоог тайлбарлаж өглөө. Хүмүүст эм ууж болохгүй гэж хэлж байгаа юм биш. Энгийн хүн өвдөхөд эмчилгээ хийлгэх зайлшгүй шаардлагатай.

Гэхдээ бясалгагчид бид үүнийг хэрхэн авч үзэх вэ? Бид чиний биеийг ариусгаж байгаа юм биш үү? Модны жилийн цагирагтай адил үзвэл, карма хамгийн голоос эхлээд чиний амьдралын төрлөөс төрөл дөхь биесийн давхарга болгонд оршдог. Чи бясалгалаар хичээллэхэд, би энэ нүглийг чиний голоос гадагш түлхэж байдаг. Би чиний нүглийг чамаас бүрэн гарч дуустал нь түлхэнэ, түлхээд л байдаг, түлхээд л байдаг, бас түлхсээр л байдаг. Энэ бүгдийг бидний биеийн гадаргуугаар дамжуулан гаргаж болохгүй. Хэрэв энэ бүгдийг чиний биеийн гадаргуугаар гаргасан бол чи тэвчин дааж чадахгүй байхсан. Үүний зөвхөн зарим хэсгийг гадаргуугаар гаргана. Чамд гэнэт өвдсөн мэт мэдрэмж гарсаар байх болно, чи энэ үед бие их таагүй байна, тэвчих аргагүй өвдөж байна гээд өөрийгөө энгийн хүнтэй адил үзэн эм уучихдаг. Тэгвэл энгийн хүнийг эм ууж болохгүй гэж бид хэзээ ч хэлдэггүй болохоор чи эм ууж болно. Чиний ухамсарлах чадвар төдийлөн дээшлээгүй учраас энэ шалгалтыг сайн давж чадсангүй гэж бид хэлнэ. Бясалгаж байхдаа эм ууж болохгүй гэсэн дүрэм бидэнд байдаггүй-ийм хатуу дүрэм бидэнд байхгүй. Гэхдээ би чамд Фа зарчмуудыг зааж өгч байна. Чи энэ карма-г гадагш нь гаргахыг хүсч байгаач гэсэн эм уугаад буцаагаад дотогш нь чихээд байхаар бид чиний биеийг яаж ариусгаж өгөх ёстой юм бэ? Мэдээж, бид чамд энэ бүгдийг өөр орон зайнуудад түлхэн гаргаж өгч чадах байсан. Гэхдээ энэ сансар

ертөнцөд ийм Фа зарчим байдаг: Нүглийг чинь арилгаж өгч байхад чи энэ зовлонг тэвчих ёстой гэж үздэг. Чи урьд өмнө нь бусдад учруулж байсан зовлонгоо өөрөө тэвчих ёстой. Гэхдээ чамайг бясалгагчийн хувьд, бид бүгдийг нь ийм замаар тэвчүүлэхгүй, яагаад гэвэл чи даахгүй нас барна, тэгвэл бясалгах боломжгүй болно биз дээ. Бясалгагчийн хувьд, чи Төгс гэгээрэлд хүрсний дараа адислалаараа урьд хохироосон амь бодиуддаа өрөө төлөх болно. Гэхдээ чи сэтгэл санааны зарим зовиурыг тэвчих ёстой. Бусдад төлөх ёстой өрнийхээ хэсгийг тэвчиж давснаар нүглээ төлж байдаг, учир нь чи зовлон амссан. Бүх зүйлс тусгаарлагдсан биш. Нүглээ хариулж байхдаа өвдөлтийн үед өөрийгөө бясалгагч гэж үзэж байх хэрэгтэй. Хэрэв чи үүнийг өвчин биш гэж үзвэл, чи үнэхээр энэ асуудал дээр энгийн хүний сэтгэлгээнээс илүү өндөр түвшний ойлголттой болсон гэсэн үг. Тэгвэл энэ асуудал дээр чиний оюун сэтгэлгээний хүрээ тэлсэн юм биш үү? Ийм хэрэг биш гэж үү? Дан ганц дасгал хийснээр бясалгалдаа сайжирч чадна гэж бодвол энэ нь инээдэмтэй. Дасгал нь Төгс төгөлдөрт “Гэгээрэлд” хүрэхэд л туслах хэрэгсэл юм.

Хүн бясалгалаар сэтгэл оюунаа сайжруулахгүйгээр хэзээ ч өөрийнхөө түвшинг ахиулж чадахгүй. Зөвхөн судар ном уншсанаар Буддад бясалгаж чадна гэж хүмүүсийн ярьдаг шиг биш юм. Олон сайн үйлс хийснээр Буддад бясалгаж болно гэж боддог хүмүүс бас байдаг. Энэ бүгд бол инээдтэй юм, тэд бүгд хүсэх сэтгэлээр хичээллэдэг (ювэй). Хэрэв чи жинхэнэ бясалгахгүй бол, судар ном дуржганатал унших нь ямар хэрэгтэй юм? Бясалгахгүйгээр Буддад хүрэх нь туйлын боломжгүй. Будда Шагжамүни Дарма (Фа) -г айлдаж байх үед судар ном гэж байгаагүй, Есүс өөрийн Номыг (Фа) зааж байх үед ч мөн адил. Хүмүүс зөвхөн жинхэнэ бясалгалаар хичээллэдэг байсан. Сэтгэл оюунаа бясалгахгүйгээр дээшээ гарч чадах уу? Чи тэр давхаргын шаардлаганд нийцэхгүйгээр дээшээ гарч чадах уу? Чамд янз бүрийн сэтгэл хөдлөл, дур хүсэл дүүрэн байхад, янз бүрийн зууралдсан сэтгэл байхад, Будда болохыг хүссэн сэтгэлээсээ илүүтэйгээр мөнгөнд шунаж байвал диваажинд очиж болох уу? Энэ бол үнэхээр боломжгүй зүйл. Та бүгд үүнийг ойлгосон байх гэж бодож байна.

Өөрөөр хэлбэл, бясалгагч бол ер бусын, ер бусын хүн байхад бие махбодийн таагүй байдлыг хэрхэн авч үзэх ёстой вэ? Энгийн хүмүүс өвчинтэй байдаг, гэхдээ чиний биений хувьд, би карма-г чамаас түлхэн гаргаж өгч байна. Хүний биеийн гадаргуу дээрх мэдрэлийн төгсгөлүүд хамгийн мэдрэмтгий байдаг учраас үүнийг гадаргуу луу түлхэхэд чамд таагүй мэдрэмж төрөх болно. Чамд өвчин туссан мэт санагдана, зарим тохиолдолд маш ноцтой юм шиг санагддаг. Ийм байдал гарч болно. Ийм зүйл тохиолдож болзошгүй тул дараах зүйлийг та бүгд бодоод үз. Хэрэв чи өөрийгөө энгийн хүн гэж үзэж байвал, үүнийг өвчин гэж үзэж байвал, мэдээжийн хэрэг бас болно, чи эм ууж болно. Чи энэ шалгалтыг давж чадсангүй, наад зах нь чи энэ тал дээр энгийн хүн. Энэ шалгалтыг давж чадвал, чи энэ тал дээр ер бусын хүн. Хэрэв чи Буддад бясалгахыг хүсч байвал чиний ойлголт бүх талаараа ер бусын байх ёстой. Хэрэв чи энэ зууралдсан сэтгэлийг орхихгүй бол чи энэ сорилтыг давах боломжгүй, ингэснээр чи Төгс гэгээрэлд хүрэх боломжгүй болно. Тиймээс хэрэв чи энэ боломжийг алдвал, энэ шалгалтыг давж чадахгүй унана. Үүнийг сайн ойлгодог манай зарим туслахууд, хуучин сурагчид сурагчдыг эм ууж байхыг нь харах болгондоо яагаад сэтгэл нь түгшдэг вэ? Мэдээжийн хэрэг, тэд үүнийг над шиг авч үзэж чадахгүй. Тэд бие биенээ сайн мэддэг болохоор “Чи эм ууж болохгүй” гэх мэтээр тэр хүнд хэлдэг. Гэсэн ч тэр хүн үүнийг ухамсарлахгүй байж мэднэ “Чи намайг бясалгаж эхэлсний дараа яагаад эм ууж болохгүй гээд байгаа юм бэ?” гэнэ. Хэрэв тэр үүнийг ухамсарлахгүй бол ойлгуулахад тийм ч амар асуудал биш. Бидэнд чамайг эм уухыг хориглосон хатуу дүрэм журам байхгүй. Би энгийн хүмүүст эм ууж болохгүй гэж хэлээгүй, зөвхөн бясалгагчдад эм уух, уухгүйн талаархи зарчмыг л зааж байна.

Манай Фа энэ дэлхий ертөнцөд бясалгалын зорилгоор дэлгэрч байгаа. Бясалгагч болгон Будда болох албагүй. Зарим хүмүүс маш их хичээнгүй, тууштай байдаг тул тэд Төгс гэгээрлийн зүг рүү хурдан урагшилж байна. Зарим хүмүүс тийм их хичээнгүй биш байж мэднэ, тэдний Төгс гэгээрэл рүү урагшлах явц маш удаан байх болно. Зарим хүн бясалгаж байгаа мэт харагддаг, гэхдээ

үнэхээр бясалгадаггүй, тэд итгэл үнэмшилтэй юм шиг харагддаг боловч үнэндээ итгэдэггүй. Тиймээс тэд Төгс гэгээрэлд хүрч чадахгүй байж магадгүй. Гэхдээ бясалгал их бага хэмжээгээр явагдаж л байвал, тэд ямар ч үр дүнгүй бясалгасан болохгүй нь лавтай. Хэрэв хэн нэгэн бясалгалд амжилтанд хүрэхгүй бол, энэ насандаа үр дүнд хүрч чадахгүй бол, дараагийн амьдралдаа яахыг нь харна, магадгүй тэр дараагийн амьдралдаа амжилтанд хүрч мэднэ. Эсвэл тэр цаашид бясалгахыг хүсэхгүй болж магадгүй, гэхдээ тэр энэ бүхний дараа, энэ Дафа-гаар зарим зууралдсан сэтгэлээ орхисон, Будда Фа-г сонссон, мөн бясалгасан болохоор энгийн хүнээс илүү сайн хүн болсон. Тэр дараагийн амьдралдаа адислал ивээл хүртэх боломжтой. Дараагийн амьдралдаа тэр магадгүй их хөрөнгөтэй чинээлэг хүн болно, эсвэл өндөр албан тушаалтан болж магадгүй юм. Эдгээр зүйлс зөвхөн адислал болж хувирна, тэгвэл тэр бясалгалд амжилтанд хүрч чадаагүй ч гэсэн дэмий хоосон бясалгаагүй гэсэн үг юм. Энэ бол зарчим. Чи бясалгагч хүний хувьд, өнөөдөр Фа-г сонсох боломжтой байгаа болохоор, та бүгд эцсээ хүртэл бясалгана гэдэгт найдаж байна. Будда Фа-г хүн бүр сонсох боломжгүй. Дашрамд, би АНУ-ыг маш онцгой газар гэж хэлнэ. Би хоёр жилийн өмнөөс Фа заахаа больсон, гэхдээ АНУ-д олон Хятад хүмүүс байдаг мөн Америкчуудын дунд ч олон сайхан сэтгэлтэй хүмүүсийг олж болно. Би тэднийг бас Фа олж аваасай гэж хүсч байна. Үнэндээ би системтэйгээр заахаа зогссон, зөвхөн тодорхой нөхцөл байдлын үед зааж байна. Ном аль хэдийн бэлэн болсон учраас хүн бүр номоо уншиж сурах боломжтой. Туслах төвүүд бас байгаа болохоор, та бүгд очиж хамтдаа бясалгалаа хийх боломжтой. Хүнд Буддын Фа-г сонсох хувь тавилан хэдэн мянган жилд нэг л удаа тохиодог бөгөөд зарим хүмүүст тэрхүү хувь ерөөл байхгүй байж магадгүй юм. Учир нь төрөл арилжих зургаан замын тойрогт хүн янз бүрийн амьтан, ургамал, бие бодь болон төрж болдог. Дахин хүн болж төрөхийн тулд, хэдэн зуу, хэдэн мянган жил шаардагддаг. Тэр хэдэн зуун, хэдэн мянган жилийн явцад чи бас зөв цагт хүн болж төрөх ёстой, тэгэхдээ чи энэ Фа-тай учирч болох газар төрөх ёстой, мөн чи үүнийг сонсох, энэ ангид хамрагдах боломжтой байхын тулд чи зөв цагт дэлхийд ирэх ёстой.

Мэдээжийн хэрэг, үүнийг хэрэгжүүлэхийн тулд олон, олон хувь ерөөлийн урьдчилсан тохироо байх шаардлагатай. Зөвхөн тийм тохиолдолд чи энэ Фа-г олж авч чадна. Энэ бол огт амар биш.

Миний зааж байгаа бол Буддын Фа. Хүн бүхэн энэ талаар тодорхой ойлголттой байгаа гэж бодож байна. Би энгийн хүмүүст Фа, зарчмуудыг зааж байгаа юм биш. Үүнээс гадна, миний ярьсан олон асуудлууд бол энгийн хүмүүсийн дунд хэзээ ч яригдаж байгаагүй, мөн энэ нь энгийн хүмүүсийн мэдлэгийн зүйл биш.

Эм уух талаар янз бүрийн бүс газруудад мэдэгдэхүйц анхаарал татсан асуудлууд гарч байгаа болохоор би энэ асуудлыг дахин авч үзсэн. Зарим хүмүүс Дафаг эвдэн сүйтгэхийг хүсч, эм уухгүй байх талаар "Бид үүгээр хичээллэж эхэлсэн л бол, эм уух хориотой" гэх мэтийн зүйл ярьдаг. Үнэндээ би чамайг эм уухыг хориглосон юм биш. Мэдээжийн хэрэг энд байгаа манай туслахууд ажлынхаа арга барилд болгоомжтой хандах хэрэгтэй, хэн нэгнийг эм уухгүй байхыг албадаж болохгүй. Бид зөвхөн зарчмыг нь сайтар тайлбарлаж өгнө. Хэрэв хэн нэгэн бясалгахыг хүсч байвал, тэр чадна. Хэрэв тэр бясалгахыг хүсэхгүй бол, хор уухаар шийдсэн бол, энэ нь энгийн хүний хэрэг юм. Түүний бодол өөрчлөгдөхгүй бол, хэн ч юу ч хийж чадахгүй. Бид зөвхөн хувь тавилангийн барилдлагын талаар ярина, хүмүүст сайн байхыг л зөвлөж чадна. Хүмүүст хүчээр тулгах нь бясалгал биш юм.

Би өөр нэг асуудлын талаар ярья. Би үдээс хойших бүх цагийг та нарт өгч байгаа болохоор намайг ярьж дууссаны дараа та бүхэн асуулт асууж болно, би хариулъя. Эх газрын Хятадад “Соёлын хувьсгал”-ын дараа төрсөн залуучууд Будда, Бодьсатва, Бурхдын талаар маш гүехэн ойлголттой байдаг. Миний зааж байгаа зүйл бол Будда Фа юм. Зарим хүмүүс энэ нь сайн гэдгийг мэддэг боловч тодорхой нэр томъёог ойлгодоггүй хэвээр байна. Тэд Буддын бясалгалын талаар маш бага мэдлэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл, тэдэнд Буддын бясалгалын талаар тодорхой ойлголт байхгүй.

Одоо би Будда Амиитаба болон Будда Шагжамүни нарын талаар товч ярья. Миний зааж байгаа зүйл бол Буддын судар номноос өөр. Миний зааж байгаа зүйлийг 2500 жилийн өмнө Будда Шагжамүни бас зааж байсан боловч тэр үеийн лам хуврагууд хойч үедээ уламжилж үлдээгээгүй юм. Будда Шагжамүни дэлхийгээс явснаас хойш 500 жилийн дараа л судрууд системтэйгээр эмхэтгэгдсэн. 500 жилийн өмнө Хятад яг Юань гүрний дунд үед байсан гэдгийг та нар мэднэ. Тэр үед Чингис хаан юу гэж хэлж байсныг өнөөдөр хэн мэдэх юм? Гэхдээ энэ бол эцсийн эцэст Будда Фа байсан. Энэ нь хэсэгчлэн ам дамжин уламжлагдаж ирсэн. Гэхдээ энэ нь Буддын айлдсан сургаалтай холбоотой элементүүд: цаг хугацаа, байршил, үйл явдлууд, утга санаа болон бараалхалт зэрэг нь ихэвчлэн алдагдсан, эдгээр нь одоо байхгүй болсон. Энэ тархах явцад Төгс гэгээрэлд хүрч чадаагүй бүх хүмүүс хүний сэтгэлгээнээсээ салаагүй байсан, тэд өөрсдийн үзэл бодлын зүйлсийг нэмж оруулах дуртай байснаас Буддын Фа-г өөрчилсөн. Тэд ойлгохгүй байсан хэсгүүдийг орхиж, аажмаар Будда, Бодьсадва, Бурхдыг хүмүүнтэй дүйцүүлсэн. Тэд санаанд нь нийцсэн болон ойлгож чадсан зүйлсээ л уламжилсан. Тэд өөрсдийнхөө сэтгэлгээнд таарахгүй аль эсвэл тэдний үзэл бодолтой нь нийцэхгүй зүйлсийн талаар ярих дургүй байсан, тиймээс тэдгээр хэсгүүд нь уламжлагдаагүй юм.

Эхлээд Будда Шагжамүни-гийн талаар ярья. Будда Шагжамүни бол бодит түүхэн хүн байсан. 2500 гаруй жилийн тэртээ эртний Энэтхэгт тэрээр бясалгагчдад өөрийн "Сахил, Самади, Гэгээрэл" гэсэн Буддын бясалгалын сахил санваарыг үлдээсэн. Буддын шашины хувьд, энэ бол өнөөгийн улс төрд автсан хүмүүсийн өгсөн нэр юм. Будда Шагжамүни шашныг хүлээн зөвшөөрөөгүй, тэр зөвхөн өөрийнхөө Дарма номоо, хүнийг гэгээрэлд хүргэж чадах Сахил, Самади, Гэгээрэл гэсэн бясалгах аргыг зааж байсан. Мэдээжийн хэрэг, үүнтэй холбоотой тодорхой зүйлс судруудад бичигдсэн байдаг тул би дэлгэрэнгүй ярихгүй. Будда Амиитаба "Сухавати" диваажинтай, Оточ Манал бурхан "Лиули" диваажинтай гэдгийг та бүгд мэднэ. Будда бүр тэнгэрийн диваажингаа удирддаг. "Фо" (Будда), "Пуса" (Бодьсадва), "Рулай"

(Татагата) бол Хятад хэлний нэршил юм. Тэнгэрт Татагата-г Фа хаан гэж нэрлэдэг бөгөөд өөрөөр хэлбэл тэр өөрийн тэнгэрийн хаант орныг удирддаг. Гэхдээ тэдний удирдах арга нь хүмүүсийн захиргааны арга хэрэгсэл, хууль тогтоомж шиг биш юм, тийм зүйл тэдэнд байдаггүй. Тэд зөвхөн нигүүлсэл, нинжин сэтгэлийн бодол санаан дээр түшиглэдэг. Тэнд байдаг бүх зүйл сайн. Зөвхөн энэхүү шалгуурт нийцэж байж л тэр диваажинд орж болно. Тиймээс Будда болгонд өөрийн удирдах диваажин байдаг. Гэхдээ урьд өмнө Будда Шагжамүни ямар диваажинг удирддагийг хэн ч сонсоогүй, Будда Шагжамүни хаанаас гаралтай болохыг, Будда Шагжамүни-гийн диваажин хаана байдгийг хэн ч мэддэггүй байсан. Зарим лам нар Будда Шагжамүни Саха диваажинд байдаг гэдэг байсан. Гэхдээ би та нарт хэлж өгье: Саха диваажин хаана байдаг вэ? Энэ бол манай Гурамсан ертөнцийн хүрээнд байдаг. Яаж Буддын диваажин энд байж болох юм? Ийм заваан газар уу! Хүн бүр эндээс холдохыг хүсдэг биз дээ, яаж энд Буддын диваажин байж болох юм? Лам нар ч энэ талаар тайлбар өгч чадаагүй, энэ нь шашинд ч бичигдээгүй юм. Үнэндээ Будда Шагжамүни маш өндөр түвшнээс ирсэн. Энэ сансар ертөнц бол асар уудам. Хэсэг хормын дараа би энэ бүтцийн талаар ярья, сансар ертөнцийн бүтцийг ярьж өгье. Будда Шагжамүни бууж ирэхээсээ өмнө байж байсан хамгийн доод түвшин нь зургаа дахь давхаргын орчлон ертөнц байсан, тэр түвшнээс шууд хүн болж төрөл олсон. Энэ бол зургаа дахь давхаргын тэнгэр биш, харин зургаа дахь давхаргын орчлон ертөнц юм. Хормын дараа би энэ сансар ертөнц ямар өргөн цар хүрээтэй болохыг тайлбарлах болно.

Тэр зургаа дахь давхаргын орчлон ертөнцөд тэнгэрийн хаант оронтой. Тэр тэнд “Дафан диваажин” хэмээх тэнгэрийн хаант орныг байгуулсан. Өөрөөр хэлбэл Будда Шагжамүни Дафан диваажингаас шууд хүний ертөнцөд төрөл олж буусан юм. Дарма номоо зааж хүмүүст аврал үзүүлэхийн тулд, шавь нартаа аврал үзүүлэх гэж тэрээр Дафан диваажингаас хүний ертөнцөд төрөл олж төрсөн. Будда Шагжамүни-гээр заалгаж аврагдах шавь нар нь наад зах нь зургаа дахь давхаргын орчлон ертөнц рүү эсвэл түүнээс дээш бясалгах ёстой байсан юм. Тэд тийм өндөрт бясалгах ёстой

байв. Тийм ч учраас Будда Шагжамүни бууж ирсэн цагаасаа хойш шавь нараа олон төрөл дамжин бясалгахыг нь харсаар байгаа, диваажиндаа хэзээ ч буцаж очоогүй юм. Гурамсан ертөнцөд Дафан дээд тэнгэр хэмээх газар байдаг бөгөөд тэр тэнд байдаг. Дафан дээд тэнгэр бас түүгээр нэрлэгдсэн. Тэрээр Дафан диваажингаас ирсэн болохоор түүнийг Дафан дээд тэнгэр гэж нэрлэсэн. Тэр тэндээс шавь нараа харж байдаг. Түүний шавь нарт бүгдэд нь өгөгдсөн тэмдэг байдаг. Тэрбээр тэднийг 卐 “хас” тэмдэгээр тэмдэглэсэн. Тэд бүгд түүний шавь гэж тэмдэглэгдсэн байдаг. Дээд түвшнээс харахад, хэн нь Будда Шагжамүни-гийн шавь, хэн нь биш гэдгийг нэг хараад л шууд хэлж чадна. Тэд өндөр түвшинд бясалгах ёстой, Будда Шагжамүни тэднийг тийм өндөр түвшинд аврах хүсэлтэй, тэд нэг амьдралдаа бясалгаж амжилтанд хүрч чадахгүй. Тиймээс тэд амьдралаас амьдралд хоёр мянга таван зуун жилийн турш дахин дахин бясалгаж ирсэн. Одоо бол сүүлчийн хугацаа, тэд төгс гэгээрэлд хүрэх ёстой юм. Энэ насандаа тэд төгс гэгээрэлд хүрсний дараа, тэрээр бүх шавь нараа дагуулж явна, бүгд Саха диваажингаас явах болно. Фа-г олж авсан манай Дафа-гийн шавь нарын дунд, Шагжамүни-гийн тэмдэг тавьсан олон шавь нар бий. Гэхдээ Шагжамүни-гийн тэмдэг тавьсан шавь нарын ихэнх нь лам хуврагууд байдаг, мөн энгийн хүмүүсийн дунд ч шавь нар нь бас байдаг. Энгийн хүмүүсийн дунд байдаг ихэнх нь бидний энэ Фа-г аль хэдийн олж авсан. Үнэндээ, бид үүнийг энэ хүртэл ярьсан учраас, миний энэ Фа-г зааж байгаа нь, та нар манай Фалуны диваажинд заавал очно гэсэн үг биш гэдгийг хэлмээр байна. Миний заан дамжуулж байгаа зүйлс бол бүхэл сансар ертөнцийн зарчим юм. Би ийм асар том зүйлийг зааж байгаа. Тэд (сансар ертөнцийн амь бодиуд) бүгдээрээ мөн энэ Фа-г олж авахыг хүсдэг. Шинэ сансар ертөнц аль хэдийн бүрэлдсэн, Фа сансар ертөнцийг ариусган цэвэрлэж байгаа, хэн ч сансар ертөнцийн Фа-д уусч байж л, тэнд буцаж очих боломжтой. Үүнийг Будда Шагжамүни шавь нартаа зориулж эрт дээр үеэс системтэйгээр төлөвлөн зохион байгуулсан зүйлс юм, энэ өдрийн талаар тэр мэдэж байсан. Олон янзын диваажингийн болон бусад ариун бясалгалын үүдний шавь нар Дафа-гаар Фа-г олж авч байгааг би мэднэ. Будда Шагжамүни-гийн шавь нарын ихэнх нь Хан нутагт байдаг. Энэтхэгт хэн нь ч

байхгүй. Гэхдээ тэдний хэд нь, маш цөөхөн зарим нь дэлхийн өөр өөр газруудаар тарсан. Ихэнх нь Хан нутагт байдаг. Хан бүс нутаг бол эх газрын Хятад юм.

Дөнгөж сая би Будда Шагжамуни болон түүний шавь нарын нөхцөл байдлын талаар товч дурдлаа. Одоо би Будда Амитаба-гийн тухай ярья. Хүмүүс Будда Амитаба-гийн тухай ярихдаа, бүгд “Сухавати” диваажин гэж байдгийг мэддэг. Сухавати диваажин хаана байдаг вэ? Будда Амитаба гэж хэн бэ? Будда Амитаба-гийн тухай тайлбарлан бичсэнийг Буддын шашны судруудаас олж болох учраас би энэ хэсгийг ярихгүй. Судруудад бичигдээгүй хэсгийн талаар би ярих болно. Сансар ертөнцийн хэсэгчилсэн бүтцийн талаар Будда нарын хэлсэн зүйлийг хүмүүс тарааж байсан, үүнд Сүмэрү диваажин гэдэг газар байдаг тухай яригддаг, энэ нь Сүмэрү уулын тухай яриа юм. Манай одоогийн дэлхий болон Гурамсан ертөнцийн хүрэн доторхи ба түүнээс гадна орших сансрын эрхсүүд нь Сүмэрү уулын өмнө зүгт байрладаг, мөн үүнийг Жамбуу-двипа гэдэг. Дэлхий бол энэ Сүмэрү уулын өмнө зүгт байдаг. Зарим хүмүүс үүнийг ойлгохыг хичээдэг, “Сүмэрү уул нь Гималайн нуруу мөн үү? Тэр үеийн Энэтхэг Жамбуу-двипа байсан уу?” гэж асуудаг. Эдгээр нь өөр асуудал юм. Тэр бол Будда. Тэр дэлхийн ойлголтын үүднээс ярьдаггүй, Бурханы үүднээс зарчмуудыг заадаг. Түүний сэтгэлгээний эх сурвалж нь хүнийхээс ялгаатай.

Энэ Сүмэрү уул нь үнэхээр оршдог. Тэгвэл хүмүүс яагаад үүнийг харж чаддаггүй вэ? Яагаад үүнийг дурангаар ч харж чадахгүй байна вэ? Энэ нь яагаад гэвэл хамгийн том молекулын давхаргын ширхгүүдээс тогтдоггүй. Би та нарт хэлье: Молекулуудаас бүрдсэн ширхгүүд-тэдгээр атомуудаас бүрдсэнийг хэлээгүй байна-тэр ч атугай тэдгээр молекулуудаас тогтсон ширхгүүдээс бүрдсэн бие бодь болон бидний хамгийн гадаргуйн давхаргын ширхгүүдээс нэг давхаргаар жижиг ширхгүүдээс тогтсон бие бодь хүртэл хүмүүст харагдахгүй. Харин Сүмэрү уул нь атомуудаас тогтдог учраас хүмүүс үүнийг харж огт чадахгүй. Гэвч саяхан одон орон, сансар судлалын салбарт ажилладаг хүмүүс орчлон ертөнцөд хичнээн олон харагдахуйц галактикууд байдаг ч

мөн галактикууд оршихоо больдог газар бас байдгийг илрүүлсэн. Галактикууд энд тэндгүй хаа сайгүй байдаг, Тэнгэрийн заадас шиг галактикууд маш олон байдаг. Гэхдээ тодорхой газарт хүрээд юу ч байхгүй болдог, зүсээд тасалсан мэт болдог. Тэд үүнийг “Сансрын хана” гэж нэрлэдэг. Яагаад ийм байдгийг тэд тайлбарлаж чадахгүй. Яагаад тэнд галактикууд байдаггүй вэ? Үнэндээ, тэдгээрийг Сүмэрү уул хаачихдаг, яагаад гэвэл тэр уул нь асар том юм. Энэ нь хэр том бэ? Түүний орой нь хоёр дахь давхаргын орчлон ертөнцийн талд хүрдэг, энэ нь бидний жижиг орчлон ертөнцөөс давдаг. Энэ бол үнэхээр асар том. Ийм асар том уул нь хүний төсөөллөөс давсан зүйл. Хүмүүс бусад талуудыг нь харах бүр ч боломжгүй юм. Дэлхий бол ийм л жижигхэн бөмбөлөг, гэхдээ та нар Бээжинг дэлхийн нөгөө талаас харахыг хүсвэл боломжгүй байдаг биз дээ. Энэ бол асар том уул, чи үүнийг хир том болохыг нь төсөөлөхийн ч аргагүй. Тэрээр мөн Сүмэрү уулын зарим талд өөр өөр диваажин байдаг гэж хэлсэн. Бид энэ талаар хэт их ярихаа больё.

Тэгвэл яагаад ийм уул байдаг юм бэ? Энэ Сүмэрү уулын талаар ярилцъя. Энэхүү Сүмэрү уул бол үнэндээ Будда Амитаба, Бодьсадва Гуанинь (Авалокитесвара), Бодьсадва Дашиджи (Махаастхаама-праапта) нарын хэлбэр дүрсний илрэл гэж би та нарт хэлье. Үүнийг хэлбэр дүрс нь гэж хэлэхэд бүрэн оновчтой биш юм. Тэд Будда болохоор хүний хэлбэртэй байдаг. Тэд мөн хэлбэрт орж, эсвэл матери болон сарнин задарч чаддаг ч хэлбэр дүрстэй байдаг. Тэд хувьсах байдлаар матери болон задарч чаддаг. Хүмүүс Буддаг харж чаддаггүй болохоор, Буддуудад бие байдаггүй гэж хэлдэг. Тэдний бие нь атомуудаас тогтдог учраас мэдээжийн хэрэг та нар тэдний биеийг харж чадахгүй, тиймээс тэдэнд бие байхгүй гэж хэлэх нь аргагүй юм. Энэ Сүмэрү уул нь атомуудаас тогтдог болохоор бидний хүний нүд харж чадахгүй. Гэхдээ энэ нь Будда Амитаба, Бодьсадва Гуанинь, Бодьсадва Дашиджи нарыг төлөөлдөг гэсэн үг юм. Энэ Сүмэрү уул нь нэг биш, гурван уул юм. Нэмж дурьдахад, энэ нь бас хөдөлж байдаг. Зөвхөн бидний энэ материаллаг орон зай дахь зүйлс л үхмэл эсвэл хөдөлгөөнгүй мэт харагддаг, бусад бүх орон зайд байдаг зүйлс хөдөлж байдаг. Та нарын мэдэх молекулууд хөдөлж байдаг, атомууд ч адилхан, бүх

зүйл хөдөлж байдаг, электронууд атомын цөмийг тойрон эргэдэг, бүх зүйл хөдөлгөөнд байдаг, бүх матери хөдөлгөөнд оршдог. Тиймээс Сүмэрү уул заримдаа шулуун хэлбэртэй болдог, заримдаа гурвалжин хэлбэртэй болдог, өөрчлөгдөж байдаг. Хүмүүс үүнийг өөр өнцгөөс юмуу эсвэл өөр төлөв байдлуудад харвал, түүний жинхэнэ илрэлийг харахгүй байж магадгүй. Хэрэв энэ нь шулуун нэг эгнээнд байвал, чи үүнийг уул гэж харах болно. Урьдын зарим бясалгагчид үүнийг харж чаддаг байсан боловч, тэд өөр өөрөөр дүрсэлсэн байдаг. Яагаад гэвэл үүний яг тодорхой төлөв байдлыг нь хараагүйгээс юм. Энэ нь Будда Амитаба, Бодьсадва Гуанинь, Бодьсадва Дашиджи-гийн билэг тэмдэг юм бол ямар учиртай вэ? Хүмүүсийн ярьдаг “Сухавати” диваажин нь Сүмэрү уулын яг дотор нь байдаг. Гэхдээ энэ уул нь бидний харж чадах материйн талаархи хүний ойлголттой адилгүй. Сүмэрү уулын доор тэр чигтээ ус байдаг. Цаг бага байгаа учраас би энэ хүртэл л ярья.

Би цааш, сансар ертөнцийн орон зайн бүтцийн талаар ярья. Сансар ертөнц хэр том бэ? Үүнийг хүний хэлээр тайлбарлахад хэцүү, учир нь хүний хэл хангалтгүй, тайлбарлаж болох байсан ч гэсэн та нарын оюун ухаан үүнийг агуулж чадахгүй бөгөөд та нар үүнийг ойлгож чадахгүй байх байсан. Энэ бол үнэхээр хязгааргүй. Энэ бол маш уудам бөгөөд ерөөсөө санаанд багтамгүй, Бурхдад хүртэл энэ нь төсөөлөхийн аргагүй байдаг. Тиймээс ямар ч Будда, Бумба эсвэл Бурхан Сансар ертөнцийн хэр том болохыг тайлбарлаж чадахгүй. Миний сая хэлсэнчлэн, бидний ерөнхийд нь ойлгодог орчлон ертөнц бол үнэндээ жижиг орчлон ертөнцийн цар хэмжээ юм. АНУ-д хийсэн сүүлчийн аяллынхаа үеэр би 2.7 тэрбум гаруй Тэнгэрийн заадастай төстэй галактикуудын цар хэмжээний талаар дурьдаж байсан, ойролцоогоор тийм хэмжээтэй, 3 тэрбумаас бага нь нэг орчлон ертөнцийг бүрдүүлдэг. Мөн энэ орчлон ертөнц нь гадаргуй бүрхүүлтэй ба хил хязгаартай. Энэ бол бидний ихэвчлэн авч үздэг ертөнц юм. Гэхдээ энэ орчлон ертөнцөөс гадна алслагдсан газруудад бусад орчлон ертөнцүүд оршдог. Тодорхой уудам орчлонд үүнтэй адил гурван мянган орчлон ертөнц оршдог. Эдгээр гурван мянган орчлон ертөнцийн гадна мөн гадаргуй бүрхүүл байдаг бөгөөд хоёр дахь давхаргын

орчлон ертөнц бүрэлдэн тогтдог. Энэхүү хоёр дахь давхаргын орчлон ертөнцийн цаана энэ хоёр дахь давхаргын орчлон ертөнцийн хэмжээтэй адил ойролцоогоор бас гурван мянга орчлон ертөнц оршдог. Тэдгээрийн гадуур мөн л гадаргуй бүрхүүл байдаг бөгөөд тэдгээр нь гурав дахь давхаргын орчлон ертөнцийг бүрдүүлдэг. Яг, жижиг ширхэг хэсгүүд атомын цөмийг бүрдүүлдэг, атомын цөмүүд нь атомуудыг бүрдүүлдэг, атомууд нь молекулуудыг бүрдүүлдэгтэй адил юм. Энэ нь тухайн систем доторхи бичил ширхгүүд нь дараах арай том ширхгүүдийг бүрдүүлдэгтэй адил юм. Миний дүрсэлсэн орчлон ертөнц бол зөвхөн энэ нэг системийн хүрээнд тайлбарлах аргачлал юм. Үүнийг хүний хэлээр дүрслэх ямар ч арга байхгүй, хүний хэл үүнийг тодорхой илэрхийлж чадахгүй. Нэг нөхцөл байдал нь ийм байна. Гэхдээ маш олон, маш олон системүүд оршдог, маш олон, тоо томшгүй олон атомууд молекулуудыг бүрдүүлдэгтэй адилаар бүх сансар ертөнц даяар тархсан системүүд байдаг. Энэ сансар ертөнцөд манай жижиг ертөнцийн хэмжээтэй хичнээн орчлон ертөнц байгааг хэлж чадах уу? Хэн ч тодорхой хэлж чадахгүй. Дөнгөж сая би хоёр дахь давхаргын орчлон ертөнц, гурав дахь давхаргын орчлон ертөнцийн талаар ярьлаа, Будда Шагжамүни зургаа дахь давхаргын орчлон ертөнцөөс ирсэн гэж хэлсэн. Энэ бол зөвхөн энэ нэг системийн талаар, иймэрхүү системийн тухайд л ярьсан юм. Жижиг ширхгүүд нь арай том ширхгүүдийг, том ширхгүүд нь бүр том ширхгүүдийг бүрдүүлдэг шиг, энэ нь нэг системийн хүрээнд доторхи л зүйл юм. Гэхдээ ширхгүүдийн энэ ганц системээс гадна маш олон систем байдаг. Янз бүрийн давхаргад орших тоолшгүй олон тооны ширхэг хэсгүүд сансарын биет даяар тархсан байдаг.

Сансар ертөнц бол маш нарийн төвөгтэй юм. Би Швейцарид зохион байгуулагдсан семинар дээр энэ талаар илүү тодорхой ярьсан. Би наян нэгэн давхарга орчлон ертөнцийн тухай ярьж байсан. Үнэндээ наян нэгээс илүү давхарга байдаг, тэдгээрийг хүний тоогоор тоолох боломжгүй юм. Хүний хамгийн том тоо бол “жао” (их наяд) юм. Буддын хэрэглэдэг хамгийн том тоо бол калпа юм. Нэг калпа нь хоёр тэрбум жилтэй тэнцдэг, хоёр тэрбум жил нь

нэг калпа болдог. Хичнээн давхарга орчлон ертөнц байгааг хүн калпагаар ч тоолж чадахгүй, хичнээн давхарга тэнгэр байгааг биш, харин хичнээн давхарга орчлон ертөнц байгааг, ийм л агуу юм. Хүн төрөлхтөн бол үнэхээр өчүүхэн. Урьд би дурьдаж байсан, Дэлхий бол юу ч биш, нэг ширхэг хумхын тоос л юм, тун өчүүхэн. Энэ өргөн уудам хүрээнд тоолж баршгүй, маш нарийн бүтэцтэй орон зайнууд оршдог. Эдгээр орон зайнуудын бүтэц ямар байдаг вэ? Би үүнийг өнгөрсөн удаа бас тайлбарласан. Манай хүн төрөлхтөн орон зайн ямар давхаргад амьдардаг вэ? Бид молекулын ширхгүүдийн хамгийн том давхаргаас бүрдэх гадаргуйн матери биет дээр амьдардаг, бид молекулууд болон гаригуудын хооронд амьдардаг, гариг бол бас нэг ширхэг, энэ өргөн уудам сансар ертөнц дотор энэ нь бас л нэг өчүүхэн хумхын тоос юм. Тэнгэрийн заадас галактик ч гэсэн бас өчүүхэн хумхын тоос юм. Энэ орчлон ертөнц, миний саяхан дүрсэлсэн жижиг ертөнц бол мөн адил өчүүхэн хумхын тоос юм. Бидний хүний нүдээр харж чадах хамгийн том ширхгүүд бол гаригс, мөн хүн төрөлхтөнд харагдах хамгийн жижиг ширхэг бол молекулууд юм. Хүмүүс бид молекулууд болон гаригс ширхгүүдийн хооронд оршдог. Энэ орон зайд чи үүнийг өргөн уудам гэж боддог, өөр өнцгөөс харахад энэ нь үнэндээ туйлын бачуу бөгөөд өчүүхэн юм.

Өөр өнцгөөс авч ярья. Атомууд ба молекулуудын хооронд орших зай орон зай биш гэж үү? Үүнийг ойлгоход хэцүү байж магадгүй. Өнөө үед эрдэмтэд атомаас молекул хүртэлх зай нь 200 мянган атомуудыг жагсааж тавьсантай тэнцүү гэж мэддэг болсныг хэлье. Жижиг биетүүдийн хувьд ширхгүүд нь илүү жижиг, тэдний ерөнхий эзлэхүүн нь илүү том байдаг, учир нь тэдгээр нь тухайн нэг давхаргад хавтгай үүсгэдэг ба тусгаарлагдсан цэгүүд биш юм. Молекулууд нь үнэхээр том юм. Матери-биетийн бөөмс нь том байх тусам эсвэл ширхэг томрох тусам тэдгээрийн орон зайн эзлэхүүн нь бага байдаг, тэдний орон зайн ерөнхий эзлэхүүн нь жижгэвтэр байдаг. Хэрэв чи тэр орон зайд орвол, үүнийг өргөн уудам болохыг олж мэдэх болно. Мэдээжийн хэрэг, чи тэр орон зайд орохын тулд, тухайн байдалд нийцэж байх ёстой. Хэрэв чи үүнийг хүний бодлоор, хүний сэтгэлгээгээр, бидний өмнө буй

материаллаг ертөнцийг хүмүүс хэрхэн үздэг шиг ойлговол, энэ нь чамд хэзээ ч ойлгогдохгүй, мөн чи тэр төлөвт нэвтэрч чадахгүй. Хүн төрөлхтөн өөрсдийн шинжлэх ухааныг маш өндөр хөгжсөн гэж үздэг. Энэ нь өрөвдөлтэй! Молекулын орон зайг огт нэвтэрч чадахгүй байхад, бусад орон зайг харж чадахгүй байхад хүмүүс өөрсдөдөө сэтгэл хангалуун байдаг, атомуудаас тогтсон орон зайг бол бага төдий ч гэсэн харж чадахгүй. Энэ бол орон зайн системүүдийн өргөн ангилал гэж би та нарт хэлье: Атомууд болон атомын цөмийн хооронд орон зай байдаг, атомын цөм ба кваркуудын хооронд орон зай байдаг, кваркууд болон нейтринонуудын хооронд мөн орон зай байдаг. Улмаар хамгийн анхдагч эх үүсвэр матери хүртэл үргэлжлэх давхаргуудыг тоолох гэвэл хүмүүсийн тоогоор, тэр ч байтугай Буддын хэрэглэдэг калпа тоогоор ч тоологдошгүй олон юм.

Хэрэв хүн төрөлхтөн материйг жинхэнэ утгаар нь ойлгохыг хүсвэл зөвхөн өнөөгийн хүний мэдлэгийн хүрээнд л үүнийг ойлгож чадна. Хүмүүн сансар ертөнцийн хамгийн үндсэн матери юу болохыг хэзээ ч мэдэж чадахгүй бөгөөд хэзээ ч судалж шинжиж чадахгүй. Тэгэхээр энэ сансар ертөнц хүн төрөлхтөнд үүрд оньсого хэвээр үлдэнэ. Мэдээжийн хэрэг, дээд түвшний амь бодиуд хэзээ ч мэдэхгүй гэсэн үг биш, энгийн хүмүүсийн хувьд энэ сансар ертөнцийг мэдэх ямар ч арга байхгүй, харин бясалгагчид мэдэж болно, зөвхөн бясалгалаар. Хүн төрөлхтөн техник технологийн аргаар хэзээ ч Буддын түвшин дэх агуу чадварт хүрч чадахгүй, мөн энэ олон орон зайн давхаргуудыг болон орчлон ертөнцүүдийг харж чадахгүй. Хүмүүс янз бүрийн сэтгэл хөдлөл, хүсэл сонирхолтой байдгаас янз бүрийн зууралдсан сэтгэлтэй. Хэрэв тэд Буддын түвшинд үнэхээр хүрэх байсан бол оддын дайн эсвэл сансрын дайн дэгдэх байсан. Гэхдээ Бурхад хүн төрөлхтөнд үүнийг хийхийг зөвшөөрөхгүй. Тийм учраас шинжлэх ухаан тодорхой түвшинд хүрэхэд хүн төрөлхтөнд аюултай болох нь гарцаагүй юм. Хүний ёс суртахуун тэр өндөр түвшинд хүрэхгүй тул хүн төрөлхтний соёл иргэншил устгагддаг. Энэ бол шударга бус зүйл биш, яагаад гэвэл хүмүүс өөрсдөө шаардлагад нийцэхгүй болсон, мөн хүний ёс суртахуун нь алхаатайгаа хөл нийлж чадахгүй байгаагаас юм.

Харин эсрэгээр, хэрэв хүний ёс суртахуун алхаатайгаа хөл нийлж байвал хүмүүс Бурхан болж, судлан шинжлэх гэхийн хэрэггүй болно, тэд нүдээ нээгээд л бүхнийг шууд гүйлгээд л харах байсан. Сансар ертөнц ийм л байдаг. Хэрэв чи энэ талаар мэдэхийг хүсвэл, энэ давхаргаас гарах хэрэгтэй.

Миний сая хэлсэн бол янз бүрийн хэмжээтэй том ширхгүүдээс бүрдсэн ертөнцүүдийн талаар юм. Үнэндээ эдгээрээс хавьгүй олон байдаг. Молекулын хамгийн ойрын орон зай дотор ч хүний нүдэнд үл үзэгдэх олон, олон орон зайнууд оршдог. Миний хэлсэнчлэн, молекулуудаас бүрдэх хамгийн том ширхгүүд бол хүмүүс бидний байдаг хамгийн гаднах гадаргуйг бүрдүүлэгч матери юм. Ган, төмөр, мод, хүний бие, хуванцар, чулуу, хөрс, тэр ч байтугай цаас гэх мэт. Хүн төрөлхтний харж байгаа эдгээр бүх зүйлс нь хамгийн том молекулын давхаргаас бүрдсэн хамгийн том ширхгүүдийн давхаргаас тогтдог. Эдгээрийг харж болно. Хамгийн том ширхгүүдийн давхаргаас арай бага хэмжээтэй молекулын ширхгүүдээс тогтсон орон зайг чи харж чадахгүй. Мөн эдгээр молекулууд нь бүр жижиг ширхгүүдээс тогтсон орон зайг бүрдүүлж чадна. Гадаргуйн хамгийн жижиг ширхгүүдээс хамгийн том ширхгүүд хүртэл бүгд молекулаас тогтдог бөгөөд энэ хооронд олон, олон орон зайн давхаргууд оршдог. Өөрөөр хэлбэл молекулууд өөр өөр хэмжээтэй ширхгүүдийг бүтээдэг бөгөөд улмаар туйлын нарийн төвөгтэй өөр өөр молекулын орон зайнуудыг үүсгэдэг. Хэн нэгэн гэнэт алга болоод, дараа нь өөр газар гэнэт гарч ирэхэд хүмүүс итгэдэггүй. Хэдийгээр түүний бие нь молекулаас тогтсон ч гэсэн тэдгээр нь маш нарийн ширхэгтэй бол (үүнд бясалгалын замаар хүрч болно) тэр энэ орон зайнаас цааш гарч чаддаг. Тэр гэнэт алга болоход чи түүнийг харж чадахгүй, дараа нь тэр хаа нэгтээ гэнэт гарч ирдэг. Энэ бол маш амархан.

Дөнгөж сая би, орон зайнуудын бүтцийг тайлбарлалаа. Би энэ талаар өнгөрсөн удааг бодвол илүү дэлгэрэнгүй ярилаа. Би хүмүүст хэтэрхий их зүйлийг хэлж болохгүй, тэд тийм их зүйлийг мэдэж болохгүй. Миний та нарт хэлсэн бүх зүйлийг хүмүүс судлан

шинжлээд ч олж мэдэж чадахгүй. Хүн төрөлхтний орчин үеийн шинжлэх ухаан үнэн хэрэгтээ буруу суурин дээр хөгжсөн, орчлон ертөнц, хүн төрөлхтөн, амьдралын талаар буруу ойлголтоор явж ирсэн. Тиймээс бясалгалын орчлонд, бясалгагчид бид өнөөгийн шинжлэх ухаантай огт санал нийлдэггүй, үүнийг алдаа гэж үздэг. Мэдээжийн хэрэг, энгийн хүмүүс бүгд энэ замаар сурч боловсорсон, энэ нь маш олон салбарт хуваагдсан, та бүгд өөр өөрсдийн салбарт нилээдгүй амжилтанд хүрсэн. Гэхдээ үүний суурь нь буруу юм. Тиймээс хүмүүс та нарын ойлголт үнэнээс үргэлж хол байх болно.

Хүн төрөлхтөний шинжлэх ухааны ойлголт нь үргэлж тэмтрэх явцтай байсан. “Сохор хүн зааныг тэмтрэн хэмжих” гэсэн ёгт үг байдаг, энэ шинжлэх ухаан өнөө үед үүнтэй л адилхан. Энэ нь зааны зөвхөн гуя эсвэл хошуунд нь хүрчихээд л шинжлэх ухаан гэж энэ юм гэж хэлдэг. Үнэн хэрэгтээ энэ нь бүх үнэнийг олж харж чадахгүй. Би яагаад үүнийг сая хэлэв? Одоо хүн төрөлхтөн хувьслын замаар хүн үүссэн гэж боддог, гэхдээ хувьслын онол огт таарахгүй. Бясалгалын орчлон дахь бидэнд хүмүүс өөрсдийгөө доромжилж байна гэж санагддаг. Хүмүүс өөрсдийгөө сармагчинтай хамааруулдаг, энэ нь инээдтэй санагддаг. Хүн хувьслын замаар огт үүсээгүй. Дарвин хувьслын онолоо гаргахад энэ нь хоосон завсраар дүүрэн байсан, хамгийн том алдаа нь сармагчингаас хүн, эртний амьдралаас орчин үеийн амьдрал хүртэлх хувьслын завсрын үеүд нь байхгүй байсан, зөвхөн хүний хувьд ч биш бас бусад амь бодь, амьтдын хувьд ч мөн адил. Үүнийг юу гэж тайлбарлах вэ? Үнэндээ, хүн төрөлхтөн өөр өөр түүхийн цаг үед өөр өөр амьдралын төлөвтэй байсан. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн амьдрах орчин нь тухайн цаг үеийн хүмүүст нийцсэн байдаг.

Энэ сэдэв дээр ирсэн болохоор, би өнөөгийн хүмүүсийн үзэл бодлын талаар бага зэрэг ярья. Ёс суртахууны доройтлын улмаас, олон ойлголт, ухагдхуунд тодорхой өөрчлөлт гарсан. Урьд өмнө олон зөнч мэргэд тодорхой цаг үед хүмүүс буг чөтгөр шиг харагдах болно гэж хэлсэн. Чи тэдний үсээ хэрхэн улаан өнгөөр

буддаг, эсвэл толгойныхоо үсийг хоёр талаас нь халзалж хусаад зөвхөн голд нь залаа үс үлдээдгийг нь харж болно. Бас тодорхой цаг үе болоход хүн нохойноос дор үзэгдэх болно гэж хэлсэн байдаг. Олон хүмүүс нохойдоо өөрийн хүү, үр хүүхэд шигээ ханддаг, сүүгээр хооллож, брэндийн хувцсаар хувцаслаж, тэргэнд суулган түрж, “миний хүү” гэж дууддаг. Тэгэхэд олон хүн гудамжинд хоол гуйж байдаг, би ч бас тийм хүмүүстэй тааралдаж байсан, АНУ-д ийм хүмүүсийг харж болно. Тэд гараа сунган "25 цент өгөөч" гэдэг. Тэд үнэхээр нохойноос дор юм. Гэхдээ дэлхий дээр хүн байгаагүй бол юу ч байхгүй байх байсан гэж би та нарт хэлж чадна. Хүн байгаа учраас эдгээр бүх зүйлс дэлхий дээр оршиж байна. Бүх амьтад, амьд зүйлс, ургамал нь хүнээс болж бүтээгдсэн, хүнээс болж устаж үгүй болдог, хүнээс болж үүссэн, мөн хүмүүст ашиглагддаг. Хүн байхгүй бол юу ч байхгүй. Мөн төрөл олох зургаан замын тойрог нь хүнээс болж оршдог. Дэлхий дээрх бүх зүйлс хүмүүст зориулагдаж бүтээгдсэн. Өнөө үед эдгээр бүх ойлголтууд нь урвуугаар эргэж байна. Амьтад яаж хүнтэй дүйцэж болох юм бэ?! Өнөө үед амьтад хүний биед шүглэж эзэн нь болж байна, тэнгэр үүнийг тэвчихгүй! Үүнийг яаж хүлээн зөвшөөрч болох юм бэ? Хүн бол хамгийн аугаа, тэд бясалгалаар Бурхан эсвэл Будда болж чадна. Үүнээс гадна, бүх хүмүүс өндөр түвшнээс ирсэн, харин эдгээр олон амь бодийн ихэнх нь энд бий болсон, Дэлхий дээр бүтээгдсэн. Би энэ асуудлыг урьд нь ярьж байсан.

Миний түрүүнд хэлсэн хувьслын онолын зүйл хэзээ ч байгаагүй гэж бид үздэг. Он удаан жилүүдийн туршид хүн төрөлхтөн олон удаа өөр өөр соёл иргэншлийн үеүдийг туулж ирсэн. Хүний ёс суртахуун доройтох бүрт соёл иргэншил нь устгагдаж үгүй болдог байсан. Эцэст нь маш цөөхөн хүн амьд үлддэг. Тэд өмнөх соёл иргэншлээс бага зэрэг соёл уламжлалыг өвлөн үлдэж, өөр нэг чулуун зэвсгийн үеийг туулж цааш хөгждөг. Чулуун зэвсгийн үе нь зөвхөн нэг үеэр хязгаарлагдахгүй, маш олон чулуун зэвсгийн үеүд байсан. Өнөө үеийн эрдэмтэд зарим асуудалтай тулгарсан: Археологийн олон олдворууд зөвхөн нэг үеийнх биш байсан. Тэдгээрийг хувьслын онолд нийцүүлэх гэж

оролдоход, тэд бодит баримтын өмнө тайлбар өгч чаддаггүй. Энэ дэлхий дээрх хүмүүс, өөрөөр хэлбэл янз бүрийн түүхэн үеийн хүмүүс өөр өөр цаг үеийн соёлын дурсгалт зүйлсийг уламжлан үлдээсэн болохыг бид олж мэдсэн. Орчин үеийн хүмүүс бүгд эртний Египетийн пирамидуудыг Египетчүүд барьсан гэж ярьдаг. Гэхдээ тэдгээр нь өнөөгийн Египетчүүдтэй ямар ч холбоо байхгүй. Энэ бол хүн төрөлхтөн, улс үндэстнүүд өөрсдийн түүхийн талаар буруу ойлголттой байдаг гэсэн үг юм. Пирамидууд ба Египетчүүд хоорондоо огт хамааралгүй. Тэдгээр пирамид нь эртний соёл иргэншлийн үед баригдсан бөгөөд эх газрын хавтгай солигдох үеэр усан дор живсэн юм. Соёл иргэншил даган бий болоход, мөн шинэ тивүүд үүсэхэд тэдгээр нь усны гүнээс гарч ирсэн. Тэр бүлэг хүмүүс аль эрт үгүй болж, хожим нь өнөөгийн Египетчүүд ирсэн юм. Египетчүүд тэдгээр пирамидын онцлогийг олж мэдсэний дараа иймэрхүү жижиг пирамидуудыг барьсан. Тэд пирамид дотор цогцсыг хадгалахад их тохиромжтой болохыг олж мэдсэн, тиймээс дотор нь авс тавьдаг болсон. Зарим нь шинээр баригдсан, зарим нь аль эртний үеэс үлдсэн. Энэ нь өнөөгийн хүмүүст тэдгээрийг аль үеэс үлдсэн болохыг олж мэдэх аргагүй болгосон. Түүхийг ээдрээтэй болгосон.

Олон хүмүүс Маяачуудын өв соёл нь өнөөгийн Мексикчүүдтэй холбоотой байсан гэж хэлдэг. Үнэндээ энэ нь Испаничууд болон нутгийн уугуул иргэдтэй эрлийзсэн үндэстэн болох Мексикчүүдтэй огт хамааралгүй юм. Нөгөөтэйгүүр Маяачуудын өв соёл нь түүхийн өмнөх үеийн соёл иргэншилтэй холбоотой байсан. Тэдгээр хүн төрөлхтөн Мексикт устгагдсан, зөвхөн цөөн тооны хүмүүс л амьд үлдсэн юм. Гэхдээ Маяачуудын өв соёл нь Монголчуудтай шууд холбоотой. Би энд дэлгэрэнгүй ярихгүй. Хүн төрөлхтөн өөрийн түүхэн гарал үүслийг мэддэггүй. Цагаан арьстнуудын хувьд мөн адил юм. Сүүлийн их үерийн үед хүн төрөлхтний сүүлчийн соёл иргэншил устгагдсан, 2000 метрээс дооших дэлхийн бүх уулс усан доор орсон, зөвхөн 2000 метрээс дээш өргөгдсөн уулс дээр амьдарч байсан хүмүүс л амьд үлдсэн. Ноагийн хөвөгч завины түүх үнэн. Тэр их үерийн үеэр Барууны соёл иргэншил бүрэн устгагдсан, дорнын соёл иргэншил ч бас

сүйдсэн. Гэхдээ Гималайн болон Кунлун уулсын нутгаар амьдардаг байсан хөдөөний хүмүүс зугтаж чадсан азтай, Кунлун ууланд амьдарч байсан Хятад хүмүүс мөн амьд үлдсэн. Тэр үед Дорнын өв соёл сайн хөгжсөн байсан, Шар мөрний зураглал (Хэту), Луо мөрний бичээсүүд (Луошу), Хувьслын ном (Ай Чин), Тайжи, Найман төлөг (Багуа), гэх мэт нь өнгөрсөн үеэс өвлөгдөж үлдсэн юм. Хүмүүс тэдгээрийг хожим үеийн ийм хүн, тийм хүн бүтээсэн гэж ярьдаг. Тэр хүмүүс зөвхөн тэдгээрийг шинэчилж, дахин олон түмэнд хүргэсэн. Тэдгээрийг тэр хүмүүс огт бүтээгээгүй, бүгд эртний соёл иргэншлээс гаралтай юм. Хэдийгээр эдгээр зүйлс Хятадад уламжлагдаж үлдсэн боловч Хятадын хөгжлийн түүхэнд үүнээс ч олон байсан юм. Эрт дээр үед илүү их зүйл хадгалагдаж үлдсэн боловч, уламжлагдан дамжих явцад улам цөөрсөөр ирсэн. Тэгэхээр энэ бол соёлын баялаг өв уламжлалтай, түүхийн гүнзгий эх сурвалжтай үндэстэн юм. Энэ бол Хятад. Нөгөө талаар Цагаан арьстны өв соёл их үерт бүрэн автсаны дараа арчигдсан. Тэр үед Европ тивийн хажууд өөр нэг тив байсан нь бас живсэн. Тэр бол тэдний хамгийн хөгжингүй газар байсан ба бас живсэн. Тиймээс Цагаан арьснууд юу ч үгүй, ямар ч соёл иргэншилгүй үеэс өнөөгийн шинжлэх ухааны хөгжилд хүртлээ дахин хөгжиж ирсэн.

Эртний Хятадын шинжлэх ухаан нь Барууны туршлаган дээр тулгуурласан шинжлэх ухаанаас өөр юм. Олон археологчид надтай эдгээр асуудлаар ярилцаж байсан, би тэдэнд бүгдийг тайлбарлаж өгсөн. Тэдэнд тайлбарлагдашгүй олон таавар асуулт байсан учраас энэ нөхцөл байдал үүссэн. Миний сая хэлсэнчлэн хүн төрөлхтний орчлон ертөнцийн талаарх ойлголт үүнээс цааш их хол явах боломжгүй юм. Өнөө үеийн олон эрдэмтдийн судалгааны ажлын эхлэл буруу байна. Ялангуяа тухайн салбартаа зарим амжилтанд хүрсэн хүмүүс түүнээсээ салж чадахгүй байдаг. Тэд ойлгосон хэмжээндээ тодорхойлж, түүгээр хязгаарлалт хийсэн. Энд байгаа та нарын олонх нь Хятадаас сурахаар ирсэн сурагчид, доктор, магистр зэрэгтэй өргөн мэдлэгтэй хүмүүс байгаа. Тэдний хүрэн дотор байхад тодорхойлолтууд нь та нарт зөв мэт байж болно, гэхдээ та нар тэдний ойлголтоос, хүрэнээс нь давахад

тодорхойлолтууд нь буруу бөгөөд хязгаарлагдмал болохыг олж мэднэ. Жинхэнэ чадварлаг эрдэмтэд эдгээр хязгаарлалтыг эвдэн гарч зүрхэлнэ. Эйнштейний хувьд бас түүний хэлсэн зүйл зөвхөн түүний ойлголтын хүрээнд зөв байсан, гэхдээ энэ хүрээнээс цааш түүний хэлсэн нь буруу болох нь тогтоогдсон. Та нар энэ зарчмыг харж байна уу? Хүн дээшлэхэд, чиний оюун сэтгэлгээ өндөр түвшний үнэнд ойртоход, чи дээд түвшинд хүрэхэд доод түвшний ойлголтууд буруу гэдгийг олж мэдэх болно. Ийм л байдаг.

Хүмүүсийн материйн тухай ойлголт буруу биш гэж үү? Хүн молекулын хамгийн том ширхгүүдийн давхаргаас бүрдсэн гадаргуйн матери болон гаригуудын хооронд орших энэ орон зайд байна, гэхдээ тэд аль хэдийн төөрөлтөнд орсон. Зөвхөн энэ хүрээн дотор л янз бүрийн замаар хөгжиж ирснийгээ тэд үнэмлэхүй шинжлэх ухаан, энэ бол материйн цорын ганц ойлголт, үүнийгээ хамгийн дэвшингүй гэж боддог. Энэ бол асар уудам, нарийн төвөгтэй сансар ертөнцийн орон зайд байгаа туйлын, туйлын өчүүхэн жижиг ширхэг доторх хязгаарлагдмал жижиг орон зайд орших энэ материаллаг ертөнцийн л ойлголт. Миний өмнө тайлбарласан гаригуудын бүтэц нь нэг систем л юм. Та нарын ойлгосон жаахан орон зай бол нэг хормын төдий л систем, тоо томшгүй олон тэрбум орон зайнуудын дунд орших нэг тоосонцор төдий систем доторх ойлголт. Энэ бол өчүүхэн орон зай доторх л ойлголт юм. Үүнийг чи зөв гэж хэлмээр байна уу? Тиймээс хүн төрөлхтний шинжлэх ухааны хөгжил, ойлголтын анхны үндсэн суурь нь буруу. Амь бодь ба хүн төрөлхтний эх сурвалжийн үүслийн талаар ярихад бүр ч төвөгтэй, би үүнийг ярихгүй. Учир нь би илүү их хэлж өгвөл, амь бодийн эх сурвалжтай холбогдоно, энэ бол тун нарийн асуудал. Түүнээс гадна, хэрэв би хэтэрхий их зүйл ярьж, хэт дээд түвшний зүйл хэлбэл хүмүүс итгэхгүй, яагаад гэвэл хүнд, хүний л ойлголт байдаг. Намайг энд ярьж байхад Бурхад үүнийг сонсоод итгэдэг, учир нь тэдний ойлголт бол Бурханых юм. Тэд үүнийг өөрсдийнхөө хүрээнд хардаг бөгөөд тэдний бодол, сэтгэлгээ нь хүмүүсийнхээс огт өөр юм.

Үүнийг ингэж тайлбарлах нь та нарт ойлгомжтой байна уу? Би та нараас асууя: Миний ярьж байгаа хэлбэр та нарт ойлгогдож байна уу, үгүй юу? (Алга ташив) Миний байнга хэлдэг зүйл байдаг, би өчигдөр үүнийг дахин онцолж хэлсэн: хувь тавилангийн холбоо (юань фэн). Бидний олонх нь энэхүү Дафа-г илүү олон хүмүүст таниулахыг үргэлж хүсдэг. Зарим хүмүүст чи үүнийг танилцуулмагц тэд маш сайнаар хүлээж авдаг, өөрсдөө сурахыг хүсдэг. Эдгээр хүмүүс магадгүй хувь тавилангийн холбоотой. Харин чи үүнийг зарим хүмүүст, эсвэл гэрийнхэндээ хүртэл танилцуулахад тэд сонсохыг ч хүсдэггүй, итгэдэггүй, чамайг юу ч гэж хэлсэн тоохгүй байдаг. Би хэлбэл, тэд магадгүй хувь тавилангийн холбоогүй. Мэдээжийн хэрэг, энэ нөхцөл байдал нь зөвхөн хувь тавилангийн холбооноос шалтгаалдаг биш юм. Зарим хүмүүсийн хувьд энэ нь төрөлхийн суурь муугаас эсвэл их хэмжээний нүгэлтэй холбоотой байж болно.

Өнөөдөр би хувь тавилангийн холбооны талаар онцолж ярих болно. Хувь тавилангийн холбоос гэж юу вэ? Би үүнийг урьд өмнө тайлбарлаж байсан. Бясалгалын орчинд хувь тавилангийн холбоог үргэлж онцолж ирсэн. Хувь тавилангийн холбоос яаж үүсдэг вэ? Үнэндээ, бясалгалын орчлонд бидний ярилцаж байгаа хувь тавилангийн холбоог түүхэн дэх ийм богинохон хугацаанд тайлбарлах боломжгүй гэдгийг хэлье. Энэ нь хүний нэг насны амьдралаас, эсвэл хэд хэдэн насны амьдралаас, цаашилбал бүр түүнээс ч урт хугацаанаас давсан асуудал. Энэ хувь тавилангийн холбоос нь төгсдөггүй. Яагаад төгсдөггүй гэж? Саяхан нүглийн өрийг төлөх талаар ярилцахдаа, хүний амьдралыг хэрхэн хардаг талаар дурьдсан. Хүний амьдралыг харахдаа түүний зөвхөн нэг амьдралыг нь биш харин бүх амьдралуудыг нь бүхэлд нь харах хэрэгтэй. Энэ нь, чи унтаж сэрээд өчигдөр байсныгаа өнөөдөр хүлээн зөвшөөрөхгүй байгаатай адил байж болох уу? Яасан ч тийм байж таарахгүй! Тиймээс хүний хувь тавилангийн холбоос нь маш урт хугацааг хамардаг. Сайн зүйл ч дамжиж ирдэг, муу зүйл ч бас дамжиж ирдэг. Өөрөөр хэлбэл хүмүүсийн хоорондын ердийн холбоос ч бас төгсдөггүй. Ихэнх тохиолдолд хүмүүсийн хувь тавилангийн холбоос гэдэг нь гэр бүлийн хувь тавилангийн

холбоог хэлдэг, өөрөөр хэлбэл эхнэр, нөхөр хоёрын хувь тавилангийн холбоос, энэ бол хамгийн түгээмэл зүйл юм. Үнэндээ би эхнэр, нөхөр хоёрын энэ хувь тавилангийн холбооны талаар өмнө нь ярьж байсан. Энэ бол энгийн хүмүүсийн асуудал юм. Нэгэнт хувь тавилангийн холбооны талаар ярилцаж байгаа болохоор би энэ талаар ярья. Энэ нь яаж үүсдэг вэ? Ихэнх тохиолдолд ихэвчлэн иймэрхүү байдаг: Өмнөх амьдралдаа нэг хүн өөр хүнд ач тустай зүйл хийсэн, тэр хүн үүнийг төлж чадаагүй, тэр магадгүй доод албан тушаалтан байсан эсвэл тэр амьдралдаа магадгүй маш ядуу байсан. Тэр энэ ач тусыг нь их хүртсэн тул буцааж хариулахыг хүссэн. Тэгвэл энэ нь магадгүй эхнэр, нөхрийн хувь тавилангийн холбоотой болох нөхцөл нь болдог. Өмнөх амьдралдаа хэн нэгэн өөр хэн нэгэнд хайртай байсан эсвэл хоёулаа бие биендээ хайртай байсан байж болох юм, гэхдээ тэдэнд хувь тавилангийн холбоос байгаагүйгээс гэр бүл болж чадаагүй, тэгвэл энэ нь магадгүй дараагийн амьдралдаа тэр хоёр эхнэр, нөхөр болох хувь тавилангийн холбоотой болж болох юм. Яагаад гэвэл хүний хүсэл их чухал байдаг, чи юу хүсч байна, юу хийх хүсэлтэй гэх мэт. Хэрэв чи “Би Буддад бясалгахыг хүсч байна” гэж хэлбэл, Будда чамд тусалж магадгүй юм. Яагаад тэр вэ? Энэхүү нэг бодол нь үнэхээр нандин юм, ийм хэцүү орчинд чи бас Буддад бясалгах хүсэлтэй байна. Нөгөө талаар, хэрэв хүн чөтгөр болохыг хүсвэл, үүнийг бас зогсоож чадахгүй. Хэрэв тэр муу зүйл хийхийг эрмэлзэж байвал түүнийг яаж зогсоох юм? Тэр чиний үгийг авахгүй, өөрийнхөөрөө зүтгэж санасандаа хүрнэ. Тиймээс хүний хүсэл маш чухал үүрэгтэй.

Нэмж дурьдахад, ойр дотны хамаатан садан, сайн найз нөхөд, сурагч, шавь байх, эсвэл хүмүүсийн хоорондын сайхан сэтгэл эсвэл хорсол занал гэх мэтээс үүдэн хувь тавилангийн холбоос үүсдэг бөгөөд энэ бүгд нь та нарыг нэг гэр бүл эсвэл нэг бүлэгт хамааруулдаг. Чи нийгэмд заавал нийгмийн харьцаанд байдаг, энэ нь хүмүүсийн хоорондын хурцадмал байдлыг шийдвэрлэх, мөн сайхан сэтгэл, хорон сэтгэлийг хариулах боломж олгодог. Эдгээр нь бүгд хувь тавилангийн холбоос юм, үүнийг ингэж л нэрлэдэг. Тэд нэг амьдралын наснаас үүддэггүй, хэд хэдэн амьдралын

наснаас эсвэл өмнөх амьдралаас үүссэн байж болно. Энэ нь ийм төрлийн нөхцөл байдлыг хэлдэг. Ийм талын харилцаа байдгаас бид ингэж олж мэдсэн, өөрөөр хэлбэл, хүний нэг насанд нь сайхан сэтгэл, хорон сэтгэл байдаг, ойр дотны хамаатан садан, сайн найз нөхөд, эхнэр хүүхэд гэх мэтчилэн байдаг, тэгэхээр энэ бүлэг хүмүүсийн дунд бас сайхан сэтгэл, хорон сэтгэл байх магадлалтай. Хэн нэгэн нөгөөд сайн ханддаг, хэн нэгэн нөгөөдөө муу ханддаг, нэг хүн нөгөө хүндээ өрөө төлж байдаг... Тэгвэл эдгээр зүйлс нь тэднийг дараагийн амьдралд нь нэг бүлэг болгож төрөл олоход хүргэнэ. Гэхдээ тэд хамтдаа ирдэггүй, тэд нэг зэрэг төрөл олно гэсэн үг биш юм. Тэдний энэ ертөнцөд ирэх хугацаа өөр өөр байдаг тул, зарим нь хөгшин, зарим нь залуу байдаг. Юутай ч энэ бүлгийн хүмүүсийн дунд хэн нь хэзээ төрөх тодорхой холбоос байдаг. Гудамжинд явж байгаа чиний бүлэгт харьяалагддаггүй, чамтай хувь тавилангийн ямар ч холбоогүй, эсвэл чамтай ямар ч харьцаагүй хэн нэгнийг харахад тэр хүн чамаас тэс өөр ертөнцийнх мэт санагдана. Чи түүнтэй ямар ч холбоогүй юм шиг санагдах болно, чамд тэд бас огт өөр төрлийн хүмүүс шиг санагдана. Тэгвэл эдгээр хүмүүс чиний бүлгийнх биш, чи тэдэнтэй хувь тавилангийн ямар ч холбоос байхгүй. Тиймээс хүмүүс ихэвчлэн бүлгээрээ төрөл олж өөр өөр цаг үед ирдэг. Зарим нь эцэг эх, зарим нь үр хүүхэд, зарим нь найз нөхөд, зарим нь дайсан, зарим нь ачтан байх болно. Энэ бол саяын ярьсан хувь тавилангийн холбоос юм.

Мэдээжийн хэрэг, бясалгал хийдэг хүмүүс ч гэсэн энэ хувь тавилангийн холбооноос зайлсхийж чадахгүй. Чи бясалгахыг хүсч байгаа болохоор... Урьд ингэж яригддаг байсан: Хэрэв хүн бясалгавал, түүний өвөг дээдэст нь хүртэл буян (дэ) очдог, тэдэнд бас ашиг тусаа өгдөг. Хэрэв чи бясалгал хийсээр, Буддад бясалгаж хүрсэн бол, тэд нүгэл ба үйлийн үрээ төлөх шаардлагагүй, бүгд Будда болно гэсэн үг биш, үүнийг огт зөвшөөрөхгүй. Чамайг энэ насандаа Фа олж авна гэдгийг тэд мэдэж байсан гэсэн үг, чиний эргэн тойрны хүмүүсийн дотор магадгүй чамтай урьд насандаа ураг төрөл байсан хүн байж болно, мөн чамд сайн эсвэл муу ханддаг хүмүүст чи Фа олж авах боломж олгоно, энэ нь магадгүй ийм хэлбэрийн хувь тавилангийн холбоос үүсгэнэ. Мэдээжийн

хэрэг, бясалгах нь гэр бүлээ хайрлахтай ямар ч холбоогүй юм. Гэр бүлийн сэтгэлээс ангид байж энэ хязгаарлагдмал холбоог салгадаг. Тиймээс хүмүүс ганцаар бясалгадаг эсвэл сонгосон ганц хүнд сургаалиа дамжуулдаг, мөн шавь нараа өөрсдөө сонгодог. Өнгөрсөн үеүдэд хүмүүс ингэж л бясалгаж байсан. Нийтийг аврах гэдэг нь бидний өнөөдрийн ярьж буй хувь тавилангийн холбоос юм. Миний ярьж байгаа хувь тавилангийн холбоос бол энд сонсож байгаа та бүгдтэй хамаатай юм. Та нар Фа-г олж авах хувь тавилангийн ерөөлтэй байсан магадлал өндөр. Тэгвэл энэ хувь тавилангийн холбоос хэрхэн үүссэн бэ? Энд байгаа олон хүн Фа-г олж авахаар ирсэн, тэд зорилготой ирсэн. Зарим нь магадгүй миний урьд амьдралуудад байсан ойр дотны садан төрлүүд, сайн найз нөхдүүд, шавь нар байж болно, эсвэл өөр хувь тавилангийн холбоотой байж болно. Гэхдээ бясалгал бол энгийн хүний хамаатан садантай холбоогүй, тийм зүйл байхгүй. Зарим хүн Фа олж авахаар ирсэн гэж би олонтаа хэлдэг. Тэд урьд нь магадгүй ийм хэлбэрийн хүсэлт хийсэн, зовлон бэрхшээлийг тэвчиж энэ Фа-г олж авахын тулд ирсэн. Энэ бас нэгэн хүчин зүйл. Ийм учраас би та нарт хоромхон зуурын буруу бодлуудаасаа болж энэ амьдралдаа тохиолдсон Фа олж авах боломжоо бүү алдаарай гэж захидаг, яагаад гэвэл чи үүрд харамсах болно, хэзээ ч дахин нөхөж чадахгүй. Үнэндээ, энэ хувь тавилангийн утсан холбоо нь ихэнхдээ хүмүүсийг татаж байдгийг би олж мэдсэн. Хэнийг ч орхигдуулаагүй, бүгд Фа-г олж авч байна. Зөвхөн ялгаа нь гэвэл хичээнгүй байдал, ахиц дэвшилд л байдаг.

Одоо би өөр нэг асуудлаар ярья: бясалгалын хэлбэрийн талаар. Би өчигдөр бас энэ талаар дурьдсан. Манай зарим сурагчид гэрлэх эсэх асуудлыг хөндсөн. Тэдний зарим нь гэрлэх хүсэлгүй, ууланд бясалгах хүсэлтэй, харин зарим нь өөр үзэл бодолтой. Манай Дафагийн бясалгалын өөр олон шавь нар бас ийм бодолтой байдаг. Гэхдээ миний зааж буй энэхүү Фа голчлон энгийн хүний нийгэмд бясалгадаг, өөрийнхээ Эзэн бодол (Жу-иши) ба Эзэн сүнсийг (Жу-юаншэнь) дээшлүүлэх зорилготой гэдгийг хүн бүр мэднэ. Нэгэнт чи зовлон бэрхшээлийг ухамсартайгаар, мэдсээр байж тэвчиж байгаа нь, мөн чиний хувийн ашиг сонирхол зөрчигдөж байхыг

тодорхой харж байсан ч сэтгэл чинь хөдлөхгүй байгаа нь чи өөрөө бясалгаж байна гэсэн хэрэг биш үү? Хэрэв Фа олж авсан нь чи биш бол, тэр хэн бэ? Хэрэв чи үнэхээр ууланд гарч бясалгавал, эдгээр зөрчил, бэрхшээлээс зайлсхийвэл бясалгал чинь удаан байх болно. Хүн он удаан жилийн явцад зууралдсан сэтгэлээсээ аажмаар салахад, энэ Фа-г олж аваагүй тохиолдолд, түүний Дэд Сүнс (Фу-юаншэнь) бясалгасан байж таарна. Уулын гүнд бясалгахад тийм нөхцөл байдал байхгүй, чи бясалгаж суухдаа магадгүй ховсдолын байдалд орох хэрэгтэй болно, удаан хугацааны турш ховсдолын байдалд сууна. Ийм тохиолдолд чи өөрөө бясалгаж байгаа эсэхээ мэдэхгүй, учир нь чи тийм төвөгтэй орчинд өөрийгөө жинхэнэ дээшлүүлэхгүй. Ийм л нөхцөл байдал байдаг. Шашин шүтлэгээр амьдардаг хүмүүс бас Эзэн сүнсээ бясалгаж болдог, гэхдээ энгийн хүний нийгэм бол хүний сэтгэл, оюун ухааны тэвчээрийг хатуужуулах хамгийн шилдэг газар юм.

Бясалгалын талаар бидний урьд сонсож байсан аргууд нь түүхэн дэх аль ч шашны эсвэл бясалгалын арга байсан, уламжлагдаж ирсэн зүйл нь ууланд эсвэл сүм хийдэд бясалгах, хүний ертөнцөөс холбоогоо таслах, гэр бүлийн сэтгэлээсээ салахыг заадаг байсан. Тийм хүний эцэг эх нь хийдэд уулзахаар ирэхэд тэр тэднийг хүлээн зөвшөөрөхгүй: “Та хэнийг хайж явна?” “Би чамайг хайж ирлээ. Чи миний хүү шүү дээ” гэхэд “Өө, Будда Амитаба. Уучлаарай, та намайг өөр хүнтэй андуураад байна. Намайг тэр, тэр...гэдэг” гэнэ, түүнд аль хэдийн номын нэр өгсөн байдаг. “Би Буддын бясалгалын шавь. Би таны хүү бишээ.” Тэд хүний ертөнцөөс өөрийгээ бүрэн тасалдаг. Өнөө үеийн лам хуврагуудын хувьд гэвэл тэд ердөө ч бясалгадаггүй, тэр ч байтугай мөнгө олж заримыг нь ар гэр лүүгээ илгээдэг. Жинхэнэ бясалгалд (эдгээр бясалгалын аргуудад) хүний ертөнцөөс холбоогоо таслахыг шаарддаг. Нэгэнт лам хувраг болбол түүнийг яагаад хүн гэж үздэггүй байсан бэ? Шалтгаан нь энэ л юм. Тэр аль хэдийн бурхан, хагас бурхан. Хэдийгээр (эдгээр бясалгалын аргаар) цаашид бясалгах аргагүй ч гэсэн эртний бясалгалын эдгээр арга барилыг олон хүн дагадаг нь тэдэнд садаа болдог, мөн ийм аргаар Дафагийн бясалгал хийхийг хүсдэг. Ирээдүйд энэ нь боломжтой ч, одоо

тийм ямар ч нөхцөл байхгүй байна. Өнөөдөр миний түгээж буй Фа нь зөвхөн одоогийн энэ бясалгалын хэлбэрийг л авч үзнэ, мөн би, багш нь өөрөө ч бас ууланд байхгүй байна. Тиймээс чи бясалгах тухай бодох бүрдээ ууланд гарах, бясалгах тухай бодох бүрдээ лам эсвэл гэлэнмаа болох, бясалгах тухай бодох бүрдээ гэрлэхгүй байх эсвэл энгийн хүмүүсийн амьдралын хэв маягийг өөрчлөх тухай үргэлж бодож болохгүй. Энэ нь тийм биш. Бясалгах олон арга зам байдаг. Наян дөрвөн мянган бясалгалын үүдний дотроос зөвхөн биднийх ийм аргаар бясалгадаг юм биш. Тиймээс миний хэлж байгаа нь өнгөрсөн үеийн бясалгалын хэдэн аргад эсвэл удаан хугацаанд тогтсон үзэл баримтлалд автах ёсгүй. Миний өнөөдөр та нарт тарааж байгаа зүйл бол та нарыг хамгийн хурдан хугацаанд жинхэнэ аварч чадах бүхэлдээ шинэ бясалгалын арга юм. Ирээдүйн хувьд, тэр үеийн бясалгах арга замууд байх болно. Үнэн хэрэгтээ, миний номонд хэлсэнчлэн, хэн нэгэн бясалгах гэвэл энэ нь амархан гэсэн үг биш. Чи бясалгаж, бясалгаж эцэст нь чи өөрийгөө үнэхээр бясалгасан биш, чи өөрөө ч үүнийг мэдэхгүй!

Их эрт дээр үеэс, хүний Эзэн сүнсийг аврахад тун хэцүү болохыг олон Бурхад олж мэдсэн гэдгийг би та нарт хэлж болно. Тиймээс тэд Дэд сүнсийг аврах аргыг хэрэгжүүлсэн. Нэгэн (Бурхан) хүмүүсийг энэ аргаар аврахад түүнд дажгүй сайн санагдсан, дараа нь өөр нэг нь бас ийм байдлаар хүмүүсийг аврахад бас дажгүй сайн болж байсан, дараа нь бүгдээрээ хүмүүсийг энэ замаар аврах болсон. Улмаар энэхүү хэлбэр нь хүмүүсийг аврах арга болж хүлээн зөвшөөрөгдсөн. Гэхдээ энэ нь хүмүүст шударга бус, тэр хүн бясалгаад байдаг харин өөр хэн нэгэн (Дэд сүнс) аврагддаг. Нарийндаа энэ шударга бус байдлаас болж тэд үүнийг олон нийтэд ил болгодоггүй, хүмүүст мэдэгдэхийг хүсдэггүй. Би үүнийг хүмүүст мэдүүлэхийн тулд ил гаргасан. Яагаад? Учир нь миний хүсч байгаа нь хүмүүст Фа-г үнэхээр олж авах боломжийг олгох, энэ байдлыг өөрчлөх, мөн чамд өөрийгөө бясалгах боломж олгох явдал юм. Энэ явцад, хүмүүс энэ аргаар бясалгасанаар нийгэмд үр өгөөжтэй, чи өөрийгөө сайжруулахад наад зах нь нийгэмд сайн хүн болох нь дамжиггүй. Тиймээс миний зорилго бол яг энэ зүйлийг эргүүлэх

явдал юм. Гэвч зарим Бурхад олон жилээр ийм замаар бясалгасан. Тэд Дэд сүнсний бясалгадаг замаар бясалгасан, тиймээс тэд бүгд үүнийг та нарт өгөхөд надад саад хийж байсан. Та бүгд бодоод үз дээ: Энэ Фа-г тараах нь амар биш, мөн үүнийг олж авах нь бас огт амаргүй. Эцэст нь Бурхад, Будда, Дао нар миний хийж байгаа зүйлийн үр дүн нь сайн болохыг харсан, одоо тэд мэддэг болсон.

Урьд намайг Хятадад Фа зааж байхад бүх зүйл маш хэцүү байсан. Одоо мэдээж, үүнийг заах нь харьцангуй хялбар байна, ялангуяа АНУ-д бол та нарт Фа сонсоход аль хэдийн их хялбар болсон. Түрүүн миний хэлсэнчлэн, бидний бясалгалын энэ хэлбэрт өнгөрсөн үеийн үзэл баримтлал нөлөөлөх ёсгүй, бид ингэж л бясалгана. Мэдээжийн хэрэг, та нарын энэ үе бясалгаж дууссаны дараа, ирээдүйд хүмүүс бясалгах өөрсдийн аргатай болно. Ирээдүйн хүмүүс Фа-гийн талаар энэ хэмжээнд мэдэж чадахгүй. Одоо бол түүхэн дэх онцгой үе учраас бид үүнийг тараасан. Бүр холын ирээдүйд, хүмүүс намайг хэн байсныг мэдэх боломжгүй, мөн бид тэдэнд “миний дүр төрх”-ийг ч үлдээхгүй. Эдгээр аудио, видео бичлэгүүдийг та нар хуулбарлан авсан ч, ирээдүйд эдгээр нь үлдэхгүй, бүгд арчигдаж алга болох болно. Урьд Будда Шагжамуни шавь нараа бясалгалд нь удирдан чиглүүлж байх үедээ шавь нараа материаллаг сонирхолтой болгохгүйн тулд мөнгө, эд зүйлс цуглуулахыг зөвшөөрдөггүй байсан. Тиймээс тэдэнд орхимж, бадар гуйх аяганаас өөр зүйл байлгахыг зөвшөөрдөггүй байсан. Гэхдээ хүмүүнд салахад хэцүү олон зууралдсан сэтгэл байдаг. Тухайн нэг үед олон хүмүүс бадар гуйх аяга цуглуулдаг болсон. Зарим нь “Миний энэ аяга хүрэл, миний энэ аяга бол хаш чулуун, миний энэ аяга харахад аятайхан, миний энэ аяга бол мөнгөн” гэдэг байсан. Зарим лам нар олон аяга цуглуулсан байсан. Тэгэхэд Будда Шагжамуни хэлсэн: “Хэрэв та нарт эд зүйлсийн зууралдсан сэтгэл байгаа бол гэртээ харьсан нь дээр бус уу, та нарын гэрт цуглуулах хадгалах бүх зүйлс байгаа. Та нар яагаад бадар гуйх аягыг ч орхиж чадахгүй байгаа юм бэ? Лам хүн бүх зүйлийг орхих хэрэгтэй. Бадар гуйх аяга цуглуулах бодлоосоо яагаад салахгүй байгаа юм бэ? Та нар үнэт эрдэнэсээ орхиод ирсэн биз дээ, тэгвэл яагаад нэг аяганд зууралдаад байгаа юм бэ?”

Үүгээр, Будда Шагжамүни хэнд ч ийм нэгэн бодол, бага зэрэг ч зууралдсан сэтгэл байх ёсгүй, үүнийг арилгах хэрэгтэй гэдгийг илэрхийлсэн. Тэдэнд ийм зууралдсан сэтгэл байхыг зөвшөөрдөггүй байсан.

Будда Шагжамүни-гийн үед, лам хуврагын аяга нь жижигхэн байсан, тэд өдөрт нэг удаа л идэх хоол гуйдаг байсан. Өнөөгийн лам нар их том аяга барьдаг. Урьд өглөгийн аяга хэрэглэдэг байсан бол, одоо дээш нь харуулсан хонх хэрэглэдэг, тэд дээшээ харсан хонхоор гуйлга гуйдаг болсон. Тэд чиний өгсөн хоолыг огтхон ч хүсдэггүй, харин мөнгө хүсдэг. Материаллаг ашиг сонирхол, мөнгөний ийм хүчтэй зууралдсан сэтгэлтэй байхад, энэ нь бясалгал мөн үү? Мөнгө бол бясалгагч хүнд хамгийн том саад болдог зүйл гэж би хэлнэ. Миний сая хэлсэн бол лам хуврагуудын тухайд байсан. Дафа-гийн бясалгал нь материаллаг зүйлд бус, харин оюун ухаанд ач холбогдол өгдөг. Та нар энгийн хүний нийгэмд ажиллаж байхдаа бясалгадаг, хичнээн их мөнгөтэй байх нь хамаагүй, харин мөнгө, эд баялагт зууралдсан сэтгэлгүй байх эсэх нь чухал. Танай байшинг алтан тоосгоор барьсан байсан ч чиний ухаан санаанд байхгүй, энэ талаар их бодохгүй. Хүмүүс энгийн хүмүүсийн дунд бясалгаж байхдаа янз бүрийн ажил эрхэлдэг. Та нар бизнес хийж мөнгө олно, гэхдээ чиний бодол санаанд байхгүй бол энэ нь ямар хамаа байх юм? Чи энэ талаар их бодлогоширдоггүй, мөн чамд энэ нь байсан, байхгүй нь ялгаагүй бол, чи энэ шалгалтыг давсан болно. Чиний байшин алтан байсан ч энэ нь хамаагүй. Бид чамайг энэ зууралдсан сэтгэлээс салахыг шаарддаг. Бясалгал гэдэг нь материаллаг зүйлээсээ салах гэсэн үг биш юм. Зөвхөн энэ аргаар л чамайг хүний ертөнцөд бясалгаж чадахыг чинь батална. Хэрэв хүн бүр бясалгадаг, хэн ч юу ч хийдэггүй байсан бол, энэ нийгэм юугаар амьдрах юм? Тийм байж таарахгүй. Бид зөвхөн хүмүүсийн оюун санаанд ач холбогдол өгдөг, хүмүүсийн оюун санаанд чиглэдэг, чи материаллаг зүйлээсээ салахын оронд зан чанараа (шиньшин-ээ) жинхэнэ дээшлүүлэх хэрэгтэй. Энэ нь уламжлалт бясалгалын аргуудаас юугаараа ялгаатай болохыг чи тодорхой мэдэж байх ёстой. Гэхдээ чамд ийм зууралдсан сэтгэл байгаа эсэхийг шалгах нухацтай сорилтонд чи орох болно.

Манай Дафагаар бясалгадаг бясалгагчдын хувьд, энэ бол бидний туулах замын нэг хэлбэр юм. Чи эдгээр зууралдсан сэтгэлийг багасгах хэрэгтэй. Ирээдүйд мэргэжлийн бясалгагчдын хувьд, тэд аяга бариад хоол гуйх болно, явганаар явж бадарчлах болно. Тэд дэлхий дээрх янз бүрийн зовлон бэрхшээлийг туулж байж л төгс гэгээрэлд хүрэх боломжтой болно. Лам нар ирээдүйд ийм замаар л бясалгах болно.

Зовлон бэрхшээлийн талаар, би та нарт ингэж хэлье: Хүн нэгэнт бясалгалаар хичээллэхэд, зовлон бэрхшээлийг амсах нь дамжиггүй, зовлон бэрхшээлтэй тулгарна. Дафа-гаар бясалгадаг хүмүүс адислал ивээлтэй байдаг, гэхдээ бясалгаж байхдаа тэд бас зовлон бэрхшээлтэй байна, энэ бол баттай юм. Гэхдээ хүмүүс бага зэрэг зовж зүдрэнгүүт эсвэл бага зэрэг бэрхшээлтэй тулгарах үед үүнийг муу зүйл гэж үздэг. “Яагаад миний энд тэнд эвгүйрхээд байнаа?” гэнэ. Хэрэв чи насан туршдаа ая тухтай байвал, чи тамд очих нь дамжиггүй гэж би хэлнэ. Чи амьдралынхаа туршид тохь тухтай байх нь битгий хэл, насан туршдаа өвдөж үзээгүй бол нас барсныхаа дараа тамд очно гэдэг нь зуун хувь баталгаатай гэж би хэлнэ. Амьд л байвал, карма-үйлийн үр үүсдэг. Чамд нүгэл хийхгүй байх боломж байхгүй, яагаад гэвэл чи амаа нээхэд л бусдыг гомдоох магадлалтай юм. Чиний хэлсэн үг бусдыг санамсаргүйгээр гомдоож болно: Магадгүй нэг хүн чиний хэлсэн үгэнд эмзэглэхгүй байж болно, гэхдээ өөр хэн нэгэн сонсоод гомдож магадгүй. Хүмүүс амьдрахдаа иддэг зүйлс нь амьтай, алхаж байхдаа ч амь бодийг гишгэж алдаг. Бид чамд дэлхий дээр амьдарч л байгаа бол мэдээж нүгэл хийнэ гэж хэлсэн. Хэрэв чи өвдөхгүй бол, чиний нүгэл арилахгүй. Хүн өвдөж зовоход түүний нүгэл үнэхээр арилж байдаг. Энэ нь арилсны дараа, чи сайжирна. Ихэнх тохиолдолд, хүн хүнд өвчин тусаад хэсэг хугацааны дараа эдгэрэхэд чиний нүүр царай туяаран гэрэлтэж, чиний хийсэн бүхэн саадгүй байдаг. Учир нь чиний нүгэл арилсны дараа энэ нь адислал болж хувирдаг-буян. Чи зовж шаналсан болохоор юу ч хийсэн голдуу саадгүй байдаг ба амархан биелэлээ олдог. Хүмүүс үүнийг харж чадахгүй учраас бага зэрэг зовлон бэрхшээлтэй тулгарсан ч

үүнийгээ муу зүйл гэж үздэг. Чухамдаа зовлон бэрхшээл гэж юундаа тийм аймаар байх юм?! Бага зэрэг зовлон бэрхшээлтэй байсан ч, хэрэв чи сэтгэл санаагаа хатуужуулж, тэсвэрлэж чадвал дараа нь чиний хийсэн бүхэн өөр явцтай байх болно. Би үүнийг хүмүүс бясалгаж байхдаа тэвчин туулах ёстой бэрхшээлээс өөр юу ч биш гэж хэлмээр байна. Хэрэв чи зовлон бэрхшээлээс айх айдаснаас салж чадвал, төгс гэгээрэлд заавал хүрнэ. Дээд түвшнээс ярихад, хэрэв чи амьдрал, ба үхлийн тухай бодлоо орхиж чадвал, чи үнэхээр Бурхан юм!

Будда Амитаба, хүмүүс түүний Буддын нэрийг давтан уншсаар “Сухавати диваажин”-д төрөл олох боломжтой гэж хэлсэн. Яаж тийм болох вэ? Түүний үгийг өнгөцхөн ойлгож болохгүй. Буддагийн нэрийг давтан уншсаар “Сухавати диваажин”-д очиж болно гэдэг бол үнэн, гэхдээ хүмүүс Будда-гийн үгийг өнгөцхөн тайлбарласан. Буддын Фа нь өөр өөр түвшинд гүн утга агуулдаг. Түүний Будда нэрийг давтан унших нь нэг ёсондоо бясалгал юм. Оюун ухаандаа “Амитаба” гэсэн үгнээс өөр зүйл үлдэхгүй болтол чи үргэлжлүүлэн уншвал, нэг бодол арван мянган бодлыг солино, чи уншсаар бодлоо “Амитаба”-гаас өөр зүйлгүй болтол бүрэн хоосолно. Буддын нэрийг уншиж байхад олон зууралдсан сэтгэл, янз бүрийн үймүүлэл анхаарлыг чинь саринуулна, чи тэдгээрийн эсрэг зогсож чадах уу? Бүх зууралдсан сэтгэлийг орхисноор бодол санаа хоосорвол бясалгалын зорилго биелнэ. Чи Буддын нэрийг давтан уншина гэдэг бол бас Будда-г хүндэтгэж байгаагийн илэрхийлэл юм. Чи “Сухавати диваажин”-д очихыг хүссэн учраас чи уншиж байна, чи Будда-д бясалгаж байгаа болохоор мэдээж “Сухавати диваажин”-гийн Будда чамайг ивээлдээ авахаар ирнэ. Үүнд гүн гүнзгий дотоод утга агуулагдаж байгаа юм. Зарим хүн, хэрэв яг нас барахынхаа өмнө Амитаба гэж давтан уншвал “Сухавати диваажинд”-д очиж болно гэж хэлдэг. Гэхдээ чи үүнийг хийхийн тулд, ямар байх ёстой вэ? Амьдрал, үхлийн тухай бодлоо үнэхээр хаяж чадвал, чи үнэхээр тийшээ очиж чадна. Энэ бол хүн ба Бурхан хоёрын ялгаа юм. Хэрэв чи амьдрал, үхлийн бодлоо орхиж чадвал, чи Бурхан, хэрэв чи амьдрал, үхлийн бодлоо орхиж эс чадваас чи бол хүн, энэ бол ялгаа нь. Бид бясалгаж, бясалгаж,

бүх зууралдсан сэтгэлийг орхидог, тэгвэл бас амьдрал, үхлийн бодлоо ч орхихгүй гэж үү? Хэрэв хэн нэгэн амьдрал, үхлийн бодлоо нэг зэрэг орхивол, үүнээс өөр зууралдсан сэтгэл гэж юу үлдэх юм? “Би Фа олж авлаа үхлээс ч айхгүй, бүр амьдралаа ч өгч чадна.” Тэгвэл түүнд өөр зууралдсан юу байх юм? Ийм л утгатай юм. Хүн үхэх гэж байхдаа маш их айдаг, “Өө үгүй ээ! Би удахгүй үхэх гэж байна. Энэ бол миний сүүлчийн амьсгал” гэдэг. Үүнийг ямар мэдрэмж гэх вэ? Гэхдээ зарим хүн үхэхийн өмнө ер айдаггүй, түүний уруул Амитаба гэж уншсаар л байдаг, түүнийг “Сухавати диваажин”-д очихгүй гэж чи хэлэх үү? Бүхнийг орхичихсон байхад, тэдэнд амьдрал, үхлийн бодол гэсэн ойлголт огт байхгүй. Хүний бодол болгон нь урт хугацааны бясалгал дээр суурилдаг. Энгийн хүмүүсийн бодол санаа нь туйлын төвөгтэй бөгөөд тэдэнд бүх төрлийн зууралдсан сэтгэл байдаг. Амьдрал, үхлийн ноцтой мөчид тэд яаж айхгүй байж чадах юм? Би “Дафа бол хамгийн энгийн бөгөөд хялбар” гэж хэлсэн, олон зүйл маш энгийн боловч тэдгээрийг задалж, нарийвчлан тайлбарлахад маш их ярих шаардлагатай. Гэсэн хэдий ч та нарт шууд хэлбэл та нар үүнийг хийж чадахгүй, хүмүүс гүн гүнзгий түвшний зүйлийг ойлгож чадахгүй байх байсан. Тэд бүгд үгийг өнгөн дээрээс өнгөцхөн ойлгодог. Тиймээс би та нарт Фа заах ёстой.

Сан Франциско хотод заасан Фа лекц

1997 оны 4-р сарын 6

Бид дөнгөж саяхан Нью-Йоркт уулзсан, өнөөдөр хэдхэн хоногийн дараа энд дахин уулзаж байна. Миний сүүлд ярьсан зүйлс дээд түвшнийх байсан болохоор, би анхандаа та нарт миний ярьсан зүйлийг тунгааж авах хугацаа өгөх бодолтой байсан. Үнэндээ, та нар миний саяхан ярьсан зүйлсийн талаар сайтар бодож үзвэл тэдгээр нь маш өндөр түвшнийх болохыг ойлгоно. Би та нарт үндсэндээ мөн чанарыг нь хэлсэн. Ингэж хэлэх шалтгаан байгаа, тухайлбал та нар өндөр боловсролтой. Мөн та нарын зарим нь Фа-г хожим олж авсан, гэхдээ Фа-г хожим олж авсан энэ хэсэг хүмүүс хурдан ахиж байна, тэдэнд тавигдах шаардлага бас өндөр бөгөөд түвшин нь хурдан өсч байна. Та нар үүнийг илүү хэцүү, илүү их төвөгтэй болохыг мэдэрч байна, өөрөөр хэлбэл илүү их саад бэрхшээлтэй мэт санагдана, ийм байх нь зайлшгүй. Өнөөдөр миний зааж байгаа олон зүйл урьд өмнө хэзээ ч яригдаж байгаагүй. Бясалгалын хугацаа маш хязгаарлагдмал учраас би энэ Фа-г та нарт аль болох хурдан тарааж та нар аль болох хурдан бясалгах боломжтой болно, мөн аль болох хурдан Төгс гэгээрэлд хүрнэ гэдэгт найдаж байна.

Дөнгөж өчигдөр би дараахь асуудлаар ярьсан. Та нар Баруун орныг зорьсон аялал хэмээх Хятадын романыг мэдэх байх. Тан лам Сюань Жуан (Тан гүрэн МЭ 618-907 он) судар олж авахаар Баруун орны диваажинг зорихдоо янз бүрийн саад бэрхшээл, зовлонг туулсан, есөн есийн буюу наян нэгэн төрлийн саад бэрхшээлийг нэгийг ч алгасалгүй давах ёстой байсан, эс бөгөөс хүлээн зөвшөөрөгдөхгүй. Тиймээс энэ нь огт амаргүй байсан. Өнөөдөр та нар Фа олж авахад хэтэрхий амархан байна. Та нар АНУ-д байхгүй байсан ч гэсэн, онгоцны тийз худалдаж аваад л богинохон хугацаанд энд ирчихэж болно. Түүнтэй харьцуулбал, та нар энэ

Фа-г үнэхээр амархан олж авч байна. Гэхдээ бясалгахад тийм ч бас амар биш. Би үүнийг бас бодсон: Хүмүүс Фа-г сурч чадах эсэх, Фа-г олж авах боломжтой эсэх, энэ Фа-г хэрхэн үздэгийг бид шалгах ёстой. Энэ цаг хугацааг хэт урт сунгаж болохгүй. Хүмүүс энэхүү Фа-г олж авахдаа эргэлзсэн хэвээр байна, “Би үүнийг сурах хэрэгтэй юу?” гэх мэтээр дахин дахин бодсоор л, эргэлзсээр л байна. Бид энэ талаар бас боддог, цаг хугацаа бага зэрэг давчуу байх нь дээр гэж бодож байна. Энэ Фа-г хэн ч олж авч чадна гэсэн үг биш, бид хувь тавилангийн холбоонд итгэдэг (юань фэн). Өөрөөр хэлбэл, цаг хугацаа бага зэрэг давчуу байвал Фа-г олж авах ёсгүй хүмүүс орж ирэх боломжгүй. Хэрэв цаг хугацааг сунгавал асуудал гарч болзошгүй, тухайлбал Фа-г олж авах ёсгүй хүмүүс орж ирэн бидэнд саад болно, хор уршиг тарих магадлалтай юм. Тэд итгэхгүй учраас саад учруулах нөлөө үзүүлнэ. Мэдээж, манай үүд хаалга өргөн нээлттэй, чиний хэн байхаас үл хамааран, чи сурч чадах л юм бол бид чамд хариуцлагатай хандах болно. Гэхдээ бид хүмүүсийн зүрх сэтгэлийг шинжих хэрэгтэй.

Буддын Фа агуу, асар уужим бөгөөд гүн гүнзгий. Бидний өнөөдөр зааж буй Фа нь Буддын Фа-гийн ердийн ойлголтоос давсан. Бид бүхэл бүтэн сансар ертөнцийн Фа-г, бүхэл бүтэн сансар ертөнцийн мөн чанарыг зааж байна. Гэхдээ энэхүү асар уудам сансар ертөнцийн хүрээнд, түүний түвшин болгонд сансар ертөнцийн мөн чанар оршдог, өөрөөр хэлбэл, Фа зарчим түвшин болгонд Жэнь, Шань, Рэн-ээс илэрдэг. Түвшин бүрийн Фа зарчмууд үнэхээр агуу болоод цогц. Хэрэв та нар тухайн нэг түвшний зарчмуудыг тайлбарлахыг хүсвэл, бүхэл амьдралынхаа туршид ч бүрэн тайлбарлаж чадахгүй байж мэднэ, тийм л агуу бөгөөд цогц. Будда Шагжамүни Татагата түвшнөөс хүмүүст болон бясалгаж буй шавь нартаа Дарма номоо заасныг та нар мэднэ. Гэхдээ тэр бүхий л амьдралаа зааж номлоход зориулахдаа зөвхөн өөрийнхөө бясалгалын арга барилыг л заасан байсан. Будда Шагжамүни, наян дөрвөн мянган бясалгалын үүд байдаг ба үүнд Бумбын бясалгал ороогүй гэж хэлсэн. Хятадын Бумбын системд гурван мянга зургаан зуун бясалгалын үүд байдаг гэдэг. Мөн эдгээрт бидний түгээмэл мэддэг барууны шашны Бурхдуудын

бясалгах аргууд ч бас ороогүй. Түүнээс гадна Будда Шагжамүнигийн ярьсан наян дөрвөн мянган бясалгалын зам бол зөвхөн Татагата түвшний хүрээн дэх ойлголт юм. Тэр хүрээнээс цааш маш олон бясалгалын зам байдаг, чи тэдгээрийг тоолох аргагүй, мөн маш олон өөр өөр Татагата Будда нар болон тэдний гэгээрсэн Фа зарчмууд байдаг. Энэ бол асар их. Будда Фа-г өргөн уудам далай, тэнгистэй зүйрлээд ч илэрхийлэх боломжгүй гэж хэлж болно. Сансар ертөнц хэр том байна, энэ Фа тэр хэмжээгээр том байна гэсэн утгатай юм.

Өнөөдөр би зөвхөн хүний хэлийг л ашиглаж байна. Өнөөгийн хүний хамгийн энгийн хэлээр энэ уудам гүнзгий, бүхэл бүтэн сансар ертөнцийн ерөнхий байдлын талаар та нарт ярьж байна. Хэрэв чи энэ Фа-г жинхэнэ гүн гүнзгий ойлгож чадвал, энэ Фа-д бясалгаж чадвал чиний хүрэх өндөр, гүн гүнзгий ойлголт, гэгээрэл чинь тайлбарласнаас ч хол давах болно. Чи бясалгах тусам аажим, аажмаар гэгээрэл чинь улам ахих болно. Жуан Фалунь номыг их унших тусам, үүнээс улам их зүйлийг ойлгох болно. Чиний төрөлхийн суурь хичнээн сайн байсан ч, энэ Дафа-д бясалгах хангалттай олон зүйл бий. Чи хэр өндөрт бясалгахыг хүсч байсан ч, энэ Фа хавьгүй илүү хангалттай, энэ Фа бол ер бусын агуу бөгөөд хязгааргүй юм. Би Жуан Фалунь номонд байгаа Фа зарчмууд бол үнэхээр өргөн цар хүрээтэй гэж хэлснийг та нар мэднэ. Үг бүрийн цаана давхарга давхаргаар тоо томшгүй олон Будда, Дао, Бурхад байгааг та нар харж болно, тэдгээрийг тоолохын аргагүй юм. Түвшин бүрт тэр түвшний зарчим оршдог болохоор түвшин бүрд тэр түвшний Будда, Дао, Бурхад байдаг, энэ Фа хичнээн өргөн уудам болохыг төсөөл дөө. Үнэндээ би үүнийг та нарт зөвхөн тоймлон хэлсэн. Үүнийг жинхэнэ ойлгох нь бясалгал дахь та нарын өөрсдийн гэгээлэг чанараас, бясалгалаас, яаж ойлгохоос чинь шалгаална. Тиймээс би та нарт нэг зарчим хэлье: Та нар Жуан Фалунь номыг нэг уншаад л дасгалуудыг мэдэж байх нь хангалттай гэж бодохгүй байх, эсвэл үүнийг сайн гэдгийг л ойлгоод зүгээр л дасгалаа хийгээд байвал болно гэсэн ойлголтгүй байх хэрэгтэй. Хэрэв чи өөрийгөө сайжруулахыг хүсвэл, энэ номонд бүрэн найдаж болно. Тиймээс чи номоо дахин дахин

унших хэрэгтэй. Номоо унших тусам чи илүү ихийг ойлгож, дээшилнэ. Үүн дээр төгс төгөлдөрт хүрэхэд туслах зүйл бол дасгалууд, тэгвэл чи өөрийнхөө түвшинг байнга дээшлүүлж байх болно. Тиймээс үүнийг нэг удаа уншихад л хангалттай, бусадтай хамт дасгалаа хийгээд бясалгалаа зогсоохгүй бол сайн гэж буруу ойлгож болохгүй. Энэ Фа бол туйлын чухал юм. Чи Фа сурах дээр шаргуу ажиллах хэрэгтэй.

Энэ сансар ертөнц бол маш өргөн уудам бөгөөд түүний бүтэц нь маш нарийн бөгөөд цогц. Би та нарт орон зайн бүтцийн талаар ярьсан. Жишээлбэл, бие бодь (матери) нь молекулууд болон бүр ч бичил бөөмсөөс бүрддэг. Бидний мэддэг орон зай нь мөн эдгээр бөөмсөөс бүрддэг. Өнөөдөр шинжлэх ухаанд мэдэгдэж байгаа бөөмс нь молекул, атом, нейтрон, атомын цөм, электрон, дараа нь кварк болон нейтрино юм. Түүнээс цааших нь өнөөгийн шинжлэх ухаанд танигдаагүй байна. Тэгэхээр миний хэлсэн нь эдгээр бөөмсийн түвшин бүрийн хүрээ нь бидний тэр түвшний хавтгай гэж нэрлэдэг зүйл юм. Үнэндээ бөөмсүүд хавтгай дээр тархсан биш, харин тухайн түвшинд хаа сайгүй оршдог, хавтгай дээр биш. Хүн төрөлхтөнд үүнийг илэрхийлэх нэр томъёо байхгүй учраас бид үүнийг хавтгай гэж нэрлэдэг, энэ бол бидний тайлбарлаж чадах цорын ганц арга юм. Яг энэ хүрээн дотор, тэр бөөмсүүдийн хүрээний давхарга дотор орон зай үүсдэг. Бөөмсүүдийн хооронд орон зайнууд байдаг, мөн бөөмсүүд дотроо бас өөрийн орон зайнуудтай байдаг. Гэхдээ бөөмсүүд нь янз бүрийн хэмжээтэй бөөмсүүдийг мөн бүрдүүлж чаддаг. Тэгэхээр тухайн нэг бөөмсөөс тогтсон янз бүрийн хэмжээтэй бөөмсүүдийн дотор мөн л орон зайнууд оршдог. Энэ бол миний хамгийн сүүлд та нарт тайлбарлаж өгсөн орон зайнуудын тухай ойлголт юм.

Атомууд ба молекулуудын хооронд асар уудам орон зай байдаг гэж би үргэлж хэлдэг. Хүмүүс бид молекулуудаас бүрдсэн хамгийн том ширхгүүдийн давхарга болон бидний харж буй гаригсын хооронд амьдардаг, эдгээр нь ширхгүүдийн давхарга юм. Хүн төрөлхтөн энэ орон зайд амьдардаг. Гариг бол бас нэг ширхэг юм. Цаашилбал Сүүн замын (Тэнгэрийн заадас) галактик гадна

бүрхүүлтэй байдаг. Сүүн замын галактик болон бусад сансар ертөнц даяар тархсан тоо томшгүй олон галактикууд орон зайг үүсгэдэг үү? Тэд бас хоорондоо харилцан холбоотой. Дараа нь галактикуудаас цааш бас сансрын уудам зай оршдог, тэгвэл энэ сансрын уудам зай нь ширхгүүдийн давхарга мөн үү? Энэ нь мэдээж ширхгүүдийн давхарга юм. Сансар ертөнц бол асар уудам, үүнийг ямар өргөн уудам болохыг дүрслэх арга байхгүй. Цаашилбал, бидний амьдардаг шиг гурван мянган орчлон ертөнц нь дараах арай том давхаргын орчлон ертөнцийг бүрдүүлдэг, тэр нь бас гаднаа бүрхүүлтэй, мөн тэр нь бүр ч том давхаргын орчлон ертөнцийн нэг ширхэг л юм. Гэхдээ миний саяын ярьсан ширхгүүд бол зөвхөн нэг цэгээс тэлсэн. Үнэн хэрэгтээ давхарга бүрийн ширхгүүд сансар ертөнц даяар тархсан байдаг. Миний саяны тайлбарласан нь орчлон ертөнцийн ердөө хоёрхон давхарга юм, чамд энэ нь аль хэдийн толгой эргэм санагдсан. Ирээдүйн хүн төрөлхтний шинжлэх ухаан ч үүнийг мэдэж чадахгүй, хүн төрөлхтөн хэзээ ч дээд түвшний зүйлийг мэдэж чадахгүй. Бидний ярилцсан хэмжээн дэх ширхгүүдийн давхарга нь хүртэл хумхын тоос, энэ өргөн уудам сансар ертөнц доторхи өчүүхэн хумхын тоос. Энэ сансар ертөнц хичнээн асар том болохыг бодоод үз дээ! Энэ бол миний та нарт үргэлж хэлдэг байсан орон зайн хэлбэр юм.

Хамгийн сүүлд би орон зайнуудын бүтцийг дахиж ярьсан. Цаашилбал атомууд ба молекулуудын хоорондох, молекулууд ба гаригуудын хоорондох орон зайнуудын хэлбэрээс гадна, давхарга болгоны атомын ширхгүүд нь мөн л янз бүрийн хэмжээтэй ширхгүүдийг бүрдүүлдэг. Эдгээр янз бүрийн хэмжээтэй ширхгүүдийн давхаргуудын хооронд мөн л орон зайнууд оршдог. Жишээ болгон молекулуудыг авч үзье: Молекулууд ба атомуудын хооронд орон зай байдаг гэдгийг бид гол төлөв мэддэг. Хэрэв атомууд молекулуудыг бүрдүүлдэг юм бол, молекулыг бүрдүүлэхийн тулд олон атомыг нэгтгэх хэрэгтэй. Тэгвэл, цөөхөн атомын ширхгүүдээс бүрдсэн том ширхгүүдийн давхарга ба олон атомын ширхгүүдээс бүрдсэн том ширхгүүдийн давхаргын хооронд мөн л өөр орон зайн түвшин оршдог. Миний хэлснээр, хүмүүс бидний харж чадах ган, төмөр, ус, агаар, мод, хүний бие гэх

мэт хамгийн гадаргуйн ямар ч зүйлс молекулуудаас үүсдэг. Энэ бол хүний харж чадах гадаргуу дээрх бие бодийн давхарга бөгөөд энэ нь молекулуудаас бүрдсэн хамгийн том ширхгүүдийн давхаргаас бүрддэг. Гэхдээ молекулууд нь бас хамгийн том молекулын ширхгүүдээс ялимгүй жижиг хэмжээтэй ширхгүүдээс тогтох хоёр дахь арай нарийн ширхэгтэй давхаргыг бүрдүүлдэг. Тэдгээр нь мөн арай жижгэвтэр ширхгүүдээс тогтох гурав дахь арай нарийн ширхэгтэй давхаргыг бүрдүүлдэг, эдгээр нь бүгд молекулуудаас тогтдог, учир нь молекулууд өөр өөр хэмжээтэй ширхгүүдийг бүрдүүлж чаддаг. Тэдгээрийн хооронд бас л орон зайнууд оршдог, тиймээс энэ сансар ертөнц бол туйлын нарийн бөгөөд цогц. Түүн дээр бас орон зайн түвшин бүрийн дотор босоо орон зайнууд оршдог ба эдгээр нь өөр өөр түвшний орон зайнууд юм. Өөрөөр хэлбэл, шашингуудад ойлгодог олон давхарга тэнгэр байдгийн адил янз бүрийн түвшний орон зайнууд оршдог гэсэн үг юм. Нэмж хэлэхэд, янз бүрийн түвшний орон зайнуудад янз бүрийн төрлийн диваажингууд оршдог. Энэ бол маш нарийн ярвигтай. Би та нарт зөвхөн ерөнхий байдлаар дүрслэн хэллээ.

Түүнчлэн хэлэхэд, энэ төрлийн орон зайнаас гадна, том ширхэгийн орон зайнууд оршдог, хамгийн гадаргуйн давхаргын орон зай юм. Би та нарт байнга хэлдэг... мэдээж, өнгөрсөн удаа хэн нэгэн надаас миний нэг нийтлэл болох “Цаашдын ахиц дээшлэлтийн үндэс” дээр “Хүний нийгэм хамгийн гадаргуйн давхрагын яг дунд оршдог, хамгийн гадаргуйн давхаргад оршдог” гэснийг юу гэсэн утгатай болохыг асуусан. Энэхүү сансар ертөнцийн зарчим дагуу “хамгийн гадаргуйн давхарга” гэсний утгын хувьд бол гадна, дотор гэж байдаггүй, мөн хүн төрөлхтний ойлгодог том, жижиг гэсэн ухагдахуун ч бас байдаггүй. Тэр ухагдахуун нь бидний хүмүүсийн ойлгодогдоос тэс өөр юм. Өнөөдөр би энэ "гадна" гэдгийн талаар ярья. Би яагаад хүн төрөлхтөн хамгийн гадаргуй дээр, хамгийн гадна талын давхаргад оршдог гэж хэлдэг вэ? Энэ нь юу гэсэн үг вэ? Өөрөөр хэлбэл, миний урьд өмнө ярьж байсан орон зайн хэлбэрээс гадна, өнөөдрийн бидний амьдарч байгаа шиг өөр нэгэн төрлийн орон зай оршдог, энэ нь Бурхадын байдгаас огт өөр юм. Миний урьд өмнө ярьж байсан

орон зайнууд нь бүгд илүү бичил дээд энергийн бие бодиор бүтсэн бол, өнөөдрийн ярьж байгаа нь бол гадаргуйн материас тогтсон юм. Энэ гадаргуйн матери дотор мөн л маш олон янз бүрийн элементүүд, янз бүрийн ширхгүүд байдаг. Энэ бол гадаргуйн маш онцгой орон зай юм. Энэ нь яг бидэнтэй адил юм: чиний биед янз бүрийн хэмжээтэй эсүүд байдаг, эдгээрийг ширхгүүд гэж нэрлэсэн ч болно. Эс бүрийн гадаргуу дээр бүрхүүл давхарга байдаг. Хүний биеийн гадаргуйн арьсыг бүрдүүлдэг ширхгүүд мөн бүрхүүлтэй байдаг. Хүний биеийн гадаргуйн ширхгүүдийн бүрхүүлүүд хүний гадаргуйн арьсыг бүтээдэг. Туйлын бичил түвшинд, энэ бүрхүүл нь бас туйлын уудам орон зай. Биен доторхи ширхгүүдийн бүрхүүлээс тогтсон эд эрхтний салст бүрхэвч нь гадаргуйн дотоод бүтэцнээс огт өөр. Сансар ертөнц мөн адил юм. Мэдээжийн хэрэг, энэ нь маш нарийн төвөгтэй. Хүмүүс бидний амьдардаг орон зай нь ямар вэ? Энэ бүхэн нь ширхгүүдээс тогтсон гэж үзье. Ширхгүүд хичнээн том, жижиг байхаас үл хамааран ширхэг бүр гаднаа бүрхүүлтэй байдаг.

Өнөөдөр миний та нарт ярьж байгаа зүйл бол энэ гаднах бүрхүүл юм. Хэдийгээр эдгээр гаднах бүрхүүлийн ширхгүүд ширхгүүдийг бүрхдэг ч, ширхгүүд ширхгүүдийг бүрхэж байдаг, зарим ширхгүүд дотор нь байгаа мэт байдаг-Дэлхий бол яг төвд оршдог-эдгээр нь үнэн хэрэгтээ гадна талд харьяалагддаг. Тийм учраас би хүмүүс хамгийн гадаргуйн давхаргад оршдог гэж хэлдэг. Тэд бүгд хамгийн гадна талд харьяалагддаг, яагаад гэвэл тэд бүгд хамгийн гадаргуйн бүрхүүлтэй холбоотой байдаг. Гадаргуйн бүрхүүл бол бие даасан систем юм. Сансар ертөнцөд хамгийн том гадна талын бүрхүүл байдаг, бүгд энэ хамгийн том гадна талын бүрхүүлтэй холбоотой. Хүн төрөлхтний махан бие бодь орших энэ орон зай бол мөн ийм хэлбэрт оршдог. Энэ орон зай нь өөрийн онцлог шинж чанартай, энэ нь Бурхадын диваажингаас эсвэл миний өмнө ярьсан орон зайнуудаас огт өөр юм. Гэсэн хэдий ч сансар ертөнц дахь бүх бие бодийн эх сурвалж нь эдгээр орон зайнуудаас үүдэлтэй.

Өнөөдөр хэн нэгэн надаас хүж уугиулах талаар асуусан. Энэ талын бие бодь алга болсны дараа, нөгөө талд байгаа биет чөлөөтэй болж суллагддаг гэж би хэлсэн. Үүний зэрэгцээ энэ талын биет тэр тал руу шилжиж болно. Тиймээс энэ талын бие бодис тэр талд нилээд нандин юм. Учир нь шатаахад энэ талын бодис хувирна, энэ талд байснаасаа өөр бодис болчихдог. Би үүнийг өмнө нь хэлж байсан: Хэрэв чи дэлхий дээр бясалгасныхаа дараа, атга шороо тэнд аваачиж чаддагсан бол дээрх хүмүүс чамайг гайхамшигтай гэж бодох болно. Энэ бол зүгээр санаа. “Сухавати диваажин”-д хаа сайгүй алт байдаг гэж хэлдэг. Хэрэв чи, ширхэг ч чулуу, ширхэг ч тоос байдаггүй Сухавати диваажинд энэ материаллаг ертөнцөөс нэг жижиг зүйл аваачвал тэр нь магадгүй хамгийн нандин зүйл болно. Хүмүүст, цөөн зүйл нь үнэ цэнэтэй, ховор зүйл нь гайхамшигтай гэсэн үг байдаг. Мэдээжийн хэрэг, бодит байдал дээр тийм байх албагүй. Би зүгээр л нэг санаа өгч байгаа юм. Учир нь тэр талын бүх бие бодь эндээс эхлэлтэй юм. Мэдээж, хүмүүс бид үүнийг тусгайлан хийх шаардлагагүй. Сансар ертөнцийн механизмууд ингэж ажиллаж байдаг.

Энэ гадаргуйн ертөнцийн талаар, тухайлбал бидний нүдээр хардаг гаригуудын талаар илүү дэлгэрэнгүй ярья. Гариг бүр өөрийн бусад орон зайнуудтай байдаг, янз бүрийн хэмжээтэй ширхгүүдээс үүссэн олон тооны орон зайнууд юм. Хамгийн том ширхгүүдээс тогтсон гадаргуйн орон зай бол үүний бүрхүүл буюу хамгийн гадна талын гадаргуй юм. Дөнгөж сая би хүний биеэр зүйрлэсэн. Сансар ертөнцөөр хэлбэл, хүмүүс бидний амьдардаг орчлон ертөнц нь сансар ертөнцийн гаднах бүрхүүл юм.

Сансар ертөнц бол гайхалтай асар том бөгөөд бид ч бас үнэндээ сансар ертөнцийн дунд талд оршдог. Ширхгүүд өөр ширхгүүдээр бүрхэгддэг мэт боловч, чи үнэхээр гадна талд байдаг гэж би сая хэллээ, яагаад гэвэл чиний оршиж байгаа энэ орон зайн бүтэц, бие бодь ба холбоосууд нь гадна талын орон зайнуудын системүүдтэй адил, мөн гадна талын орон зайнуудаар хязгаарлагддаг, ийм л нөхцөл байдалтай. Нэмж хэлэхэд, Будда Шагжамүни нэг ширхэг элсэн дотор гурван мянган хорвоо ертөнц

байдаг гэж хэлсэн. Үнэндээ Будда Шагжамүни, элсний ширхгүүдийн гадаргуу дахь бичил орон зайнууд нь маш олон янз бүрийн хорвоо ертөнцийг агуулдаг гэж хэлсэн. Гэхдээ өнөөдөр би та нарт илүү тодорхой хэлье: Элсний гаднах бүрхүүл, гадаргуй нь, мөн элсний ширхгүүдийг бүрдүүлдэг давхарга бүр дэх ширхгүүдийн гаднах бүрхүүлүүд нь манай энэ талын материаллаг орон зайтай нэг ижил системд багтдаг. Молекулуудаас бүрдсэн янз бүрийн хэмжээтэй ширхгүүд доторх олон, олон амь бодь нь бидний хүн төрөлхтөнтэй яг ижил хэлбэр, дүрстэй байдаг. Өөрөөр хэлбэл, элсний ширхгүүдийн доторх хүмүүс бидэнтэй яг адилхан-хар арьстай хүмүүс, цагаан арьстай хүмүүс, шар арьстай хүмүүс байдаг. Чи ирээдүйд тэдний хувцаслалт нь манай эртний хүмүүсийн хувцаснаас нэг их ялгаатай биш байхыг хараад гайхах болно. Үүнээс гадна, тэдний ертөнцийн илүү бичил түвшинд өөр нэг хэлбэрийн ерөнхий өөрчлөлт гарна, ийм төрлийн өөрчлөлт урьд өмнө хэзээ ч яригдаж байгаагүй. Өөрөөр хэлбэл, янз бүрийн бичил ертөнцүүдэд бас орчлон ертөнцийн тодорхой орон зай байдаг. Миний сая хэлсэн бол элсний ширхгүүдээс бүрдсэн орчлон ертөнцийн уудам зай юм.

Бидний ярьсан бичил орчлон ертөнцүүдэд байдаг тэдгээр амь бодиуд өөр нэг системд харьяалагддаг-өөр сансрын биет дэх амь бодиудын систем юм. Тэнд бас Будда нар, Дао нар, Бурхад, хүн, амьтан, түмэн бодис, уул, ус, тэнгэр, газар, агаар болон тэдгээрийн бичил орчлон ертөнцүүдэд оршдог бүхий л бие бодь матери оршдог. Үүнтэй адил бүр бичил, мөн түүнээс ч бичил орчлон ертөнцүүд оршдог. Тийм ч учраас урьд өмнө манай олон бясалгагчид бичил ертөнцүүдээс-элс, хөрс, чулууны жижиг ширхэгийн бичил ертөнцүүдээс гарч ирж байгаа Буддыг олж харсан. Тэдгээр Будда нар өөрсдийгөө том болгож чаддаг. Түүнээс жижиг системд бас Будда нар, Дао нар, Бурхад, хүмүүс байдаг бөгөөд тэдгээр Будда нар Буддын адил бас өөрсдийгөө хувиргаж манай ертөнцөд ирж очдог. Тэд өөрсдийгөө хэр том болгож чадах вэ? Тэд хамгийн томдоо Сүүн зам (Тэнгэрийн заадас) галактик шиг том болж чадна. Тэд жижиг болохдоо зүгээр л нүднээс алга болдог. Тэдгээр нь бичил ертөнцийн Будда нар болохоор, манай сансрын

биетийн Будда нараас огт өөр юм. Гэхдээ тэд ижил дүр төрхтэй бөгөөд бясалгахад тавигдах шаардлага ч мөн адил байдаг. Тэд адилхан аугаа юм. Тэд бас дээрээс авхуулан доош бүхэнд үйлчлэх Жэнь-Шань-Рэн Фа-д адилхан холбоотой байдаг.

Энэ сансар ертөнц бол үнэхээр гайхалтай. Эдгээрээс ч маш, маш, маш жижиг ертөнцүүдийн сансрын биетүүдэд илүү жижиг Будда, Дао, Бурхад, хүмүүс, бие бодь оршдог. Гэхдээ тэдгээр оршихуйнууд нь зөвхөн нэг ширхэг элсэнд байдаг гэсэн үг биш, харин тэдгээр нь сансар ертөнцийн бүх бие бодь, өөр өөр хэмжээтэй ширхгүүдийн дотор нь, гадна нь, мөн бүх ширхгүүдийн бүрхүүл даяар тархсан байдаг. Би зүгээр л бичил түвшингүүдийн талаар ярилаа. Энэхүү асар том сансрын биет тодорхой хэмжээнд хүрэхэд бидний энэ сансрын биетийн хүрээнээс гардаг. Тийм сансрын биетийн хамрах хүрээг “орчлон ертөнц” гэсэн нэршилд багтаах боломжгүй, энэ ухагдахуунаас огт өөр. Орчлон ертөнц тодорхой хил хязгаарт хүрэхэд, гэнэт юу ч оршихгүй хов хоосон орон зайтай тулгардаг. Түүнээс цаашилбал илүү том сансарын биет оршин байхыг үзнэ, энэ нь бидний энэ сансрын биетээс тэр чигтээ өөр юм. Миний яриад байгаа сансрын биет бол энэ орчлон ертөнцийн ойлголтоос бүрэн давсан. Тиймээс том сансрын биетийн Будда, Дао, Бурхад нэн агуу том юм. Тэд биднийг харах нь бид бичил ертөнц дэх эсвэл бичил сансрын биет дэх Будда, Дао, Бурхад, хүмүүс, болон бусад зүйлсийг хардагтай адил байдаг. Тиймээс тэд өөр нэг асар том системд хамаарагддаг. Тэдний хүмүүс биднийг хэрхэн хардгийг дурьдах нь бүү хэл тэд бидний энэ сансрын биетийг харахдаа ховор олдвор үзсэн мэт байдаг. Тэдэнд энэ нь өвөрмөц, гайхалтай, их сонирхолтой санагддаг. Тэд бас эдгээр амь бодийг тун гайхалтай гэж үздэг. Энэхүү бяцхан сансрын биет бас амь бодиор дүүрэн, тэд үүнийг ингэж хардаг. Гэхдээ тэдэнд энэ сансрын биетийн хүрээн доторхи бидэн шиг амь бодийн адил үзэл бодол байдаггүй, огт байхгүй. Тэдний нүдэнд чи бичил организм, тэдэнд юу ч биш. Тийм ч учраас манай олон бясалгагчид чулуу, элс эсвэл бүр бичил ширхгүүд доторх байдлыг харахад ихэвчлэн тийм мэдрэмж төрдөг.

Манай зарим сурагчдын тэнгэрийн мэлмий (тианму) нээгдэхэд, тэд тэнгэрийн мэлмийн дотроо уул, усыг олж хардаг ба тэд гадагшаа гүйж байгаа, гадагшаа маш хурдтай гүйж байгаа харагддаг. Тэд олон, олон уулс, голууд болон тэр ч байтугай олон, олон хотуудын хажуугаар өнгөрдөг, тэд тэнгэрийн мэлмийн дотроос гадагшаа гүйсээр л байдаг. Чиний харж буй дүр зураг бол гаднах байдал биш гэж би хэлнэ: Эдгээр нь үнэхээр чиний толгой доторхи эсүүд болон илүү бичил ширхгүүдээс бүрдсэн орчлон хорвоогийн орших хэлбэрүүд юм. Хэрэв чи харж чадвал, нэг ширхэг үсэн дотор олон хот суурин байгааг, дотор нь бас галт тэрэг, машинууд давхилдаж байхыг олж харж магадгүй гэж би олонтаа хэлдэг. Энэ үнэхээр санаанд багтамгүй юм шиг сонсогдож байгаа биз. Энэ орчлон ертөнц бол яг ийм асар уудам, нарийн цогц бөгөөд бидний орчин үеийн шинжлэх ухааны ойлголтоос тэс өөр юм. Өнөөдрийн шинжлэх ухаан үүссэн цагаасаа хойш алдаатай ойлголт, буруу үндэслэл дээр хөгжиж ирсэн гэж би үргэлж хэлдэг. Тиймээс зөвхөн тэр хүрээнд л хязгаарлагддаг. Жинхэнэ шинжлэх ухааны хувьд гэвэл, бидний орчлон ертөнц, амьдрал, материйн талаар сурч мэдсэн зүйлээс харахад, өнөөгийн шинжлэх ухааныг шинжлэх ухаан гэж үзэх боломжгүй юм, учир нь энэ шинжлэх ухааны замыг дагавал, орчлон ертөнцийн гайхамшгийг хэзээ ч олж мэдэж чадахгүй. Хүн төрөлхтөн, зөвхөн хүмүүс л орчлон ертөнцийн цорын ганц амь бодь гэж өөрсдийгээ үздэг, тэд туйлын өрөвдмөөр, ийм л хөөрхийлэлтэй. Харь гаригийнхан манай дэлхийд ирж байдаг, тэдний фото зураг хүртэл байдаг, гэтэл хүмүүс тэдний оршин байдагт итгэдэггүй хэвээр байна. Хүмүүс энэхүү шинжлэх ухаанаар хязгаарлагдсан учраас тэр юм. Сэтгэл хөдлөлд хөтлөгдсөн тэдгээр хүмүүс судалгаа хийдэггүй, тийм мэдрэмж байхгүй. Тэд зөвхөн аль хэдийн хүлээн зөвшөөрөгдсөн зүйлд л итгэх дуртай, ямар нэг зүйл үнэхээр үнэн байсан ч үл тоомсорлодог, зөвхөн номноос сурч мэдсэн зүйлдээ итгэх дуртай байдаг. Энэ бол миний ярьсан орон зайнуудын хэлбэр юм. Хүний хэл их хязгаарлагдмал учир үүнийг тайлбарлахад надад хэцүү байдаг. Та бүгдэд ойлгогдсон болов уу? гэж асуумаар байна (Алга ташив)

Бидний мэдэх Будда, Дао, Бурхад болон, хүмүүс бидний харж буй бүх матери бүх зүйлс жао (Бурхдын хэмжүүрийн нэгж) хэмжээгээр ч тоолохын аргагүй олон орчлон ертөнцийг багтаасан орон зайнуудад оршдог. Энэхүү сансрын биет ийм л асар том юм. Энэ бол нэг бие даасан систем. Дараа нь энэ уудам хүрэнээс цааш өөр бие даасан систем болох бүр том сансрын биет оршдог, сансар ертөнц ямар агуу том болох нь энэ юм. Бичил ертөнцөд энэ нь туйлын, туйлын, туйлын бичил юм. Хүмүүс бидний амьдардаг дэлхий бол төвд байршилтай, макро эсвэл микро талаас нь авч үзвэл хүний ертөнц бараг гол дунд нь байдаг. Өөр өөр ширхгүүд нь өөр өөр орон зайнуудыг үүсгэдэг. Үүнээс гадна, онцгой, өөр ширхгүүдээс бүрдсэн гадаргуйн ертөнцүүд бас байдаг. Та нар мэднэ, намайг Хятадад байхад зарим сурагчид яагаад зарим шавь нарын Сүнснүүд (Юаншень) махан биеэ орхиод бидний энэ материаллаг орон зайд аялахдаа Буддын, Бурхдын диваажинг олж хардаггүй юм бэ гэж асуусан. Тэдний харсан бүх зүйл бол бидний энэ материаллаг орон зайн бодит байдал юм. Тэд яагаад Бурхдыг хараагүй вэ? Учир нь тэд хүмүүсийн амьдардаг орон зай болох энэхүү гадаргуйн бүрхүүл хэлбэрийн орон зайд орсон, энэ нь биднийх шиг материаллаг орон зайн хэлбэртэй байдаг, тэд ийм л байдлыг харсан юм. Энэ бол миний ярьсан орон зайн төрлийн орших хэлбэр юм.

Манай зарим сурагч надаас асуусан: "Хүний амьдрал хэрхэн бий болсон бэ?" Би материйн эх үүсвэрийн талаар өмнө нь дурьдсан, гэхдээ энэ асуултын талаар бас ярья. Намайг шинжлэх ухааны талаар ярьж байна гэж битгий бодоорой, Будда Фа бүх зүйлийг өөртөө агуулдаг. Би бие бодийн (матери) эх сурвалжийн талаар өмнө нь ярьж байсан. Эх үүсвэр нь юу вэ? Би та нарт материйн эх үүсвэр нь юу болохыг хэлээгүй. Би сая ярьсан бүх янз бүрийн сансрын биетүүдийн эх үүслийн талаар хэлэх боломжгүй ч, бидний энэ сансрын биет доторхи янз бүрийн давхаргад оршин буй бие бодь, оршихуйнуудын гарал үүсэл нь юу болохыг хэлж өгч болно. Үнэндээ материйн эх үүсвэр нь ус юм. Орчлон ертөнцийн эх үүсвэр болох ус нь дэлхий дээрх энгийн хүмүүсийн ус биш. Би яагаад усыг материйн эх үүсвэр гэж хэлж байгаа вэ? Янз бүрийн

түвшний хамгийн бичил матери тодорхой цэгт хүрэхэд матери байхгүй болдог. Нэгэнт матери үгүй болоход бие бодийн ширхгүүд оршин тогтнохоо болино. Цааш нь харахад, нэг байдал гардаг: ямар ч материаллаг ширхэггүй зүйл илэрдэг бөгөөд энэ нь намуун тогтонго байдаг, би үүнийг голдуу үхмэл хөдөлгөөнгүй ус гэдэг. Мөн үүнийг эх үүсвэр, амьгүй ус гэдэг. Хэрэв чи ямар нэгэн зүйл үүнд шидвэл, цалгих долгион үүсэхгүй. Дууны чичиргээ ч мөн долгион үүсгэхгүй, энэ бол огт хөдөлгөөнгүй. Гэхдээ материйн хамгийн үндсэн бүтэц нь ийм төрлийн уснаас үүсдэг.

Бүтэц нь яаж бүрэлддэг вэ? Энэ сансар ертөнцөд Фа байдаг. Энэ Фа бол бидний ярьдаг Жэнь-Шань-Рэн юм. Сансар ертөнцийн энэхүү мөн чанар нь тэр усны хамгийн анхны, хамгийн бичил, мөн усны хамгийн анхдагч ширхгүүдийн нэгдэл, үүнийг хамгийн анхдагч ширхэг гэж хэлж болно. Гэхдээ тэдгээрийн аль аль нь нэгдмэл, энэ нь юу ч биш, яг л усны хөөс шиг. Дараа нь хоёр анхдагч ширхгүүд нэгдэж анхдагч арай том ширхэгийг үүсгэдэг. Тэгээд хоёроор бүрдсэн хос ширхгүүдийн хоёр хэсэг нэгдэж илүү том ширхгийг үүсгэдэг. Ингэж хослох нэгдлүүд нь янз бүрийн түвшний ширхгүүд төрөл бүрийн зүйлсийн гадаад хэлбэрийг бүрдтэл, мөн амь бодиуд, матери, агаар болон оршин тогтноход зайлшгүй шаардлагатай гэрэл, ус, цаг хугацаа, гэх мэтчилэнг үүстэл үргэлжилдэг. Ширхгүүд янз бүрийн хэлбэрээр нэгддэг, үүнийг бид өнөөдөр үелэх дараалал гэж нэрлэдэг.

Ширхгүүдийн янз бүрийн үелэх дараалал нь тухайн давхаргын гадаргуйн төрөл бүрийн бие бодийг үүсгэдэг. Ийм байдлаар үргэлжлэн улам том ширхгүүд болон томорсоор, микро жижгээс макро том болон нэгдсээр эцэст нь өнөөдөр бидний мэдэх гадаргуйн матери болох нейтрино, кварк, электрон, протон, атомын цөм, атом, молекулууд болон түүнээс бүр том тэнгэрийн эрхсүүд болдог. Энэ гадаргуйн бүрэлдсэн материйн үелэх дараалал янз бүр байдгаас гадаргуйн материйн төрлүүд бас их олон янз болдог. Гэхдээ мод молекулаас, төмөр нь молекулаас, хуванцар ч гэсэн молекулаас бүрддэг гэдгийг бид бүгд мэднэ. Бидний орон зайн ус хүртэл бичил уснаас тогтдог, энэ нь бичил ус нэгдсээр том

ширхгүүд болж, улмаар тэр том ширхгүүд нэгдэж усны молекулуудыг үүсгэдэг. Тиймээс бид гадаргуйн бие бодь нь бүр бичлээс үүсдэг гэж хэлдэг. Нэмж хэлэхэд бидний ойлгож байгаа сансар ертөнц бүхэлдээ уснаас бүтдэг, энэ ус нь туйлын өндөр нягтралтай бөгөөд огт хөдөлгөөнгүй. Энэ бүгд үүнээс л бүтсэн юм.

Та нар чулуунаас ус гаргаж авч чаддаг байсан зарим Дао нарын тухай эртний домог сонссон байх. Энэ нь бидний орчин үеийн хүний сэтгэлгээнд болон орчин үеийн шинжлэх ухааны төсөөлөлд тайлбарлагдашгүй мэт сонсогдсон ч, тэд чамайг домог эсвэл гайхалтай үлгэр ярьж байна гэж бодсон ч би хэлбэл энэ бол гарцаагүй үнэн, яагаад гэвэл бүх матери уснаас бүтдэг. Тэр ч бүү хэл усыг ган эсвэл төмрөөс ч гарган авч болно, мөн тэдгээрийг ус болгон хувиргаж болно. Бие бодь хичнээн хатуу байсан ч гэсэн түүний үндсэн ширхгүүд нь уснаас тогтдог. Хэрэв хүн Будда Фагийн бурханлаг хүчийг энэ өнцгөөс бодвол, үүнийг ойлгоход хэцүү биш гэж бодож байна. Энэ бол ийм их хүч чадалтай, тэр юмыг анхны материйн хэлбэрт оруулж чадна. Саяын ярьсан хэлбэр нь үе шаталсан байдаг, янз бүрийн томоохон түвшингүүдэд иймэрхүү өөр өөр төрлийн ус байдаг.

Бид бас өөр нэг байдлыг олж мэдсэн. Миний сая хэлсэнчлэн бидний энэ ус нь томоохон давхаргуудын ширхгүүдийг үүсгэдэг маш микро уснаас тогтдог, улмаар энэ усны молекулууд болон манай дэлхий дээрх усыг үүсгэдэг. Тэгвэл, өөр өөр түвшний давхаргуудын эх үүсвэр болсон ус нь хүний материаллаг ертөнцийн ширхгүүдээс бүр том ширхгүүдийн давхаргыг үүсгэдэггүй гэж үү? Тэгээд тэр түвшин дэх усыг үүсгэдэг биш гэж үү? Үнэндээ би сая хэлсэн, би энэ сансар ертөнцийг эцэст нь юу болохыг хэлж болохгүй. Гэхдээ би та нарт янз бүрийн түвшин дэх матери янз бүрийн эх үүсвэртэй байдаг гэж хэлж болно, өөрөөр хэлбэл бие бодийн эх үүсвэр болох өөр өөр ус байдаг. Түвшин өндөр байх тусам, усны нягтрал ихэсдэг, энэ нь өөр өөр орон зайд орших өөр өөр ширхгүүдийг, өөр өөр ус, өөр өөр амь бодиудыг үүсгэж болдог. Та нар бидний энэ орон зайд орших бүх зүйлс, хүний бие, ган, төмөр, бүгд амь бодиуд гэдгийг мэднэ. Өөрөөр

хэлбэл, бидний мэддэг, хүрч болдог, хүний нүдэнд харагддаг оршихуйнууд нь үнэндээ мөн л уснаас үүсдэг. Энэ хүний ертөнцийн ус нь, хамгийн гадаргуу дээрх хүний ус нь тэр анхдагч хөдөлгөөнгүй уснаас бүтсэн юм. Тэр зай бол маш хол. Мөн бидний хүний нүдээр харж болох амь бодь, зүйлс нь энэ уснаас бүтсэн. Хэрэв чи гартаа нэг ургамлыг базаад, базаад л байвал эцэст нь уснаас өөр зүйл үлддэггүй гэдгийг та нар мэднэ. Жимсний хувьд ч мөн адил. Одоо эрдэмтэд хүний биеийн далан хувь нь ус байдаг гэж хэлдэг. Гэхдээ тэд яс, үс хүртэл усны молекулаас бүрддэг гэдгийг мэддэггүй, тэдгээр нь зөвхөн илүү бичил уснаас бүрдсэн ширхгүүдээс л бүтдэг юм. Үнэндээ тэд бүгд ус, тэдгээр нь зөвхөн илүү бичил ширхгүүдээс л бүтсэн юм. Бидний энэ материаллаг орон зай дахь бүх зүйлс уснаас бүтсэн.

Бичил биесийн ширхгүүдийн үелэх дараалал янз бүр байдгаас төрөл бүрийн хэлбэрийн бодисуудыг үүсгэж чадна. Хэрэв чи ид шидийг үзүүлж чадвал ... Мэдээж, урьд өмнө олон хүмүүс ид шид үзүүлж байсан, усыг мөс болгон хувиргаж эсвэл ямар нэг зүйлийг өөр зүйл болгон хувиргачихдаг байсан. Энэ нь санаанд багтамгүй сонсогдож байгаа боловч огт төсөөлшгүй зүйл үнэхээр биш юм. Хэрэв чи ямар нэг зүйлийн молекулын үелэх дэс дарааллыг өөрчилж чадвал, энэ нь өөр нэг зүйл болно. Тэгвэл ямар нэг зүйлийн гадаад төрхийг яаж өөрчлөх вэ? Мэдээжийн хэрэг, гадаад төрхийг өөрчлөх нь бүр ч хялбар байдаг, гадаад төрх нь өөрчлөгдөнгүүт энэ нь өөр нэг зүйл болчихдог. Будда, Дао эсвэл Бурханы түвшин өндөр байх тусам, түүнд тэр хэмжээгээр ийм хүч байдаг. Та нар хүн бол маш чадваргүй гэдгийг мэднэ. Хэр чадваргүй вэ? Хэрэв хүн ямар нэгэн зүйл биелүүлэх эсвэл ямар нэгэн зүйл хийхийг хүсвэл гар, хөлөө ашиглах хэрэгтэй, биеийн хүчний хөдөлмөр хийх хэрэгтэй. Харин Буддууд тэгдэггүй. Буддууд зөвхөн бодоход л болно, бодол байхад л хангалттай, яагаад гэвэл Будда бурханлаг их хүч чадалтай, ер бусын олон чадвартай, мөн өөрсдийн хүчирхэг гон-той байдаг. Тэр гон-ын бичил ширхэг болгон нь Будда-гийн өөрийн дүр төрхтэй байдаг бөгөөд тэдгээр бичил ширхгүүд нь илүү бичил ширхгүүдээс бүтдэг, тэдгээр нь бүгд өөрсдийнх нь дүр төрхтэй байдаг. Бодоод

үз дээ, тэдний нэг бодол гарах мөчид гон нь гардаг. Туйлын бичил түвшнөөс эхлээд янз бүрийн түвшний ширхгүүдийн бүтцийг өөрчилдөг. Тэд хамгийн хурдан орон зайн цагийг ашигладаг болохоор үүнийг хоромхон зуур хийчихдэг. Буддууд бидний энэ орон зай ба цаг хугацаанд хязгаарлагддаггүй учраас аливаа зүйлийг маш хурдан хийдэг. Тэд биетийг хамгийн үндсэн сууриас нь эхлэн хоромхон зуур өөрчилж өөр зүйл болгон хувиргаж чаддаг. Энэ бол Будда Фа-гийн бурханлаг хүч үйлчилж байгаа хэрэг юм. Буддын бодол гарах агшин зуурт бие бодь яагаад өөрчлөгддөг вэ? Будда бодоход, түүний гон-ын тоо томшгүй олон ширхгүүд, хэмжээлшгүй билгүүн ухаан хоёул бүх түвшинд нэгэн зэрэг өөрчлөлт хийдэг, ерөнхийдөө гон нь түүний хийхийг хүссэн бүх зүйлийг хийж өгч байдаг, мөн түүний гон-ын том ширхгүүд нь бие бодийн гадаргуйг бас өөрчилж байдаг. Бие бодийн хамгийн үндсэн ширхгүүдээс түүний гадаргуйн ширхгүүд хүртэл нь, түүний гон биетийг бичлээс гадаргуу руу нэгэн зэрэг өөрчилж байдаг. Тэр энэ зүйлийг ганцхан хормын дотор л бий болгодог, тэр үүнийг хоромхон зуур хийж дуусгадаг. Юу ч зүгээр өөр зүйл болоод хувирчихдаггүй, харин тэр агаарт байгаа молекулууд болон ширхгүүдийг чиний харж болохуйц бие бодь болгон хувиргах чадвартай, энэ бол хоосноос ямар нэгэн зүйл бий болгох юм. Яагаад Будда Фа-гийн бурханлаг хүч нь маш хүчирхэг вэ? Хүн төрөлхтний шинжлэх ухаан, технологи хэзээ ч ийм түвшинд хүрч чадахгүй.

Будда Фа-гийн хүчийг хүн төрөлхтөн шинжлэх ухаан, технологийн аргаар хэзээ ч олж авах боломжгүй, яагаад гэвэл хүн төрөлхтөн ёс суртахууныг шинжлэх ухаан, технологийн дэвшлээр дээшлүүлэх боломжгүй юм, энэ бол боломжгүй. Нэмж хэлэхэд, хүмүүс энэхүү шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд, ямар нэгэн зүйлийг бүтээхийн тулд үргэлж маш хүчтэй зууралдсан сэтгэлээр ханддаг бөгөөд энэ нь Сансар ертөнцийн Фа зарчмуудыг зөрчиж байдаг. Тиймээс тэдний зан чанар тийм өндөрт хүрэх боломжгүй юм. Түүнээс гадна, хүмүүст янз бүрийн сэтгэл хөдлөл, хүсэл сонирхол байдаг, мөн тэмцэлдэж өрсөлдөх, атаархах, баярлах, шунах гэх мэт янз бүрийн зууралдсан сэтгэл байдаг.

Хэрэв шинжлэх ухаан, технологи үнэхээр тийм өндөр хөгжилд хүрч чадвал орчлон ертөнцөд оддын дайн дэгдэх болно, үнэхээр сансрын дайн болж магад. Гэхдээ Будда, Дао, Бурхад үүнийг зөвшөөрөхгүй, тэд хүн төрөлхтнийг сансар ертөнцөд үймээн самуун тарихыг огт зөвшөөрөхгүй, тиймээс Бурхад хүн төрөлхтнийг хязгаарлан барьж байдаг. Ёс суртахуун сайжрахгүй бол хүн төрөлхтний шинжлэх ухаан, технологийг өндөр түвшинд хүрэхийг нь яасан ч зөвшөөрөхгүй, энэ бол огт боломжгүй зүйл.

Хүн төрөлхтөн өнөөгийн үе шатанд ирэхээсээ өмнө янз бүрийн түүхэн үеийг туулсан гэж би олонтаа хэлдэг. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтөн түүхийн өөр өөр үеүдэд гамшиг сүйрэл тохиолдсоны дараа олон олон удаа устгагдаж байсан. Дараа нь шинэ хүн төрөлхтөн бий болдог. Бид янз бүрийн мөчлөгүүдийн дараа өнөөдөр ийм үед ирээд байна. Яагаад? Бясалгагчдын хүрээнд энэ нөхцөл байдлыг олж мэдсэн: Хүн төрөлхтөн аюултай үе шатанд тулж ирэх бүрд эсвэл түүхээс арчигдах тэр цаг үе болгонд хүн төрөлхтний ёс суртахуун туйлын доройтолд орсон үе байдаг байсан. Зарим хүмүүс Грекийн соёл иргэншил хичнээн агуу байсан тухай ярьдаг, гэтэл тэдгээр хүмүүс хаашаа алга болов? Өнөөдөр Грекийн соёлын ул мөрөөс зарим зүйлийг олж мэдэж болно: Грекийн өв соёлоос үлдсэн зүйлс бол Грекийн соёл иргэншлийн хөгжлийн сүүлчийн үеийнх гэдэг нь мэдээж, тэндээс ижил хүйтэн болох, садар самуун байдлын хажуугаар амьдрал нь үнэхээр үрэлгэн давилуун, мөн авилгалд автсан, хүн төрөлхтөн аль хэдийн аймшигтайгаар доройтсон байсныг бид харж болно. Яагаад энэ нь алга болсон бэ? Учир нь ёс суртахуун аль хэдийн унасан. Хүмүүсийг хүний дүр төрхтэй болохоор нь л хүн гэж нэрлэж болохгүй. Яагаад сүнсийг хүн гэдэггүй юм? Эцсийн эцэст, тэд чамаас ширхгүүдийн ганц л давхаргаар дутуу. Тэгвэл яагаад сармагчин, гориллыг хүн гэж нэрлэж болохгүй вэ? Учир нь хүнд зөвхөн дөрвөн мөч, бие байснаараа хүн болчихгүй, мөн хүний ёс суртахууны хэм хэмжээ, ёс суртахууны үнэт зүйлс байдаг. Хэрэв хүмүүс ёс суртахууны үнэт зүйлс, ёс суртахууны хэм хэмжээ, ёс зүйгээ алдвал тэд хүн гэгдэхээ болино. Тиймээс өнөөгийн хүний нийгэм ... илэн далангүй хэлэхэд, Бурхад хүмүүсийг хүн гэж үзэхээ

больсон гэдгийг би та нарт хэлье. Үүнийг боддоо: Хүмүүс аюултай байдалд байгаа юм биш үү? Танай засгийн газар ямар нэг зүйлийг зөвшөөрдөг, танай улс зөвшөөрдөг, танай үндэстэн зөвшөөрдөг, тэр ч байтугай чи үүнийг өөрийнхөө бодолдоо хүлээн зөвшөөрдөг, гэхдээ энэ нь сайн зүйл байх албагүй. Тийм ч учраас чи өнөөгийн нийгмийг ажиглавал хар тамхи, мансууруулах бодисын наймаа, мансууруулах бодис үйлдвэрлэх, хүйсээ өөрчлөх, ижил хүйстэн болох, сексийн эрх чөлөө, зохион байгуулалттай гэмт хэрэг гэх мэтчилэн төгсгөлгүй урсгалаар гарч ирж байгааг чи харж болно. Хувиа хичээх үзэл болон хүсэл сонирхол нь хүмүүсийг нэг нэгэндээ дайсан, ямар ч зөв бодолгүй болгосон. Доройтсон хүний нийгмийн бүхий л үзэгдэл хаа сайгүй элбэгшиж байна. Орчин үеийн урлаг гэгдэх зүйл, рок-н-ролл гэгддэг зүйл, болон хөл бөмбөгийн талбайд илэрдэг чөтгөрийн мөн чанар гэх мэтийн зүйлс бүх салбарт, ажил мэргэжилд байна. Эдгээр зүйлс нийгмийн бүхий л талыг хамарч байна. Хүний оюун санааны доройтол нь хүмүүсийн үнэт зүйлийг хөмрүүлж байна: Тэд сайныг муу гэж, мууг сайн гэж үздэг, хүний үнэ цэнэ урвуугаар эргэж байна. Хүчээр мөнгө олж авах, нэрд гарах, хувийн ашиг сонирхол, тэмцлийн философийг хүмүүсийн дунд сурталчлах, зохион байгуулалттай гэмт хэргийн толгойлогчдыг алдаршуулах... Хэл дээ, тэдгээрийг хүн гэж нэрлэсээр байх уу?

Өнөөгийн сургуулийн сурагчдыг харахад өмднийхээ бүсийг өгзгөн дээрээ бүсэлчихсэн, гуя хөлийг нь дагаад нарийн гэдэс шиг олон зүйл дүүжлээстэй, тал бүс нь доош салбаганан унжсан явдаг. Тэд толгойныхоо үсийг хоёр талаас нь халзалж хусаад, оройд нь дээврийн орой шиг үлдээчихсэн, зарим нь чөтгөр мэт голоороо залаа шиг зурвас үс үлдээчихдэг, тэд үүнийгээ сайхан харагдаж байна гэж боддог. Гэхдээ үнэхээр сайхан харагдаж байна гэж үү? Хэрэв чи үүнийг нухацтай харвал, тэдэнд гоо зүйн ямар ч ойлголт байхгүй. Зарим эмэгтэйчүүд дан хар хувцас өмсч, чөтгөр шиг үсний засалттай, яг л газар доорх ертөнцийн сүнс сүг шиг хүйтэн зэвхий царайтай байдаг. Энэ нь хүмүүн гэгдэх үнэт зүйлс урвуугаар эргэсэнтэй холбоотой. Чөтгөрүүд эмх замбараагүй

байдлыг өдөөж байгаагаас хүн төрөлхтөн хар бараан, дүнсгэр зүйлийг үзэсгэлэнтэй сайханд тооцдог болсон.

Би урьд нэг өдөр хэлсэн, мангас шиг, чөтгөр шиг, сүнс сүг шиг муухай тоглоомууд байх тусам илүү хурдан зарагддаг, хөөрхөн хүүхэлдэйг хэн ч худалдаж авдаггүй. Хүмүүсийн үзэл тэр чигтээ өөрчлөгдсөн. Та бүгд бодоод үз дээ, энэ нь аймшигтай биш гэж үү? Хүн төрөлхтний хөгжил нь үнэхээр давтагдах мөчлөгтэй байдаг. Ийм зүйл болохоос урьдчилан сэргийлэх цорын ганц арга зам нь: Хүний ёс суртахууныг хадгалахад юм. Чи харж байгаа, өнөөгийн үед нийгмийн асуудлууд ар араасаа гарч ирж байна, аль ч засгийн газар үүнийг шийдвэрлэх боломжгүй байна. Үндэстэн ястны асуудлууд, улс орон хоорондын асуудал, үндэстнүүдийн хоорондын зөрчил, үндэстэн доторх зөрчилдөөн, нийгэмд гэмт хэрэг гарах олон шалтгаанууд ... бүх засгийн газруудын толгойн өвчин болоод байна, хэн ч шийдэж чадахгүй байна. Тэд яагаад тэдгээрийг шийдэж чадахгүй байгаа юм бэ? Учир нь тэдний авч хэрэглэдэг бүх арга нь зөвхөн нэг асуудлаар нөгөөг шийдвэрлэхийг эрэлхийлдэг. Гэхдээ нэг байдлыг хязгаарлахад, илүү муу байдал гарч ирдэг. Дараа нь тэрийг дарахад түүнээс ч муу үзэгдэл гарч ирдэг. Хүн төрөлхтний гаргасан хуулиуд нь үнэндээ хүмүүсийг механикаар хязгаарлаж, тэднийг болон хууль тогтоогчид өөрсдийгөө хүртэл битүүмжилж байгаа юм. Хүмүүс өөрсдийгөө тувт битүүмжилсээр байна. Тэд битүүмжилсээр, битүүмжилсээр эцэст нь гарах гарцгүй болж хоцорсон. Хэт олон хууль гаргахад хүмүүс яг л амьтан шиг удирдуулдаг, үүнээс гарах гарцгүй болдог, тэгвэл хэн ч ямар ч шийдэл гаргаж чадахгүй.

Хүн төрөлхтний бүх өвчнүүдийн үндсэн шалтгаан нь үнэндээ хүний ёс суртахууны доройтол гэж би та нарт хэлнэ. Тэндээс эхлэхгүйгээр, хүн төрөлхтний ямар ч асуудал шийдэгдэхгүй. Үүнээс эхэлбэл хүн төрөлхтний бүх асуудлыг шийдвэрлэж болно. Энэ үнэн биш гэж үү? Бүгдээрээ бодоод үз дээ: Хэрэв хүн бүр үнэн голоосоо сайн хүн байхыг хичээвэл, биеэ барьж чаддаг, мөн хийж буй бүх зүйл дээрээ бусдыг эхэлж боддог, бусдыг хохироохгүйн тулд хийж буй үйлдлээ бусдын эрх ашигт нийцэх эсэхийг бодож

байвал төсөөлөөд үз, нийгэм ямар болох вэ, хууль хэрэгтэй байх уу? Цагдаа хэрэгтэй юу? Хүн бүхэн өөрийгөө барьж, хүмүүжилтэй байна. Харин улс төрийн суртал ухуулга, хүчээр захиргаадалтаар ёс суртахууныг эргээд сэргээж чадахгүй, харин ч тэд эсрэг үр дүнд хүргэнэ. Хүн бүр хууль эрх зүйн тогтолцоог сайн гэж үзсэн үзлээр дэлхий ертөнц өнөөдрийг хүртэл хөгжиж ирсэн. Үнэндээ энэ бол гарах гарцгүй болсон үед хамгийн сүүлчийн найдвар юм. Хүн төрөлхтөн хэдэн мянган жилийн турш хөгжиж ирсэн. Урьд өмнө нь ийм олон хууль хэзээ ч байгаагүй, зөвхөн энгийн “Хааны хууль” гэж л байсан, мөн буян (дэ) нь сайн ба мууг цэгнэх шалгуур болдог байсан. Эртний хүмүүсийн ёс суртахуун нь өнөөгийнхөөс хавьгүй өндөр байсан. Өнөө үед хүмүүс эртний хүмүүсийг сайнгүй байсан гэж боддог. Үнэндээ чи орчин үеийн хүмүүсийн доройтсон үзэл бодлоор эртний хүмүүсийг дүгнэж байгаа учраас тэр юм. Урьд үеийн хүмүүс одоогийн хүмүүсээс дутахааргүй ухаалаг байсан. Хүний тархины ашиглаж болох хэсэг хэзээ ч нэмэгдэж байгаагүй, одоогийн хүмүүс өөрсдийгөө зөвхөн их мундаг, маш ухаалаг гэж үздэг.

Нийгмийн хөгжил Бурхадаар бас зохицуулагддаг. Тэд чамд энэ үе шатанд хүртэл хөгжих орчин үеийн техник хэрэгсэл, орчин үеийн тоног төхөөрөмж, орчин үеийн тохь тухтай байдлыг олгодог. Эртний хүмүүст эдгээрийг бүтээх санаа төрөөгүй гэж үү? Бурхад тэр үе шатанд үүнд хүрэхээр зохицуулаагүй л юм. Орчин үеийн хүмүүс эртний хүмүүсээс илүү ухаантай гэсэн үг биш. Гэхдээ материаллаг зүйлс улам их хөгжих тусам, хүмүүс энэ материаллаг нөхцөл байдалд улам автдаг. Тэд энэ бүгдийг гайхамшигтай ололтууд, эртний хүмүүс хийж чадаагүй, орчин үеийн хүмүүс бид мөнхрөгч хүмүүсээс бараг ялгаагүй, өчигдөр чи Европоос нисээд, өнөөдөр Америкт ирчихсэн байна, яг л мөнхрөгч хүн шиг. Би та нарт хэлье, эдгээр нь энэ өргөн уудам орчлон ертөнцөд аль эрт оршиж байсан, тэд өөр ертөнцөд удаан хугацаагаар оршин тогтнож ирсэн. Тэнгэрийн хүмүүс муу болсноор хүн төрөлхтний байгаа энэ газарт унаж ирсэн юм-энэ дэлхий дээр. Бүх хүний оюун ухаан төрөхийн өмнөх ухамсартай байдаг, тэд өөрсдийгөө зүгээр л мэддэггүй юм. Тэр “Шинжлэх ухаан, технологийн хүчээр” гэдэг

нь, “манай шинжлэх ухаан, техник технологи ямар дэвшингүй байна вэ” гэдэг нь, тэдгээр “зохион бүтээсэн онгоц, машинууд”, тэдгээр “орчин үеийн зүйлс” ... Үнэндээ би хэлбэл энэ бүхэн нь зөвхөн өнгөрсөн үеийн зүйлс чиний ой ухаанд хадгалагдаж үлдсэн юм, мөн энэ хөглөрсөн хогон дотроос, хамгийн гадаргуйн болхи материалаар хийж бүтээгдсэн зүйлс юм. Хүмүүс эдгээрийг дажгүй сайн гэж боддог. Мэдээжийн хэрэг, хүн төрөлхтөн ийм байдлаар унаж ирсэн. Тэд муу болсон болохоор, энэ давхаргад унаж ирсэн, зовлон бэрхшээлийг тэвчих ёстой болсон. Хүн төрөлхтний хөгжил нь хүний хүссэн замаар явагдах боломжгүй, мөн хүнийг хүссэн зүйлээ хийхийг нь зөвшөөрөхгүй, эсвэл тэднийг тохь тухтай байлгах хүссэн болгоныг нь мөн зөвшөөрөхгүй, энэ бол огт хүлээн зөвшөөрөгдөхгүй зүйл. Ийм учраас хүн төрөлхтөн аюултай нөхцөл байдалд байна. Чамд хэн нэгэн ийм ч сүйрлийн тухай, өөр нэг хүн тийм ч сүйрлийн тухай ярьж байхад, би эдгээр зүйлийн талаар хэзээ ч ярьдаггүй, энэ нь ямар ч хэрэггүй юм. Тэр нь болох болохгүйн талаар би ярьдаггүй. Болсон ч гэсэн манай бясалгагчдад, эсвэл сайн хүмүүст ямар ч нөлөөгүй. Гэхдээ хүмүүс одоогийн ийм байдалд тулж ирэхэд, өөрсдийн асуудлыг шийдэж чадахгүйгээс асуудал үүсдэг, хүмүүс гарах гарцгүй байдалд орсон, энэ нь үнэхээр хүн төрөлхтний ёс суртахууны доройтлоос үүдэлтэй юм. Нэгэнт бид амь бодийн үүслийн талаар, орон зайн талаар ярилцсан болохоор, дахиад хүн төрөлхтний талаар ярьж байна. Матери хүнийг бий болгож чадна, яагаад гэвэл бөөмс нэгдэж өөр бодис үүсэхэд тэдгээр нь хүний гадаргуйн өөр өөр бие бодь болж нэгддэг. Молекулуудын үелэх дараалал нь ясны ширхгүүдийнх байхад, гадаргуйн бие бодь нь яс болно. Тэдгээр үелэх дараалал нь махан биений молекулуудынх бол, тэдгээр нь мах бодь болно. Тэдгээр нь ямар л үелэх дараалалтай байна тийм болно. Энэ нь чиний оршихуйг бүрдүүлдэг, үүнийг хэлэхэд амархан.

Дөнгөж сая би өөр асуудлын талаар ярилаа. Маш олон хүн Бурхад хүнийг бүтээсэн гэж хэлдэг. Зарим нь хүнийг шавраар бүтээсэн талаар ярьдаг. Бид хүнийг яаж бүтээсэн талаар тусгайлан ярихгүй, үнэндээ хүнийг бүтээх янз бүрийн арга байдаг. Аугаа Бурханы ганц бодол л чамайг бүтээж чадна. Бүх зүйл амьтай.

Чиний гадаад төрхийг бүтээсний дараа дотоод эрхтэнүүдийг чинь бүтээдэг. Хүмүүс хүний бие махбодийг туйлын нарийн цогц гэж боддог ч, Аугаа билгүүн ухаант, агуу гэгээрсэн Бурхдын хувьд энэ нь шалихгүй зүйл юм. Буддагаас ганц бодол гарахад л чиний дотоод эрхтнүүдийг туйлын бичил түвшны бие бодиор бүтээж чадна, тэр хоромхон зуур хийж чадна. Аливаа зүйл бий болонгуут, түүнд амь ордог. Мэдээжийн хэрэг, хүнд бас Дэд сүнс (Фу юаншэнь) байдаг, олон олон амь бодиуд нэгдэж байж хүн үүсдэг. Энэ бол ингэж л явагддаг.

Урьд өмнө шинжлэх ухааны салбарын хүмүүс тахиа анхдагч уу эсвэл өндөг анхдагч уу гэдэг дээр толгойтой үсээ зулгаадаг байсан, энэ тал дээр мэтгэлцэх дуртай байсан. Би тахиа, өндөгний алийг нь ч анхдагч гэхгүй. Энэ бол ердөө л бичил бие бодь нь том бие бодийг бүрдүүлдэг, жижиг ширхгүүд нь том ширхгүүдийг бүрдүүлдэг, гэхдээ матери материйг үүсгэдэг гэж хэлдэггүй. Хэдийгээр том амь бодийн биеийг бүрдүүлж байгаа ширхгүүдийн эзлэхүүний хэмжээ биднийхээс өөр, гаднах хэлбэрийн хэмжээ өөр байдаг, гэхдээ амь бодийг бүрдүүлж буй гадаргуйн бие бодийн ширхгүүдийн үелэх дараалал нь амь бодиудын том жижгээс үл хамааран ижил байдаг. Жишээлбэл, хэрэв арай том давхаргын хүний биеийн ширхэг бүр нь гаригсын давхаргын ширхгүүдээс бүрддэг бол, түүний махан бие нь бидний хүний биеийн молекулын үелэх дараалалтай адилхан. Өөрөөр хэлбэл, гаригсын үелэх дараалал нь махан биеийг бүрдүүлдэг бидний молекулын үелэх дараалалтай ижил байдаг. Тиймээс арай жижиг эсвэл бүр жижиг давхаргын хүмүүс мөн ийм байдлаар бүрэлдэн үүсдэг. Энэ талаар ийм л зүйл хэлье.

Өнөөдрийн хувьд, энэхүү орчлон ертөнцийн бүтцийг дэлгэрэнгүй тайлбарлалаа. Мэдээж, нарийн ширийн зүйлийг хэлж болохгүй. Зарим хүн надаас “Багш аа, бид Буддууд хэрхэн амьдардаг талаар мэдмээр байна” гэж асуусан. Би “Тэгвэл чи өөрийгөө Буддад бясалга” гэж хариулсан. Буддууд хэрхэн амьдардгийг хүмүүст мэдүүлэхийг зөвшөөрөхгүй. Хүмүүст ийм ойлголт огт байдаггүй. Хэрэв би чамд хэлчихвэл, чи тэдэнд хүний

сэтгэлийн хөөрөл, хүний бодол, хүний үзэл бодлоор хандана, энэ нь тэднийг доромжилж, үл хүндэтгэсэнтэй адил болно. Тиймээс бид чамд тодорхой хэлж болохгүй. Би чамд зөвхөн хүний хязгаарлагдмал хэлээр ерөнхий байдлыг л хэлж өгч болно. Үнэндээ өнөөдөр бид үүнийг заахын тулд Хятад хэлийг сонгосон нь илүү тохиромжтой байж чадсан, яагаад гэвэл Хятад хэл нь дэлхийн аль ч хэлнээс утга санаа илэрхийлэлтээр давуу, хамгийн гүн агуулгатай хэл юм. Англи хэл юмуу эсвэл өөр хэл хэрэглэсэн бол илэрхийлэх боломжгүй байх байсан. Би тайлбарлахдаа зарим нутгийн хэллэгийг ашигладаг. Орчин үеийн хялбарчилсан хятад хэлээр ч гэсэн тодорхой тайлбарлах боломжгүй, та нар миний үгэнд орон нутгийн зарим хэллэг байгааг анзаарсан байх, миний үгний сонголт нь уламжлалт бус юм, шинэ хэлбэрийн багуу бичмэл гүн утга санаа агуулдаггүй. Хэрэв ийм байдлаар хийгээгүй бол Фа-г илэрхийлэх ямар ч боломжгүй байсан.

Хүн болгоны санаа зовдог өөр нэг асуудлын талаар би ярьж. Зарим хүмүүс “Багш аа, би бясалгаад л байна, гэхдээ юу ч харж чадахгүй юм” гэж хэлдэг. Хүмүүсийн яагаад харж чаддаг, чаддаггүйн талаар ярилцъя. Үнэндээ би тэнгэрийн мэлмийн тухай ярихдаа үүнийг тайлбарласан. Хүмүүст тавигдах шаардлага өндөр, зарчим ч байнга дээшилж байдаг. Хэрэв би цааш тайлбарлавал, энэ ойлголтоос давж гарах болно. Гэхдээ би үүнийг сүүлд ярьсантайгаа холбохыг хичээе. Би үүнийг чамд цааш нь тайлбарлаж өгье.

Энд сууж байгаа та нарын ихэнх нь үнэхээр төрөлхийн суурь сайтай. Үнэндээ бясалгал хийж эхэлсэн үеэс өнөөдрийг хүртэл, богино хугацаа байсан ч гэсэн та нар зарим зүйлийг харах боломжтой. Жуан Фалунь номонд хүний зууралдсан сэтгэлүүдийг арилгах хатуу шаардлагыг онцолсон байдаг учраас олон хүн харахыг зориглодоггүй. Олон хүн бүдэг бадаг зүйлийг харсан ч, итгэж зүрхэлдэггүй. Чиний харж чадахгүй байх хэд хэдэн шалтгаан бий. Эхнийх нь зарим хүн: “Хэрэв би ямар нэгэн зүйл харвал, энэ материаллаг ертөнцөд хардаг шиг тод байх ёстой. Тэгвэл л итгэнэ” гэдэг. Энэ бол үнэхээр хүчтэй саад тотгор юм. Тэд энэ асуудлыг үргэлж хүний бодол, хүний сэтгэхүйгээр ойлгодог. Энэ нь тийм

биш юм. Хэрэв чи үнэхээр тийм тод харж чадах юм бол Төгс гэгээрэлд хүрсэн гэсэн үг, чи зуун хувь гэгээрсэн болно. Тэр үед чи хүмүүсийг хардгаас илүү тодорхойгоор Бурхдыг харах болно. Тэдгээр ертөнцөд стереоскопийн мэдрэмж нь биднийхээс илүү хүчтэй, агаар нь биднийхээс илүү тунгалаг, матери нь биднийхээс илүү нягт байдаг тул чи илүү тодорхой харах боломжтой. Та нарын зарим нь харж чаддаггүйн нарийн учир нь чи тодорхой харвал л үнэхээр харсан гэж үздэг ойлголттой байдаг, гэхдээ тийм биш юм. Чиний бясалгалын явцад аливаа зүйлийг чамд тийм тод харахыг зөвшөөрөхгүй, чи зөвхөн бүдэг л харна. Нэлээд тодорхой харж чаддаг цөөн тооны хүмүүс байдаг, гэхдээ тэдний харж байгаа зүйл бол зөвхөн нэг хэсэг л юм, харах талбай нь нарийн. Тэд зөвхөн тухайн хэсгийг л тод харж чаддаг. Хэрэв хүний харах талбай өргөн бол түүний хардаг зүйл харьцангуй бүдгэрэх нь дамжиггүй, тийм тод харж чадахгүй, эсвэл тэр зөвхөн их доод, цөөн хэдхэн орон зайг л харж чадна. Тиймээс бид хүмүүсийн бодит, материаллаг үнэт зүйл гэгддэг зүйлсээр өөрсдөдөө саад учруулах ёсгүй. Энэ бол нэг шалтгаан юм. Гэхдээ үл хамаарах зүйлүүд бас байдаг. Төрөлхийн тодорхой харж чаддаг цөөн хүмүүс байдаг, би энэ талаар ярихгүй.

Өөр нэг шалтгаан бол та нарын олонх нь харж чадахгүй гэсэн үг биш, та нар харж чадна, гэхдээ та нар үүнийг үргэлж хуурмаг зүйл, үргэлж санаа дагасан зүйл гэж боддог. Заримдаа ийм байдал эхний үе шатанд гардаг. Би энэ талаар Жуан Фалунь номонд тусгайлан дурьдсан, бодлын нөлөө оруулж болохгүй, харсан зүйл чинь бодлын дагуу өөрчлөгдөнө гэсэн болохоор бидний зарим нь энэ үгний наад цаадахыг бодолдоо зөв тунгаадаггүй. Чиний зууралдсан сэтгэл, баярлах сэтгэлийн хажуугаар бас өөр саад тотгор байдаг. Ямар саад вэ? Жишээлбэл, чи оюун ухаандаа юу бодож байгаа, харж байгаа зүйлийн дүр төрх чиний тархины нэг хэсэгт хамтдаа тусгагдаж байдаг, үр нөлөө нь тархины тэр хэсэгт үүсдэг. Хүмүүсийн харж байгаа зүйлсийн дүрс нүдэнд шууд тусгагддаггүй, харин харааны мэдрэлийн судлаар дамжин тархины булцуут булчирхай дээр тусгагдан харагддаг. Гэсэн хэдий ч, чиний бодож байгаа зүйл оюун санаанд чинь буухад мөн тархины тэр

хэсэгт дүрс нь тусгагдаж байдаг. Тиймээс энэ нь хуурамч сэтгэгдэл төрүүлдэг: Чи ямар нэгэн зүйлийг үнэхээр харсан ч энэ нь эхэндээ бүдэг бадаг байдаг учраас чи түүнийг өөрийн төсөөлөл гэж боддог. Үнэндээ энэ бол чиний төсөөлөл биш, чи үнэхээр үүнийг харсан юм.

Урьд өмнө олон жижиг бясалгалд шавь нараа сургахдаа оюун ухаандаа төсөөлөхийг тусгайлан шаарддаг байсан. Хэрэв чи харж чадахгүй бол, оюун санаандаа төсөөл гэж заадаг байсан. Яваандаа чи улам их төсөөлөх тусам энэ нь улам бодит болно, тэдэнд ингэж сургадаг байсан. Жижиг бясалгалын замаар яваад төгс гэгээрэлд хүрэхэд маш хэцүү, учир нь тэдэнд орхигдуулсан зүйл байдаг, энэ төсөөлөл нь өөрөө зууралдсан сэтгэл юм. Чамаар ямар нэгэн зүйл харуулах гэдэг, чи харж чадахгүй, чи санаандаа төсөөлнө, нарийн харах гэж их хичээнэ, нүдээ аниад улам сайн төсөөлж бодно, их бодох тусам илүү бодит болж ирнэ, аажмаар чиний төсөөлөл үүнийг бодит болгоно. Тэд жижиг бясалгалын аргаар ингэж л сургадаг. Эдгээр нь жижиг бясалгалын арга байсан болохоор, тэд үүнийг зууралдсан сэтгэл болохыг мэддэггүй байсан. Ер нь тэд гэгээрлийн талаар ч яриагүй.

Бид эдгээр асуудлыг маш нухацтай авч үздэг. Аливаа зууралдсан сэтгэл нь чиний Төгс гэгээрэлд хүрэхэд нөлөөлнө. Би чамд энэ асуудалд саруул ухаантай байгаарай гэж хэлье. Чи харсан зүйлээ магадгүй төсөөлөл гэж үздэг, гэхдээ чи ингэж бясалгаж болохгүй. Жишээлбэл, хэн нэгэн Фалунь-ийг бүдэг харсан, гэхдээ үүнийг өөрийнх нь төсөөлөл гэж бодсон, хэрвээ чи үүнийг хөдөлж, эргэж байгааг нь харсан бол, чи үүнийг харсан гэж би чамд хэлнэ. Миний хэлсэн дагуу хийж үзэж болно, юу болохыг нь хараарай. Би зөвхөн тэдгээр харсан зүйлээ хий төсөөлөл гэж бодсон шавь нарын тухайд л ярьж байна. Үүнийг мэдэрдэггүй хүмүүсийн хувьд, төсөөлөх гэж хүчилж хэрэггүй, тэгвэл зууралдсан сэтгэл болно. Чиний оюун санааны саад бэрхшээлийг арилгахын тулд л би чамд үүнийг хэллээ. Үүнд зууралдаж болохгүйг анхаар, зууралдахгүй гэдэгтээ баттай байгаарай.

Нью Йорк хот, уулзалтын үед заасан Фа

1997 оны 3-р сарын 22

Маргааш болох чуулганы өмнө та нарт асуух зүйл байгаа эсэхийг мэдмээр байна, та нар өнөөдөр асууж болно.

Асуулт: Нөхрийнхөө мөнгийг зарцуулах нь буянаа алдаж байгаа хэрэг мөн үү?

Багш: Эхнэр нөхөр хоёрын харилцаа ийм л байдаг, энэ бол асуудалгүй. Та нар яагаад ийм асуулт одоо тавьж байна вэ? Яагаад гэвэл хүмүүсийн эдгээр ёс зүй гажсан учраас юм. Өнөө үед зарим хүмүүс эмэгтэйчүүдийн эрх чөлөөг өмгөөлдөг, энэ бол эмзэг асуудал. Зарим хүмүүс “Эмэгтэйчүүд бид хэтэрхий их дарлуулж байна, эмэгтэйчүүдийг эрх чөлөөтэй болгох ёстой, эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй байх ёстой, эмэгтэйчүүд бид илүү хүчтэй байх ёстой.” гэдэг. Яагаад ийм байдал гарах болов? Учир нь зарим эрчүүд эмэгтэйчүүдэд аймшигтай ханддаг, үүнд хэнийг буруутгах вэ. Энэ нийгэм доройтох үед, хүмүүс доройтлын цаад хүчин зүйл, эсвэл доройтол хэрхэн үүссэнийг олж харахад маш хэцүү байдаг гэж би та нарт хэлнэ, хүн бүр асуудлыг дотроос нь авч хэлэлцэх дуртай.

Үнэндээ би та нарт хэлэхэд, эмэгтэйчүүдийн эрх чөлөө гэх энэ төрлийн ухуулга сурталчилгаа нь хүн төрөлхтний доройтлын дараа л гарч ирдэг. Зөвхөн эрчүүд эмэгтэйчүүдтэй зүй бус харьцаж байгаадаа биш, харин эрчүүд эрчүүдтэйгээ зүй бус харьцдаг, эмэгтэйчүүд бас эмэгтэйчүүдтэйгээ зүй бус харьцдаг, эрчүүд эмэгтэйчүүдтэй зүй бус харьцдаг, эрчүүдийн эмэгтэйчүүдтэй зүй бус харьцдаг нь мэдэгдэхүйц их байдаг. Үнэндээ хүчирхэг эмэгтэйчүүд ч бас эрчүүдтэй зүй бус харьцдаг. Энэ нь бүх нийгмийн ёс суртахууны доройтлоос үүдэлтэй юм. Үнэн хэрэгтээ, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын харилцаа нь хүч чадал, уян

зөөлөн байдлын хооронд л байдаг, тиймээс эмэгтэйчүүдийг эрчүүд дарангуйлах нь илүү илэрхий байдаг. Гэхдээ би яагаад энэ байдлыг буруу, мөн эмэгтэйчүүдийг өмгөөлсөн “хараат бус байдал”, “өөрийн хүчинд тулгуурлах”-ыг сурталчлах нь буруу гэдгийг бас хэлье. Өнөөгийн хүмүүс эртний хүмүүсийг орчин үеийн хүмүүсийн доройтсон үзэл бодлоор үргэлж шүүмжилж, эрт дээр үед эмэгтэйчүүд дарлагдаж байсан гэж боддог. Орчин үеийн хүмүүсийн төсөөлдөг шиг огтхон ч тийм байгаагүй юм. Эртний Хятадад мөн бүх дэлхий даяар, Барууны нийгэмд ч бас адилхан, эрчүүд эхнэртэйгээ хэрхэн харьцахаа мэддэг, эхнэртээ анхаарал халамж тавьдаг байсан, мөн эхнэрүүд нь ч бас нөхрүүддээ анхаарал халамж хандуулахаа мэддэг байсан - энэ нь арга ба билиг зэрэгцэн оршиж байсан. Хэрэв хоёр “арга” бие биетэйгээ шөргөлцвөл хоорондоо зодолддог, хэрэв хоёр “билиг” нийлбэл бас болдоггүй. Арга, билиг хоёр нь бие биенээ нөхөн дэмжиж байдаг бөгөөд нэг нэгнээсээ хамааралтайгаар ийнхүү зэрэгцэн оршиж байдаг.

Гэхдээ өнөө үед бүгд бодоод үз дээ: эмэгтэйчүүдийн эрх чөлөөг дэмжвэл, эмэгтэйчүүд дарангуйлагдаж байна, босох ёстой гэж боддог. Гэхдээ дараа нь юу болдог вэ? Гэр бүл салалт, тэмцэл зодоон, хаягдсан хүүхдүүд болон нийгмийн бусад асуудлууд гарч ирдэг. Үүний гол шалтгаан нь эмэгтэйчүүдийн эрх чөлөөнд биш, харин хүний нийгмийн ёс суртахууны доройтол юм, энэ нь шалтгаан нь биш гэж үү? Энэ бол үндсэн шалтгаан. Асуудлыг шийдвэрлэхдээ, үндсэн шалтгааныг нь авч үзэхгүй, харин тухайн байдлыг тэр л хүрээнд шийдвэрлэдэг, энэ нь зөвхөн хуучин асуудлыг шийдвэрлэх нөлөө үзүүлнэ, гэвч шинэ асуудлууд гарч ирдэг, нийгэм байнга гажуудсан хөгжлийн замаар явна. Өнөөгийн нийгэмд олон хүмүүс асуудлыг шийдэхдээ тухайн хүрээнд л авч үздэг, хямралыг тэмцлийн замаар шийдвэрлэхийг хичээдэг, хэзээ ч энэ байдлаар шийдэж чадахгүй. Сүүлийн үед яагаад ийм байдалтай болсныг хүн төрөлхтөн мэдэхгүй. Тэд ямар нэгэн зүйлийг авч хэлэлцэхдээ үргэлж тэр зүйлийнхээ хүрээнээс гардаггүй, хязгаарлалт тогтоохын тулд янз бүрийн хууль гаргадаг. Гэхдээ хүмүүсийн сэтгэл зүрх сайнгүй байхад шинээр гажуудсан бүр муу асуудал үүдэн гардаг, тэгэхэд тэд бүр олон хууль гаргадаг. Хүн

төрөлхтөн өөрсдийгөө ингэж боймилж байдаг, тэгээд эцэст нь өөрсдийгөө огт гарах гарцгүй болтол нь боймилчихдог. Үүнээс гадна эдгээр зүйлс нь нийгмийн маш олон бэрхшээлийг дагуулдаг.

Арга билгийн онолоор бол эм нь зөөлөн, ширүүн биш байх ёстой. Эр нь арга талд харьяалагдах бөгөөд хүчтэй байхад, эм нь билиг талд харьяалагддаг, зөөлөн. Хүч чадал ба уян зөөлөн байдлыг нэгтгэвэл үнэхээр эв найртай байх нь лавтай. Өнөө үед эрчүүд эмэгтэйчүүдтэй зүй бус харьцах дуртайдаа биш, харин энэ нийгэм доройтсоноос юм. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс аль аль нь зүй бусаар харьцаж байна. Үүний зэрэгцээ, орчин үед арга ба билиг урвуугаар эргэж байна. Энэ нь Хятадад хамгийн их ажиглагдаж байна. Тамирчдыг хар л даа, эмэгтэйчүүд илүү олон медаль авдаг бол, эрчүүд ховорхон авдаг. Би зөвхөн энэ санааг л илэрхийлж байна. Яагаад бүх зүйл дээр билиг нь маш хүчтэй, арга нь маш сул байна вэ? Энэ хүчин зүйл нь арга, билиг урвуу эргэснээс үүдэлтэй юм. Мөн эмэгтэйчүүдийн эрх чөлөөг хамгаалах нэрийн дор бас гаж нөлөө гарч байна. Энэ бол нийгмийн ёс суртахууны доройтол нь нийгэм дэх хүмүүсийн зүрх сэтгэлд өөрчлөлт оруулах шалтгаан болж байгаа юм. Үнэндээ эмэгтэйчүүд дотроо бол нөхрүүдээ хонь шиг эсвэл эмэгтэй хүн шиг байхад нь дургүй байдаг, тийм биз дээ? Тэд нөхрүүдийнхээ эршүүд биш, хүчирхэг хатуу чанга байж чадахгүйг нь үзэн яддаг. Гэхдээ эрчүүд нь хүчирхэг, хатуу байхад эмэгтэйчүүд бас тэвчиж чаддаггүй. Энэ үнэн биз дээ?

Хүмүүс хүн төрөлхтний бүх үзэгдэл, бусад бүх зүйлийн доройтлын үндсэн шалтгааныг хайхаа мэддэггүй. Тэд тухайн асуудлыг тэр хүрээнд нь л шийддэг, энд асуудал гарахад тэд хууль баталдаг, тэнд асуудал гарахад тэд бас л хууль баталдаг, улмаар чи торонд орсон мэт битүүмжлэгддэг, хөдөлж чадахгүй болдог. Эцэст нь хуулиуд гарах гарцгүй болгоно. Хууль санаачлагчид бүгд бусдыг зохицуулахыг хүсдэг, хууль нь эргээд тэднийг зохицуулна гэдгийг бодож үздэггүй. Хүмүүс өөрсдийнхээ зохиосон зүйлээсээ болж зовж шаналж байна, тийм биш гэж үү? Тийм учраас чи нийгмийн хөгжлийн гажуудсан урсгалыг дагаж болохгүй, давалгаанд бүү авт, “Нэгэнт энгийн хүмүүс ингэж хийж байгаа

болохоор бид тэдний аясыг нь дагана” гэж давалгаанд бүү түрлэг нэм. Энэ бол, бид энгийн хүмүүс шиг байж болохгүй гэж миний хэлдгийн учир нь юм. Энгийн хүмүүс эдгээр зүйлийг харж чадахгүй.

Хүн төрөлхтний эцсийн гарах гарц нь хүмүүсийг нэг шугаманд барих багц хуулинд бус харин дэлхий даяар буян (дэ)-г эрхэмлэхэд оршино. Хэрэв хүмүүсийн ёс суртахуун сайжирвал, хүмүүс бусадтай зүй бусаар харьцах гэх мэтийн зүйл үгүй болно, харин хүмүүс бие биенээ хүндэтгэх болно, тэгвэл ийм олон муу хүмүүс байсаар байх уу? Цагдаа ч хэрэггүй болно биз дээ. Хэрэв би “цагдаа харж байна” гэхээсээ илүүтэй өөрийгөө зөв авч явбал, цагдаа ямар хэрэгтэй юм? Хэрэв хүн бүхэн буяныг эрхэмлэдэг бол, хууль тогтоомж ямар хэрэгтэй гэж? Та бүгд мэднэ, эртний Хятадад болон дэлхийн бусад улс орнуудад ч мөн адил, хүний ёс суртахууны хэм хэмжээ маш өндөр байхад, эдгээр хууль байдаггүй байсан. Тэдэнд хууль байгаагүй! Зөвхөн маш энгийн Хааны хууль л байсан. Хүмүүс ёс суртахууныг сайн ба мууг цэгнэх шалгуур болгон ашигладаг байсан. Чиний хийсэн зүйл зөв байсан эсэх нь чиний ёс суртахууны хэмжээнээс хамаарна. “Энэ хүнд буян байхгүй” гэсэн өгүүлбэр л түүнийг шүүнэ. Газар, орны шүүгчид хэргийг ийм байдлаар шийдвэрлэдэг байсан. Буянгүй хүнийг хулсаар ташуурдана, хэрэв энэ нь хангалтгүй бол толгойг нь авдаг. “Энэ хүн, хүн биш болсон, толгойг нь ав” гэдэг байсан. Тэрээр хүний ёс зүйг завхруулсан тул түүнийг зүйл дуусгадаг. Энэ ертөнцөд амьдрахад хүмүүст хүний ёс суртахууны хэм хэмжээ, хүний зан үйлийн дэг жаяг байдаг. Энэ бүх зүйлээ алдвал тэд яг амьтантай адил, тэгэхээр тэднийг байлгах хэрэг байна уу? Тэд устгагдах ёсгүй гэж үү? Өнөөдрийн хүн төрөлхтний үзэл бодлыг эргүүлэхэд маш хэцүү болсон. Өнөөдөр эмэгтэйчүүдэд гарч байгаа нөхцөл байдлыг та нар харж байгаа. Гэхдээ бусад талбарт ч бас адилхан байгаа биз дээ? Хүний нийгэмд нийгмийн асуудал хэтэрхий их гарах болсон. Цорын ганц гарц бол хүмүүсийн зүрх сэтгэлийг зөв болгох явдал юм.

Асуулт: Залуу хүмүүс гэрлэхийг хүсдэг. Энэ нь зууралдсан сэтгэл мөн үү?

Багш: Цагаан арьстнууд болон бусад үндэстэн ястнууд битгий хэл, Хятадад ч гэсэн сүм хийдэд очдог хүмүүс олон биш, хэрэв би лам болоод, сүм хийдэд энэ Фа-г заасан бол, нийтийн дунд байгаа Фа-г үнэхээр олж авч чадах хүмүүс өргөн хэмжээнд Фа-г олж авах боломжгүй байх байсан. Би үүнийг нийгэмд зааж байгаа болохоор та нарт Фа олж авах боломж олгохын тулд энэ хэлбэрийг ашигласан, бид энэ нийгэмд нийцсэн арга замыг сонгох хэрэгтэй, хүмүүсийн амьдралын энгийн хэв маягт нийцсэн, мөн хүмүүст бясалгах боломж олгох аргыг бид хэрэглэх ёстой. Тиймээс бид Фа заах хэлбэрт болон янз бүрийн зүйлсийн талаар нарийн зохицуулалт хийсэн юм.

Хэрэв би сүм хийдэд очсон бол, гэрлэхгүй байх байсан. Гэхдээ ирээдүйд энэ Фа-г сурах олон хүмүүс байх болно гэдгийг би бас мэдэж байсан. Ирээдүйд хүн бүр үүнийг мэдэх болно, чи цагаан арьстан байсан ч, шар арьстан, эсвэл ямар ч төрлийн хүн байсан үүнийг мэддэг болох нь дамжиггүй. Тэгвэл асар том асуудал гарах байсан: Хэн ч гэрлэхгүй болчихвол, юу болох вэ? ... Тэд над шиг байхыг хүснэ. Фа зааж эхэлсэн үеэсээ би өөрийн үйлдлээрээ үлгэр жишээ болж байгаа, зарим хүмүүс миний хийсэн алхам бүрийг, тэр ч байтугай миний хувцаслалтыг хүртэл дуурайдаг юм шиг санагддаг. Тиймээс би эдгээр зүйлд их бага хэмжээгээр тодорхой анхаарал хандуулдаг. Миний зааж буй Фа зөв шулуун байгаад зогсохгүй, би бас өөрөө зөв шулуун байх ёстой. Миний орхимж өмсөж авхуулсан зураг бол ирээдүйд бясалгалаар дагнах шавь нартаа зориулж үлдээх юм. Гэхдээ миний барууны костюм өмсөж энгийн хүний нийгэмд Буддын Фа зааж байгаа нь тэнгэр газар үүссэнээс хойш анхны удаа юм, урьд өмнө хэзээ ч ингэж байгаагүй. Нэгэнт Фа-г ийм хэлбэрээр зааж байгаа болохоор бидний бясалгал энэ нийгмийн байдалд нийцсэн байх ёстой.

Хэрэв би ямар нэгэн буруу зүйл хийвэл ирээдүйн хүн төрөлхтөнд маш их өөрчлөлт гарах болно. Будда нар мах иддэггүй

гэдгийг та нар бүгд мэднэ. Бясалгалын маш олон зам байдаг. Хэдийгээр тэд бүгд мах идэх тал дээр Буддын шашин шиг хатуу биш боловч бясалгал нь маханд автах сэтгэлээсээ салахыг шаарддаг. Би энэхүү Фа-г энгийн хүмүүсийн дунд зааж байгаа болохоор, бясалгагчид мөн энгийн хүмүүсийн дунд бясалгаж байгаа, маш олон хүн сурч байгаа. Хэрэв би мах идэхгүй бол, ирээдүйд хүмүүс мах идэхгүй болно, хүн төрөлхтний амьдралын хэв маяг, хоолны дэглэм өөрчлөгдөх болно. Гэхдээ мах нь хүний бие махбодийг үнэхээр тэнхрүүлж чаддаг гэдгийг Бурхад мэднэ, үүнийг цагаан хоолоор орлуулж чадахгүй, энэ бол баттай. Мэдээжийн хэрэг, бясалгагч бидний хувьд бол өөр. Үүнээс эсрэгээр, мах идэхгүйгээр бясалгагчийн эрүүл мэнд нэлээд сайн байдаг нь бясалгалын нөлөөнөөс юм. Энгийн хүний хувьд, хэрэв бясалгал хийдэггүй, мах иддэггүй бол уураг тэжээлийн дутагдалд орох талтай, энэ бол гарцаагүй юм.

Гэрлэлт байхгүй болбол үр удам үгүй болж хүн төрөлхтөн мөхөхгүй гэж үү? Бид бүх зүйлийг харгалзан үзнэ. Буддын лам хуврага болсон бясалгагчдад гэрлэхийг хориглосон дүрэм байдаг нь үнэн. Гэхдээ бусад бясалгалуудад тийм байх албагүй. Урьд өмнө янз бүрийн түүхэн үеүдэд, хүн төрөлхтний өөр өөр түүхэн үеүдэд эсвэл хүн төрөлхтний өөр өөр соёл иргэншлийн үеүдэд байсан хүмүүсийн хувьд бясалгал хийхэд тавигддаг өөр өөр шаардлага байсан.

Гэрлэхгүй байхын зорилго бол хүний дур хүсэл, бэлгийн сонирхолд татагдах гэсэн хоёр зүйлийг арилгах явдал юм. Гэхдээ энгийн хүмүүсийн дунд бясалгаж байхад үүнийг эхнээсээ хийж чадахгүй, яагаад гэвэл хүн төрөлхтөн үр удмаа үлдээх хэрэгтэй. Бидний маш олон хүн энгийн хүний нийгэмд бясалгаж байна. Тиймээс чи бясалгагчдыг энгийн хүний нийгэмд бясалгахыг хүссэн мөртлөө тэднийг нийгэм дэх энгийн хүний амьдралын хэв маягаас нь салгахыг мөн хүсвэл... хүний нийгэм үнэхээр үгүй болохыг туйлаас зөвшөөрөхгүй! Чи хүн төрөлхтөнг сайн биш гэж бодсон ч, энэ бол бидний энэ дээрээс доош бүхнийг багтаах сансар ертөнцийн нэгэн хэсэг, мөн Фа-гийн хамгийн доод түвшний

илрэлийн нэг хэсэг юм. Хүн төрөлхтөн оршин тогтнохоо больж болохгүй. Гэхдээ чи хувь хүнийхээ хувьд гэрлэхийг хүсэхгүй байвал асуудалгүй. Энэ бол хувийн асуудал, буруу биш. Гэхдээ нэг зүйл бий: Гэрлэхгүй байх нь зууралдсан сэтгэл биш юм. Бид Төгс гэгээрэлд хүрэхийн тулд хүний нийгмээс холбоогоо таслах ёстой гэж буруу ойлгож өөр саад бэрхшээлд орж болохгүй.

Жишээлбэл, Буддын бясалгал, Бумбын бясалгал, анхны Католик шашин, Христийн шашин эсвэл тэдгээр ууланд бясалгадаг хүмүүс ч адил бясалгалын мөр хөөсөн хүмүүс гэрлэдэггүй байсан уламжлал хэдэн мянган жилийн турш дамжиж ирсэн. Тиймээс хүмүүст бясалгавал гэрлэж болохгүй гэсэн ойлголт суусан. Өнөөдөр манай Дафа дэлхийд дэлгэрэхэд энэ нь том саад болж байна. Энэ саад бэрхшээлээс болоод энгийн хүний нийгэмд бясалгадаг манай шавь нар гэрлэхгүй болж болохгүй. Өнөөдрийн бидний бясалгалын хэлбэр нь зөвхөн чиний Дэд сүнс (Фу юаншэнь)-ийг дээшлүүлэхэд юмуу эсвэл өөр ямар нэгэн зүйл бясалгахад биш, харин хамгийн хэцүү хүмүүсийн дунд чамайг өөрийг чинь сайжруулах зорилготой юм. Тиймээс чи хамгийн явдалтай энгийн хүмүүсийн дунд сэтгэлээ хатуужуулах хэрэгтэй. Хүмүүний орчлонд бясалгаж байгаа шавь нар энгийн хүний нийгмийн хэв маягт нийцсэн байх ёстой. Энэ бол Фа-гийн салшгүй нэгэн хэсэг юм. Миний хэлснийг та нар ойлгож байна уу? Гэхдээ бэлгийн дур хүсэл, сонирхолд автах бол зайлшгүй арилгах ёстой зууралдсан сэтгэл мөн. Бид ч бас тэдгээр эртний бясалгалууд болон эртний шашин дахь бясалгалын аргуудын адил хичээллэх хэрэгтэй гэсэн буруу ойлголт авч бас болохгүй. Энэ нь тийм гэсэн үг биш. Өнөөдрийн бидний бясалгалын хэлбэр бол миний чамд үлдээсэн бясалгалын арга юм, бидний энэ Фа-г өнөөгийн нийгэмд тараахад тавигдах янз бүрийн шаардлагууд бас үүнд багтана- энэ бүгд хойч үеийнхэнд үлдэх болно.

Та бүхэн манай тодорхой дүрмийн талаар мэднэ. Жишээлбэл: Бид улс төрд оролцдоггүй, бид албан байгууллага шиг удирдах газар байгуулдаггүй, бид захиргааны шат дамжлага үүсгэдэггүй, мөн бид мөнгөтэй харьцахгүй. Мэдээж энэ Фа хүмүүст албан тушаалын

зэрэг олгохгүй. Чиний юу хийдэг, нийгэмд хэр өндөр албан тушаал хашдаг хамаагүй, энэ нь чиний бясалгалд нөлөөлөхгүй. Тэдгээр нь энгийн хүний нийгмийн асуудал, чиний бясалгал бол чиний л бясалгал. Чи энгийн хүмүүсийн дунд хийдэг зүйлээ бясалгалаасаа ялгах хэрэгтэй, эдгээр нь хоёр өөр зүйл. Жишээлбэл, хэрэв энгийн хүмүүсийн дунд хийдэг чиний ажил энгийн хүний нийгэмд болон хүн төрөлхтөнд тустай бол чи буян хурааж байна харин бясалгаагүй, энэ нь хоёр өөр зүйл, тиймээс чи тэдгээрийг хооронд нь хугаагүй эсэхээ мэдэж байх ёстой. Зарим хүн “Би буян хураах сайн ажил хийдэг, тэгэхээр би ирээдүйд Төгс гэгээрэлд хүрэх болно” гэдэг. Хэрэв үнэхээр бясалгадаггүй нэгэн хүн шашны тэргүүн болсон ч, эсвэл сүм дугана барьж, Буддын хөшөө босгосон ч гэсэн Төгс гэгээрэлд хүрч чадахгүй. Энэ бол өөртөө сэтгэл хангалуун болох л санаа юм. Ажил бол ажил, гэвч энэ нь бясалгалыг хэзээ ч орлож чадахгүй, бясалгал бол бясалгал, энгийн хүмүүсийн зүйлс бол энгийн хүмүүсийн л зүйлс юм. Шашны төлөө ямар нэг зүйл хийх нь энгийн хүмүүст зориулж хийсэнтэй адил, тэдгээр шашны амьдралаар замнасан хүмүүс Будда биш. Буддууд хүний зүрх сэтгэлийг хүлээн зөвшөөрдөг ч, шашинг бол үгүй. Эдгээр нь хоёр өөр зүйл юм, тэдгээрийг хооронд нь бүү андуур.

Асуулт: Багш аа, Шэньжэнь, Гуанжоугийн сурагчдын өмнөөс тэдний мэндчилгээг танд уламжилъя. Намайг ирэхээс өмнө тэд энэ мессежийг заавал дамжуулж өгөхийг надаас хүссэн юм.

Багш: Багш нь бүх шавь нарынхаа талаар зүрх сэтгэлдээ байнга боддог гэж тэдэнд хэлээрэй.

Асуулт: Коллежийн элсэлтийн шалгалтанд бэлдэж байгаа ахлах ангийн сурагчид хичээлдээ үнэхээр завгүй учраас дасгалаа бага хийдэг. Энэ нөхцөлд яах ёстой вэ?

Багш: Энэ бол асуудал бишээ. Бидний дасгал хөдөлгөөн бол төгс гэгээрэлд хүрэхэд туслах хэрэгсэл юм. Хэдийгээр энэ нь чухал ч бид зүрх, сэтгэлээ бясалгах нь хамгийн чухал зүйл юм. Хэрэв чи үргэлж өөрийгөө сэтгэлийн гүндээ бясалгагч гэж үздэг бол, хэсэг

хугацаанд, эсвэл бүр урт хугацаанд дасгал хийх үнэхээр завгүй байсан ч сэтгэлдээ өөрийгөө үргэлж бясалгагч гэж үзэн шаардлагын дагуу байдаг бол чиний гон өссөөр байх болно. Гэхдээ нэг зүйл бий: “Багш ингэж хэлснээс хойш бид цаашид дасгал хийхгүй байсан ч яахав” гэж бодвол, үүнийг хүлээн зөвшөөрөхгүй. Тэгвэл туйлшрал болно. Онцгой нөхцөл байдал байгаа учраас л хүндэтгэх шалтгаан өгнө. Учир нь Буддын Фа хязгааргүй юм. “Буддын Фа хязгааргүй” гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь хязгааргүй олон арга замтай, хүн бүрийн нөхцөл байдлаас шалтгаалж хүмүүсийг аврах хангалттай олон арга зам бий.

Асуулт: Багш аа, маргааш видео бичлэг хийхийг зөвшөөрөх болов уу?

Багш: Эх газрын Хятадад бидний зааж байгаа энэ Фа-г маш олон хүн сурч байгаа, мөн намайг лекц уншихаа больсон гэж та нар сонссон байх. Би эх газрын Хятад дахь сурагчидтай уулзахгүй байгаа. Үнэндээ би гурван жилийн турш Хятадын эх газрын сурагчидтай уулзаагүй. Гэвч улам олон хүмүүс нэмэгдэн сурсаар байна, мөн энэ нь нийгмийн анхаарлыг их татаж байна. Олон хүмүүс сурч байгааг тэд харж байна. Үүнээс гадна, хүмүүс үүнийг сурсныхаа дараа сайн гэдгийг бүгд мэдэрдэг. Бясалгагчдын хэлснээр, хүмүүс үүнийг сурсныхаа дараа бүгд бясалгахаар шийдэцгээдэг. Улмаар хүмүүсийн тоо мэдэгдэхүйц их болж ирмэгц, Хятадын нийгэмд зарим хүмүүсийг жаахан бодолд оруулж магадгүй юм. Олон хүмүүс намайг болон Фа-г энгийн хүний бодлоор үнэлж байж магадгүй. Хүмүүст сайн зүйл хийе гэсэн ч маш хэцүү байдаг, учир нь хүмүүсийн сэтгэл санаа шулуун зөв биш. Бид аль болохоор тэдгээр шаардлагагүй түвэг учруулсан зүйлсээс зайлсхийхийг хичээдэг. Тийм учраас саяхан зарим улс орны сурагчидтай уулзахдаа би дүрс, дууны бичлэг хийхгүй байхыг тэдэнд хэлсэн. Шалтгаан нь юу байв? Учир нь Хятадад эдгээр зүйлс тархахыг багасгах зорилготой юм. Бид улс төрд оролцдоггүй болохоор мэдээж энд ч гэсэн улс төрийн талаар ямар ч асуудал байхгүй, муу хүмүүс асуудал үүсгэхийг хүсч байгаа тул бидний ярианаас иш татан хор хөнөөл учруулж болзошгүй юм. Гол

шалтгаан нь түвэгтэй асуудлаас зайлсхийх, бидний энэхүү Фа-г хүн төрөлхтөнд, ирээдүйд зөв, алдаагүй, хазайлгахгүйгээр үлдээх явдал юм. Хэрэв бид ямар нэгэн шаардлагагүй гарз хохирол амсвал ирээдүйд харамсах зүйл болно. Бид зөвхөн өнөөдрийн хувьд бодож болохгүй.

Аудио бичлэг байна уу, видео бичлэг ч байна уу, эдгээр нь ирээдүйд үлдэхгүй, энэ бол гарцаагүй. Зарим нь одоо аль хэдийн арчигдаж эхэлснийг та нар мэднэ, урьд өмнө хийгдсэн зарим видео бичлэгүүд дүрсээ аль хэдийн алдсан, аудио бичлэгүүдийн дуу нь арчигдсан. Тэдгээр нь аажмаар арчигдаж байгаа. Зарим зүйлийг энэ байдлаар хадгалж болохгүй. Чиний нөхцөл байдалд тохируулж хэлсэн миний үгийг, бусад хүмүүс сонсвол өөр нөхцөл байдал үүснэ, үүнийг өөрөөр ойлгох болно. Жуан Фалунь нь уншихад хүн бүрт тохиромжтой. Ийм л нөхцөл байдал байдаг. Яахаа чи өөрөө мэд. Би энэ талаар төгс хариулт өгөөгүй.

Асуулт: Багш аа, би Шанхайгаас ирсэн. Шанхай дахь шавь нар таныг үнэхээр их санадаг. Би сүүлийн Олон улсын туршлага солилцох чуулганаас буцаж ирснийхээ дараа таныг харсан гэдгээ хэлэхэд тэд бүгд нулимс унагасан. Тэд надаас тэдний хүндэтгэлийг танд уламжилж өгөхийг хүссэн юм.

Багш: Би бясалгал зааж байх үедээ Шанхай руу очиж чадаагүйдээ харамсаж байдгийг тэдэнд хэлээрэй. Тэр үед би энэ Фа-гийн хувьд зөв шулуун зам үлдээхийг хүсч байсан болохоор, гудамжинд зэрлэг өвсний наймаачид шиг аашилдаг, өөрсдийн зүйлээрээ наймаалцдаг бусад чигон багш нартай адилгүй байсан. Би зөвхөн тухайн орон нутгийн чигоны байгууллагууд, Чигон Шинжилгээ Судалгааны Нийгэмлэгийн болон Засаг захиргааны төлөөлөгчдийн урьсан тохиолдолд очдог байсан. Шанхай хот урилга ирүүлээгүй байсан болохоор, энэ асуудал саатагдсан. Дараа нь урилга явуулахад, би бясалгал заахаа аль хэдийн зогсоосон байсан. Би Хятадын энэ том хотод Фа заахаар очиж амжаагүйдээ их харамсдаг. Шанхай бол Бээжингийн дараа орох Хятадын хамгийн том хот. Одоо Шанхайд олон хүн Фа сурч байгаа гэдгийг

би мэднэ. Хэдийгээр би тэнд очих боломж гараагүй ч гэсэн Дафагийн Шанхай дахь тархалт, хөгжил ерөнхийдээ сайн байгаад болон тэдний тууштай сурч байгаад миний сэтгэл хангалуун байна. Энэ бол сайн хэрэг.

Асуулт: Ли багш аа, би Бээжингээс ирсэн шавь байна. Бээжин дэх бүх шавь нар таньд мэнд хүргэж байна.

Багш: Бээжингийнхнийг, зөвхөн Бээжингийн ч биш, бусад олон бүс нутгийн сурагчдын хувьд мөн адил, би ч бас та нарыг санадаг. Гэхдээ би та нартай уулзахаас зайлсхийдэг, яагаад гэвэл та нартай уулзсаны дараа, нэг хүн намайг харчихвал, хэдэн цагийн дотор хэдэн арван хүн ирнэ, өдөрт хэдэн мянган хүн ирж магадгүй, маргааш нь арав гаруй мянган хүн ч ирж магадгүй юм. Бусад бүс нутгаас хүмүүс бас ирж магадгүй, яг өнөөдрийнх шиг олон хүмүүс бусад бүс нутгаас ирнэ. Дараа нь энэ нь нийгэмд сөрөг нөлөө үзүүлнэ, тиймээс би та нартай уулзаж болохгүй байна. Гэхдээ бид хатуу нийгмийн тогтолцооны дор, Фа-г төвөггүй тарааж чадсан, түүхэн дэх маш хатуу цаг үеийн сорилтыг давсан гэж би бодож байна. Түүхэнд ирээдүйн аль ч үед бид цуцашгүй хэвээр байх болно, тийм үү?

Асуулт: Бидний зарим сурагчид Жуан Фалунь-ий номыг Хонконг, Хятадаас авчирсан. Эдгээр номыг хурлын танхимд зарах нь зөв үү?

Багш: Хэрэв та нарт Жуан Фалунь-ий ном байгаа бол, чуулганд оролцож байгаа хүмүүст сайн зүйл хийх, номгүй байгаа сурагчдад амар болгож өгөхийг хүсч байвал буруугүй гэж би бодож байна, та нар тэгж хийж болно. Чи нэр хүнд, хувийн ашиг сонирхлыг эрэлхийлээгүй болохоор, энэ нь асуудалгүй. Гэхдээ энэ зүйлийг хийхээс өмнө бусад сөрөг үр дагавар гарахаас болгоомжлохын тулд, АНУ-д үүнийг зохион байгуулж буй хүмүүст мэдэгдээрэй. Би үүнийг асуудал биш гэж бодож байна.

Хамгийн сүүлд надтай уулзаж байсан энд байгаа хүмүүс бясалгалын нэгэн үе шатыг хэдийнээ туулсан. Та нар Фа-гийн талаар тодорхой түвшинд ойлголттой болсон, хариуцлагагүй хандахгүй байх гэж би бодож байна. Би яагаад ийм итгэлтэй байгаа вэ? Учир нь та бүхэн миний юу зааж байгааг мэдэж байгаа. Бид юу ч хүсэхгүй, зөвхөн хүмүүсийн сэтгэлд л анхаарлаа хандуулдаг. Хэрэв хүмүүсийн зүрх сэтгэл өөрчлөгдөж чадахгүй бол, энэ Фа ямар ч ашиггүй болно. Аливаа албадлагын хэлбэр нь хүмүүсийн зүрх сэтгэлийг өөрчилж чадахгүй, тиймээс бид ийм, тийм дүрэм гаргаагүй, мөн чамаас энэ тэрийг хий гэж шаардаагүй - тэгж бид хийхгүй. Энэхүү Фа нь өөрөө зөв замаар дэлгэрэх боломж олгодог. Олон, улам олон хүн үүнийг сурч, нийгэмд сайн үүрэг гүйцэтгэж чадаж байгаа нь Фа хүмүүсийн зүрх сэтгэлд аль хэдийн шингэснийх юм. Тэд өөрсдийгөө хэрхэн авч явахаа мэддэг, тэдэнд юу хийхийг нь хэлэх шаардлагагүй, надад тэдэнд юу хийхийг нь хэлээд байх ч шаардлагагүй болсон. Тийм болохоор би үүнд тийм ч их санаа зовдоггүй. Хэрэв бидний энд байгаа хэн нэг нь ямар нэгэн зүйлийг сайн хийгээгүй бол бусад нь үүнийг тэр дор нь шууд харах болно. Фа энд байна, чамд аливаа зүйлийг цэгнэх Фа байна. Ийм л байх ёстой юм.

Асуулт: Багш энэ Фа-г зөвхөн Хятадууд төдийгүй бусад үндэстнүүдэд тараах хэрэгтэй гэж хэлсэн. Багш энэ Фа-г бусад ард түмэнд хэрхэн өргөнөөр түгээх талаар заавар зөвөлгөө өгөх байх гэж найдаж байна.

Багш: Энэ талаар бидэнд тодорхой дүрэм байхгүй. Фа-г хүмүүсийн хүртээл болгосон. Одоогийн байдлаар Герман, Япон, Солонгос, Франц, Англи, Орос болон бусад хэл дээр орчуулагдсан байна. Ямар ч байсан олон болж байна. Мөн Италийн орчуулга хийгдэж байгаа бололтой, бусад хэл рүү хөрвүүлэх ажил эрчимтэй хийгдэж байна.

Орчуулгын группүүд энэ талын зүйл дээр ажиллацгааж байна, материал бэлэн болмогц хүмүүс унших боломжтой болно. Фа-г хэрхэн тараах талаар бидэнд үүнийг ийм, тийм байдлаар хийх

ёстой гэсэн дүрэм журам байхгүй. Фа тараахдаа бид Фа бол сайн гэж үздэг тул, хүмүүс үүнийг дээдэлдэг. Энэ нь сайн учраас чи энэ тухай бусдад хэлэхийг хүсдэг. Тэгэхээр энэ Фа тархсан арга зам нь ерөнхийдөө сэтгэлээс сэтгэлд, хүнээс хүнд дамжиж ирсэн. Яаж тархсан нь үндсэндээ энэ л юм. Хятадад хорин сая гаруй хүн жинхэнэ бясалгаж байна. Алдаг оног бясалгадаг хүмүүсийг оролцуулан тоолбол одоо зуун сая хүн байна. Гэхдээ гаднаа чимээгүйхэн илэрч байдаг, нийгэм дэх хүмүүс сайн мэддэггүй. Өөрөөр хэлбэл, хүн бүр үүнийг сэтгэлээсээ тарааж байна, сэтгэлийнхээ гүнээс амнаас ам дамжуулан тарааж байна. Энэ нь аль хэдийн нэлээд том чиг хандлагыг бий болгосон. Бидэнд онцгой дүрэм журам гэж байдаггүй, хүн бүр үүнийг өөрийн хүслээр, сайн дураараа хийдэг. Миний юу хэлснийг ойлгож байна уу? Буддын сургаальд бүх амь бодийг аврахыг номлодог учраас бид ямар нэгэн хоосон ёс дэгийн зүйл ярьдаггүй. Бид хүмүүсийг аварч байна, гэхдээ энэ нь та нар яваад хүмүүсийг аврахыг хэлээгүй, чи өөрөө ч бясалгасан хэвээр байгаа болохоор хүн аварч чадахгүй. Гэхдээ чи Фа-г бусдад танилцуулж байгаа нь хүмүүст Фа-г олж авахад нь туслах хамгийн сайн арга юм. Ирээдүйд хүмүүс үүнийг хичнээн нандин болохыг ойлгох болно. Чи хэн нэгэнд хичнээн их мөнгө өгсөн ч, эсвэл хичнээн их сайн зүйл хийсэн ч түүнд Фа-тай танилцуулж өгсөн шиг тийм сайн байж чадахгүй. Фа нь бүс нутаг, үндэстэн, улс орон, тэр ч байтугай хүн төрөлхтөнд ёс суртахуунаа сэргээж, аз жаргалтай, тайван, энх тунх амьдрах боломжийг олгож чадна. Зөвхөн эдгээр зүйлс байж хүн төрөлхтөн зөв замаар хөгжиж чадна.

Асуулт: Фалунь Буддын Фа-г сурсаны дараа хамгийн түрүүнд шаргуу хөдөлмөрлөж, сайн ажиллахыг хүсдэг болсон. Надад үнэхээр хийх зүйл байхгүй үед номоо л уншдаг.

Багш: Энэ нь бүхнээс илүү сайн биш гэж үү? Амьдралд чинь, ажил дээр чинь эсвэл нийгэмд тулгардаг зарим асуудал чиний тодорхой зууралдсан сэтгэлийг арилгахад тусалж чадна. Чамд ямар нэгэн зүйл тохиолдвол, энэ нь чиний зууралдсан сэтгэлээ арилгахад эсвэл чамд ямар нэгэн талаар тус болж болно. Хүн

нэгэнт бясалгалын зам руу орвол, тэр үеэс хойш түүний амьдралд тохиолдлын зүйл гэж байхгүй болно. Чиний бясалгалын явц системтэйгээр зохицуулагдсан, үүнд цаг хугацаа тийм ч их биш болохоор санамсаргүй зүйл гэж байх боломжгүй. Бүх зүйл урьдчилан нягт зохицуулагдсан байдаг. Өдөр тутмын амьдралдаа тохиолддог санамсаргүй мэт санагдсан, эсвэл ялихгүй зүйлсийг ч санамсаргүй зүйл гэж бүү бод, чамд олон гайхамшигтай зүйл тохиолдох боломжгүй мөн чи өөр орон зайд орж бясалгаж чадахгүй, тийм замаар зүрх сэтгэлээ дээшлүүлж чадахгүй. Чи дэлхийн энгийн зүйлсийн дунд байна, чиний асуудлууд энгийн хүний асуудалтай адил хэвээр байгаа, чиний амьдралын хэв маяг энгийн хүнийхтэй адилхан хэвээр, мөн чамд тохиолдож байгаа зүйлс урьдынхаас нэг их ялгаа байхгүй. Гэхдээ чи үүнийг сайтар бодож үзвэл, тэдгээр нь адил биш юм. Тэд бүгд чамд бясалгалдаа дээшлэх боломж олгоно.

Асуулт: Та Жэнь, Шань, Рэн гэж заадаг. Тодорхой нэг тохиолдолд, нэг хүн бусдаас уравсан, бид тэдэнд тэр этгээдэд хариу сургамж өгөхөд туслана гэж амласан. Бид ингэж болох уу?

Багш: Бид ингэж бодож байна, мөн энэ нь номонд бас байдаг: Ямар нэгэн энгийн хүнд тулгарсан зүйл чиний уурыг үнэхээр хүргэж түүнд хөндлөнгөөс оролцохыг хүсвэл, чамд зөвшөөрөхгүй гэсэн үг биш. Ийм байдалтай тулгарвал хэдэн үг хэлэх бол байж болно. Магадгүй чиний үгс нөлөөлөхгүй, эсвэл хэлсэн чинь оновчтой биш байж болно, учир нь чи тэдний зөрчилдөөний цаад учир шалтгааныг, тэдний үйлийн үрийн холбоог харж чадахгүй. Жишээлбэл, хоёр хүний нэг нь нөгөөгөө цохисон. Чи энгийн хүний үүднээс цохисон хүнийг буруутай гэж бодно, тэр яагаад түүнийг цохив? Гэхдээ хэрэв чи цаг хугацааг ухраагаад харвал, тэр хүний амьдралын эхний хагаст эсвэл түүний өмнөх амьдралд энэ хүн түүнийг нэг удаа цохисон болохыг олж мэднэ. Бясалгагчид бид хүнийг харахдаа түүний зөвхөн нэг насны амьдралыг харж болохгүй, бид түүний бүхэл оршихуйг бүхэлд нь харах шаардлагатай. Тэр хүн энэ хүнд өртэй юм.

Цагдаа эдгээр зүйлийг зохицуулах нь зүй ёсны хэрэг, энэ нь энгийн хүмүүс энгийн хүмүүсээ зохицуулахад дэлхийн зарчимд нийцнэ, эдгээр нь ямар ч зарчим зөрчихгүй. Гэхдээ бясалгагчид эдгээр зүйлийг харвал хөндлөнгөөс бага оролцох эсвэл огт оролцохгүй байхыг хичээх хэрэгтэй гэж би хэлмээр байна. Яагаад? Учир нь чи хөндлөнгөөс оролцсоноор үүнийг буруу зохицуулах магадлалтай. Ийм байх ёсгүй байхад харин чи, бясалгагч, үүнийг тийм байлгах гэж хүчилснээр энэ зүйлийг хойшлуулбал эсвэл эвдвэл өөртөө нүгэл үүсгэж болзошгүй. Бурхан түүнийг энэ амьдралдаа нүглээ төлөхөөр урьдаас зохицуулсан боловч, тэр одоо үүнийг төлөөгүй, тэр хоёр ийм боломж дахин олох хэрэгтэй болдог. Миний хэлсэн нь ийм л утгатай. Гэхдээ чи үнэхээр хүн алах, галдан шатаах гэх мэт аймшигтай зүйлтэй тааралдаад үл тоомсорлон өнгөрөөвөл энэ бол шиньшин-тэй холбоотой асуудал болно. Чи бол бясалгагч, гэхдээ Бурхан ч гэсэн эдгээр зүйлсийн хувьд ямар нэгэн зүйл хийх болно, тийм үү? Гэхдээ нөгөө талаар, ихэвчлэн манай сурагчдад иймэрхүү зүйл ховор тохиолдоно, эсвэл хэзээ ч тохиолдохгүй. Өөрөөр хэлбэл, чиний амьдралд ийм зүйл зохицуулагдаагүй, яагаад гэвэл тэр нь чиний зан чанарыг сайжруулахад тустай зүйл байх ёстой. Тэдгээр зүйлс нь хэрэгцээгүй бол ердийн тохиолдолд манай сурагчдад бараг тохиолдохгүй, эсвэл огт тохиолдохгүй.

Хэн нэгнийг залилан мэхлэх эсвэл энгийн хүнд ямар нэгэн зүйл амлахын хувьд, эдгээр нь бүгд энгийн хүний асуудал. Нэгэнт чи бясалгаж байгаа болохоор аливаа зүйлийг Фа-гаар дүгнэж цэгнэ, өөртөө бясалгагчийн үүднээс хандах хэрэгтэй. Хэрвээ чи “итгэлийг эвдэх” эсвэл “энгийн хүнд ямар нэгэн зүйл амлах” гэх мэт зүйлд энгийн хүмүүсийн жишгээр хандвал чи энгийн хүн болсон юм биш гэж үү?

Асуулт: АНУ-д суралцаж байгаа сурагчид (хятад оюутнууд) бүгд уйтгартай байгалийн шинжлэх ухааныг нэг хэвийн зууралдсан сэтгэлээр сурч байна.

Багш: Би энэ тухай маргааш ярьж магадгүй. Би чамд энэ зарчмыг хэлье: Хүн төрөлхтний түүх ба хүн төрөлхтний шинжлэх ухаан бол үнэндээ алдаа юм. Түүний хөгжлийн суурь, түүнчлэн хүн төрөлхтөн, байгаль, материйн талаарх суурь ойлголт нь бүгд буруу. Энэ нь өнөөгийн хүний нийгэм дэх ёс суртахуунд хохирол учруулж байна. Энэ бол гол том асуудал, би энэ талаар маргааш ярих болно. Гэхдээ нэг зүйл бий: Хэрэв хүн төрөлхтөн ямар ч мэдлэггүй байсан бол, хүмүүс өнөөдөр Жуан Фалунь номыг уншиж чадахгүй байх байсан, эсвэл наад зах нь дээд, гүн гүнзгий утга агуулгыг олж харахгүй байх байсан. Тиймээс магадгүй чиний олж авсан мэдлэг бас санамсаргүй зүйл биш. Ирээдүйн хүн төрөлхтөн шинэ шинжлэх ухааны суурин дээр хөгжинө, тэгэхээр тэдэнд ч мөн мэдлэг хэрэгтэй.

Дафа-гийн шавийн хувьд, цаг нь болохоор чи юу хийхээ аяндаа мэдэх болно гэж бодож байна. Магадгүй эдгээр зүйлс ч бас санамсаргүй биш байх. Тиймээс одоо чи юу сурах ёстой түүнийгээ сур, үүнийг зууралдсан зүйл гэж битгий бод. Нэг бясалгагч оюутан анх АНУ-д ирэхдээ ямар нэг буруу зүйл хийсэн учраас сургуулиасаа гарсан гэж би сонссон, тэр эхлээд буруу зүйл хийсэн байж магадгүй, гэхдээ одоо тэр өмнөх алдаагаа дахин давтаж байна гэж хэлмээр байна. Нэгэнт болоод өнгөрснөөс хойш ирээдүйн амьдралдаа санаатайгаар бэрхшээл бүү учруул, чиний хийсэн зарим алдаа нэг ижил байдлаар засагдах боломжгүй. Чи сэтгэлдээ буруу зүйл хийснээ мэдэж байгаа, ирээдүйд ийм зүйл дахин хийхгүй гэдгээ бас мэдэж байгаа, ийм асуудал гарахад чи ирээдүйд сайн байж амжилттай давж чадвал, үүнийг би асуудал биш гэж хэлнэ. Дараа нь асуудал гарахгүй гэж бодож байна. Эдгээр асуудалтай холбогдуулан, буруу зүйл хийснийхээ төлөө байдлыг буцааж, өнгөрснөө нөх гэж бид чамаас шаарддаггүй, бид үүнийг ингэж хийхгүй. Өөрөөр хэлбэл, бясалгалдаа саад бэрхшээл битгий учруул, амьдралдаа саад бэрхшээл битгий учруул. Оюутнуудын хувьд одоохондоо бид сайн сур гэж л хэлэх байна, нэгэнт л та нар оюутан болохоор, сайн сурах хэрэгтэй.

Та нар өөр ямар нэгэн ажил хийдэг байсан ч, энэ нь энгийн хүний нийгэм дэх ажил төрөл болохоор, энгийн хүний нийгмийн зарчмын үүднээс авч үзвэл энэ орон зай дахь хүний нийгэмд үйлчлэх үйлчилгээ юм, чи үүнийг бас сайн хийх хэрэгтэй. Учир нь хүн төрөлхтөн бол Сансар ертөнцийн Дафа-гийн хамгийн доод түвшний амьдралын илрэл юм.

Асуулт: Багш аа, Германы шавь нарын өмнөөс таньд мэндчилгээ дэвшүүлье.

Багш: Би Германаас ирсэн урилгыг харсан. Өнгөрсөн арван нэгдүгээр сард хүйтэн байхад Оросоос бас урилга илгээсэн. Дулаарахаар би очих боломж харья.

Асуулт: Багш аа, би Япон руу цагаачилсан. Ирээдүйд таньд боломж гарвал, бид таныг Японд ирэхийг үргэлж хүсдэг.

Багш: Намайг Гуанжоуд хичээл заахад Японоос нэгэн хүн ирж оролцсон. Дараа нь тэр Японд буцаж очоод зарим хүмүүсийг нэгтгэсэн, бүгд япон хүмүүс байсан. Сурсан бүх хүмүүс нь харваас настай хүмүүс байсан. Хэсэг хугацаанд хичээллэхдээ өмнө нь хийж байсан чигоноо орхиж чадахгүй байсан учраас бид түүнтэй хэзээ ч холбоо бариагүй. Түүгээр заалгаж байсан хүмүүс бүгд ариун бус байсан учраас бид түүнтэй холбоо бариагүй.

Асуулт: Миний нөхөр япон хүн, гэхдээ түүнд Дафа маш их таалагддаг. Тэр үүнийг их сайн гэж боддог.

Багш: Өв соёлын ялгаа байж магадгүй. Гэхдээ япончууд үнэхээр сурч чадвал, тэдэнд цагаан арьстнуудаас ч илүү хялбар байх болно гэж би бодож байна, яагаад гэвэл дорнын ард түмэн ижил сэтгэлгээтэй байдаг, Барууныхан өөр сэтгэлгээтэй байдаг. Гэхдээ Барууныхан сурсныхаа дараа тэд бас сайн байж чаддаг. Би Японд нэг удаа очиж байсан, гэхдээ зөвхөн Японы ард түмэн ямаршуу байдалтай байгааг харах гэж очсон.

Асуулт: Ирээдүйд энэ Дафа хүмүүсийн оюун сэтгэлийн Фа болох юм бол, философи, утга зохиол гэх мэт нийгмийн шинжлэх ухааны салбар ямар болох вэ?

Багш: Бүх зүйл өөрчлөгдөх болно. Тэр чигтээ цоо шинэ болно. Хүмүүсийн энэ нийгэм, хүн төрөлхтөн, бүх зүйлийн талаарх ойлголт өөрөөр эргэх болно. Одоо Бээжин дэх манай олон сурагчид өөрсдийгөө бусад хүмүүстэй адилгүй гэдгийг мэддэг. Тэдний дамжуулдаг үг нь: “Бид бол шинэ хүн төрөлхтөн.” Мэдээжийн хэрэг, би тэдний хэлсэн үгсийг баталж байгаа юм биш, харин зүгээр л нэг санааг дамжуулж байгаа юм. Энэ нь өнөөгийн хүмүүсийн боддог, ойлгодгоос өөр болно, энэ бол дамжиггүй. Энэхүү Фа-г гүнзгийрүүлэн сурах явцад бүх зүйлийн талаар шинэ ойлголттой болох болно. Энд цугларсан хүмүүс боловсролын харьцангуй өндөр түвшинтэй, мөн гадаадад сурч байгаа олон сурагчид байна. Та нар үүнийг аажмаар мэдэрч, эргэцүүлэн бодох тусам чиний хүн төрөлхтний талаархи бүх талын ойлголтонд өөрчлөлт гарч байгааг олж мэдэх болно. Энэ нь миний хэлсэнчлэн, хүн төрөлхтний хөгжил, хүн төрөлхтөний эхлэл ба үүслийн талаархи ойлголт-хувьслын онолд яригддаг зүйл огт байдаггүй юм, мөн матери-бие бодийн тухай ойлголт, орчлон ертөнцийн тухай ойлголт, амьдралын тухай ойлголт, бидний өмнөх орчлон хорвоогийн тухай ойлголт, энэ сансар ертөнцийн орон зайн тухай ойлголтууд бүгд буруу суурин дээр хөгжиж ирсэн юм.

Асуулт: Эзэн сүнс (Жу-юанишэнь) хэзээ хүний биед ордог вэ?

Багш: Эзэн сүнс ихэвчлэн төрөхөөс өмнөхөн их холгүй ордог боловч, тодорхой тогтсон цаг хугацаа байдаггүй. Энэ нь яг төрөхийн өмнө байж болно, эсвэл төрөхөөс нилээд өмнө, хагас сар, сар, эсвэл бүр өмнө нь байж болно, бүгд байх боломжтой.

Асуулт: Хүн төрөлхтөн хүнийг хувиран бүтээх тал дээр Багшийн үзэл бодол ямар байдаг бол?

Багш: Хүн төрөлхтөнд ёс суртахууны хэм хэмжээ байхгүй болоход юуг ч хийнэ. Ийм төрлийн хүн төрсний дараа, түүнд эцэг эх гэсэн ойлголт байхгүй, хүний ёс зүй, ёс суртахууны тухай ойлголт гэж байхгүй, энэ бол аймшигтай. Тэр нэг хүнийг солихын тулд түүнийг хувилж дараа нь тэр хүнийг ална. Эдгээр зүйлс хүн төрөлхтний ёс суртахууны доройтлын үед гарч ирдэг. Гэхдээ би хүнийг хувилах асуудал гарахгүй гэж бодож байна, яагаад гэвэл Бурхад үүнийг зөвшөөрөхгүй. Хүнийг хувилж хийсэн ч гэсэн тэр нь хүн биш байх болно, Бурхад түүнд Эзэн сүнс өгөхгүй учраас түүнд зөвхөн ад чөтгөр л орох болно.

Асуулт: Хэрэв цус холилдсон (эрлийз) хүмүүс бясалгавал, аль диваажинд очих вэ?

Багш: Хүн төрөлхтний явцад, цус холилдсон хүмүүс тэнгэрт харьяалагдах үндсээ аль хэдийн алдсан. Гэхдээ тэд бясалгагч бол, тэдний гадаад төрх байдал нь чухал биш болно, тухайн хүний Эзэн сүнснээс шалтгаалах болно. Хэрэв түүний Эзэн сүнс цагаан арьстных бол, тэр цагаан арьстан; хэрэв түүний Эзэн сүнс нь шар арьстных бол, тэр шар арьстан; хэрэв түүний Эзэн сүнс хар арьстных бол, тэр хар арьстан. Хэрэв тэр бясалгадаг л бол, энэ нь өөр асуудал юм.

Асуулт: Цус холилдсон (эрлийз) хүн бясалгаад амжилтанд хүрч чадах уу?

Багш: Хэн нэгэн бясалгаж чадах эсэх, бясалгаад амжилтанд хүрч чадах эсэх нь бүгд тухайн хүнээс өөрөөс нь шалтгаална. Хэрэв эрлийз хүн тууштай бясалгаж чадвал, тэр мөн адил Төгс гэгээрэлд хүрч чадна. Тэрээр бясалгалдаа амжилтанд хүрэхэд, түүний Эзэн сүнс ирсэн газартаа буцаж очих болно.

Асуулт: Өнгөрсөн удаа, та цус холилдсон (эрлийз) хүнийг гээгдсэн хүн гэж хэлсэн, энэ нь юу гэсэн үг вэ?

Багш: Тэр дээрээс доош энд ирсэн биеэ алдсан. Үүнийг ингэж хэлье: Шар арьстан хүмүүст тэр дээр шар арьстан хүмүүс л байдаг, цагаан арьстан хүмүүст тэр дээр цагаан арьстан хүмүүс л байдаг. Тэр энэ холбоосноос гээгдсэн.

Асуулт: Хүүхэд төрснийхөө дараа л Эзэн сүнстэй болдог гэж та хэлсэн. Жирэмсний үед амь байдаггүй гэсэн үг үү? Тайлбарлаж өгнө үү.

Багш: Энэ тийм биш. Юу ч... Аливаа зүйл бүтээгдэхэд амь түүнд ордог гэж би хэлсэн. Үйлдвэрт хийгдсэн бүтээгдэхүүн ч бай, юу ч бай, чи тэдгээрийг тийм л байдлаар хардаг, гэхдээ бүгд амьтай байдаг. Үр хөврөл эхийн хэвлийд маш өчүүхэн байхад, өчүүхэн хэсэг мах үүсэхэд тэр нь аль хэдийн амьтай болсон байдаг. Тэгвэл тэр Эзэн сүнсгүйгээр яаж амьд байж чадах вэ? Эзэн сүнсгүй байсан ч тэр өөрөө амьтай байдаг. Яагаад гэвэл хүнд өөрөөс нь гадна... урьд өмнөх үеийн бясалгалд гурван сүнс, долоон амь гэж ярьдаг байсан биш үү? Мэдээж, тэдний хэлсэн зүйл тодорхой биш байсан. Би чамд энэ санааг л хэлж байна, өөрөөр хэлбэл чиний биед Эзэн сүнснээс гадна хүний амийг бүрдүүлдэг бусад элементүүд байдаг. Махан бие бас өөрөө эцэг эхийн чинь дүр төрхтэй амьтай байдаг, эцэг эхийн дүр төрх бас амьтай байдаг. Хүний махан бие нь үүсэж эхлэхээсээ маш нарийн цогц юм.

Асуулт: Тэгвэл үр хөндөлтийг бас амь алсанд тооцох уу?

Багш: Тэр үнэн. Жирэмсний үед үр хөндөх бол амь хөнөөж байгаа хэрэг. Хүний ёс суртахуун ямар болсон, мөн хүн төрөлхтөн болон хуулиуд нь үүнийг зөвшөөрч байсан ч, хууль нь Бурхдыг төлөөлөхгүй, чи алсан л бол, алсан. Хуулийн дагуу бол чи амь хөнөөгөөгүй гэж маргаж магадгүй, тэр бол хүмүүсийн л яриа. Төрөх газруудын эргэн тойрны орон зайд очих газаргүй олон нялх хүүхэд байгааг бид олж харсан, тэд тахир дутуу биетэй, зарим нь бүтэн биетэй, бүгд нялхаараа, хүүхдүүдийн бяцхан аминууд байсан. Уг нь эдгээр амиуд төрөл олоод өөрсдийн ирээдүйтэй байх байсан, мөн хэдэн жил амьдраад дараахь төрлөө олох мөчлөгт орох

байсан юм. Гэвч чи түүнийг бүр төрөхөөс нь өмнө хөнөөсөн. Дараа нь тэр энэ олон жилийн туршид зовлон зүдгүүртэй тэмцэх хэрэгтэй болно, тийм бяцхан амиуд ганцаардмал байх нь үнэхээр гунигтай юм! Тэрээр тэнгэрээс хуваарилсан дэлхий дээр амьдрах бүх он жилүүдээ дуустал хүлээх ёстой, зөвхөн үүний дараа л тэр дараагийн төрөл олох тойрогтоо орж чадна. Тэгэхээр чи түүнийг шууд ийм гашуун зовлонтой байдалд оруулсан, үүнийг чи алсан биш гэж хэлж болох уу? Үүнээс гадна, энэ нүглийн хэмжээ нэлээд их юм.

Асуулт: Тэгвэл ийм нүгэлтэй хүн бясалгаж чадах уу?

Багш: Тийм ээ, мэдээж бясалгаж чадна. Гэхдээ миний хэлсэнчлэн Сансар ертөнцийн Дафа бүхнийг багтаасан. Тодорхой нэг түвшинд авч үзвэл, Фа үнэмлэхүй юм. Өөр өөр түвшинд өөр өөр Фа байдаг ба түвшин өндөр байх тусам зарчмуудын ойлголт илүү тодорхой байдаг. Учир нь хэрэв чи үнэхээр Төгс гэгээрэлд бясалгаж хүрч чадвал, тэд (алагдсан амиуд) чиний орчлон ертөнцийн амь бодиуд болох нь дамжиггүй. Тэгэхээр, зарим хүмүүс “Тэгвэл амь алахад санаа зовох хэрэггүй юм байна” гэж боддог. Ингэж бодож байгаа хүн бясалгалд яасан ч амжилтанд хүрч чадахгүй. Хэрэв чи бясалгалд амжилтанд хүрэхгүй бол, чи тэдгээр алсан аминыхаа өрийг төлж чадахгүй. Миний хэлснийг ойлгож байна уу? Бясалгалаар эдгээр зүйлийг нөхөж болно, зөвхөн жинхэнэ бясалгалаар л чадна. Төгс гэгээрэлд хүрсний дараа, үйлийн өр төлөгдөж дуусна.

Асуулт: Хорин жилийн өмнө үр хөндөлт хийлгэсэн, би тэр үед сайн мэддэггүй байсан мөн үүнийг зөвшөөрдөг байсан, би одоо ийм их нүгэлтэйгээр бясалгавал яах бол?

Багш: Чи бясалгалдаа л анхаар. Үнэндээ, бидний олон хүмүүс, олон амьдралынхаа туршид аль амьдралдаа юу хийж байснаа яаж мэдэх билээ дээ, бид аль ч амьдралдаа хичнээн их нүглийн өртэй болсноо хэн мэдэх вэ дээ. Өнөө үеийн хүмүүс бүгд нүгэл дээр давхарлагдсан нүгэлтэйгээр энэ үе шатанд хүрч ирсэн, нүгэлгүй

хүн гэж байхгүй. Харваас амь алаагүй хүн гэж байхгүй, алах нь заавал хүн алах гэсэн үг биш. Бид чамайг аварч чадах болохоор, чи бясалгах боломжтой бөгөөд чи Фа олж авсан болохоор эдгээр зүйлийн талаар битгий бод. Зөвхөн бясалгахдаа л анхаарлаа хандуул, бусдыг нь би чамд зохицуулж өгнө. Хэрэв чи Төгс гэгээрэлд хүрвэл, энэ асуудал зохих ёсоороо шийдэгдэнэ.

Асуулт: Германд Фалунь Дафа-гийн хэд хэдэн сурагч ан хийдэг. Тэд үнэг хүний биед шүглэдэг, муу гэж хэлдэг. Би үүнийг хараахан хүлээн зөвшөөрөхгүй байна.

Багш: Бид үнэгнүүдийн талаар ярихгүй. Үнэгнүүд ирээдүйд байхгүй болж болно. Гэхдээ бясалгагчид бид амь алах зүйл хийхгүй байхыг хичээх хэрэгтэй. Түүнээс гадна бид энэрэнгүй байх ёстой биз дээ. Үнэг хүний биед шүглэх тухайд гэвэл, олон үнэг зарим онцгой хүчийг олж авсан, зарим үнэг онцгой хүч чадалгүй, хүний биед шүглэж чадахгүй.

Асуулт: Ирээдүйн хүн төрөлхтөн дээшээ бясалгах шаардлагатай юу?

Багш: Ирээдүйн хүн төрөлхтөн бий болох тэр үед, та нар бараг бүгдээрээ бясалгалаа дуусгасан байх болно, гэхдээ тэр цаг бас удахгүй ирнэ. Дуу, дүрсний бичлэгүүдийг ирээдүйн хүмүүст үлдээхгүй, мөн тэд миний дүр төрхийг мэдэхгүй байх болно. Зарим хүн намайг тэнгэрийн олон нууцыг задруулсан гэж ярьдаг. Үнэндээ ирээдүйн хүмүүс миний Фа заахыг сонсоо ч үгүй. Одоо гудамжинд байгаа хүмүүс Фа-г мэдэхгүй, сонсоо ч үгүй. Мэдээжийн хэрэг, хэрэв чи жинхэнэ бясалгаад Төгс гэгээрэлд хүрээд явбал, би Фа-г Бурхдад заасан болно. Тиймээс тэнгэрийн нууцыг хүмүүст задруулаагүй юм. Ирээдүйн хүмүүс гайхамшигтай үед шилжиж орно, нилээд адислал хишгийг хүртэх болно. Тэдэнд бясалгалаар хичээллэх нь харьцангуй хэцүү байх болно, сайн орчинд тийм их зовлон бэрхшээл байхгүй учраас тэр юм. Тиймээс тэдэнд бясалгах нь тийм ч амар биш байх болно. Гэхдээ нөгөө талаар энэ нь бас

хэвийн байдал, ирээдүйн хүний ертөнц нь тийм ширүүн, муу байхгүй, хэвийн бясалгалын үе байх болно.

Бясалгал бол зовлон бэрхшээлээр дүүрэн байдаг. Энэ нь чиний зовлон бэрхшээлээр хязгаарлагдахгүй. Би өмнө нь хэлж байсан: “Дээр тэсэхийн аргагүй хүйтэн.” Миний ярьж байгаа зүйл энгийн хүмүүсийн ярихаас өөр юм. Өөрөөр хэлбэл, чиний давхарга дээшлэхэд, чиний гон өсөхөд, үүнийг дагаад чиний бүх зүйл сайжирна, мөн чиний бодол чинь ч өөрчлөгдөнө, чамтай ярианы сэдэв нийлэх хүн тун цөөхөн болохыг олж мэднэ. Энэ утгаараа чи маш их ганцаардлыг мэдрэх болно, чи дотроо нэг төрлийн сэтгэлийн дарамт мэдрэх болно. Дараа нь үүнтэй зэрэгцэн нэг байдал илэрнэ: Чи энгийн хүмүүстэй, тэр ч байтугай гэр бүлийнхэнтэйгээ хүртэл ярих зүйл багасна, харьцаа багасана. Ийм болох нь мэдээж юм. Гэхдээ энэ бол ердийн зүйл. Бид энэ харилцааг тэнцвэртэй байлгахыг л хичээдэг. Учир нь чамайг үнэхээр энгийн хүн гэж үзэх боломжгүй юм. Та нар Бурхад, энгийн хүн биш болсон болохоор... Урьд хүний нийгмийг орхиж бясалгадаг байсан лам бол хагас бурхан гэгддэг байсан, өнөөгийн лам нар мэдээж тийм биш болсон, тэдэнд ч тийм чанар байхгүй. Түүнийг хүний нийгмээс гарсны дараа яагаад хагас бурхан гэж хэлдэг байсан бэ? Урьд өмнө энгийн хүний нийгмийг орхиж бясалгаж эхэлсэн бол энгийн хүний амьдралаас бүхий л холбоогоо тасалдаг байсан. Түүнийг хүн хэвээр байсан гэж та нар бодож байна уу? Мэдээж, тэр хүнтэй адил байж чадахаа байсан. Хүн эдгээр энгийн хүний сэтгэл хөдлөлгүйгээр амьдарч чадахгүй. Та нар бясалгалаар хичээллээд, үнэхээр сайжирсныхаа дараа, хүмүүсийн зууралддаг зүйлтэй зууралдахгүй болсноо, мөн хүмүүсийн ярих дуртай зүйл та нарт үнэхээр уйтгартай санагддаг болохыг үзнэ.

Дараа нь хүмүүс болон та нарын хооронд ялгаа гарах нь гарцаагүй бөгөөд энэ ялгаа улам бүр нэмэгдэх болно. Гэхдээ чи энэ зүйлийн талаар хэт их бодох хэрэггүй, яагаад гэвэл чи энэ байдалд орсны дараа, чи харилцах ёстой зүйлтэйгээ аажмаар харилцаж эхлэнэ, мөн аажмаар Гон (кайгон) нээгдэнэ, Гэгээрэл (кайву)-д

хүрнэ. Та нарт өөрсдийн сэтгэл ханамж байхад, хүмүүст бас хүний сэтгэл ханамж байдаг, мэдээж Бурхдад бурхдын сэтгэл ханамж байдаг.

Асуулт: АНУ-д өссөн хүүхдүүд (хятад хүүхдүүд) Хятад хэлэндээ тийм ч сайн биш. Ирээдүйд тэднийг Хятад руу явуулах хэрэгтэй юу?

Багш: Би гадаадад олон газраар явж байсан, энэ байдлыг хаа сайгүй олж харсан гэж хэлж болно, тиймээс би шавь нартайгаа уулзахдаа байнга хэлдэг: Хүүхдүүдээ хятад хэл сурахад нь анхаар, та нар шар арьстны онцлог шинж чанараа алдаж болохгүй. Цагаан арьстнуудын диваажинд чамд орон зай байхгүй учраас шар арьстан хүмүүсийн диваажинд л эргэж очих хэрэгтэй. Хамгийн чухал зүйл бол, чи Фа-г сурахдаа жинхэнэ гүн утгыг нь ойлгож чадах уу үгүй юу гэдэгт л байгаа юм. Өнөөдрийн гадаад хэл рүү орчуулсан номууд нь шилжилтийн үеийн хүмүүсийг ойлгох явцаар л хангана. Яг л манай Хятад Фалунь Гон ном шиг, Энэ нь зөвхөн хүмүүсийн эхлэн ойлгох явцад зориулагдсан бол, жинхэнэ бясалгалд Жуан Фалунь-ийг дагаж мөрддөг. Гадаад хэл рүү орчуулсан номууд нь мөн л чиний ойлгох явцад зориулагдсан болно. Хэрэв чи жинхэнэ бясалгалаар хичээллэхийг хүсч байвал, эх бичвэрийг (хятад хэлнээс) нь унших хэрэгтэй. Зөвхөн эх бичвэрээс л чи юу нь юу болохыг мэдэж болно. Орчуулга нь хичнээн сайн хийгдсэн байсан ч, гүехэн бөгөөд дотоод утга агуулга байдаггүй. Тийм ч учраас бидний олонх нь номыг унших болгондоо өөр байдгийг мэдэрсэн, нэг өгүүлбэрийг өөр давхаргаас уншихад огт өөр байдаг.

Асуулт: Зарим хуучин сурагчид шинэ сурагчидтай нэгдэж хэлэлцүүлэг өрнүүлэх дургүй байдаг. Энэ үзэгдэл зөв үү?

Багш: Бид хүн бүрийг бясалгалын газарт ирж бясалгалаа хий гэж хатуу шаарддаггүй. Би зөвхөн, бясалгалын газартаа группээрээ дасгалаа хийж, өөр хоорондоо ярилцах нь чамайг хурдан сайжруулах боломжтой гэдгийг л хэлдэг, энэ нь сурагчдыг дээширхэд нь нэмэртэй байдаг. Хэрэв хэн нэгэн гэртээ

хичээллэхийг хүсч байвал, гэртээ хийсэн ч болно - энэ бол хамаагүй. Бидний нэлээд сайн бясалгасан хүмүүс байдаг, тэдний цөөнгүй нь гэртээ хичээллэдэг хүмүүс байдаг нь үнэн. Гэхдээ бас хичээнгүй байж чаддаггүй, тогтмол ахиц гаргаж чаддаггүй зарим хүмүүс байдаг, тэдний цөөнгүй хэсэг нь бас гэрээсээ гардаггүй хүмүүс. Тиймээс чи ерөнхий дүгнэлт хийх аргагүй, бас хүмүүст хүчээр тулгаж болохгүй. Бясалгалаар хичээллэх нь бүх талаараа хүмүүсийн зүрх сэтгэлээс л хамаарна. Хэрэв хэн нэгэн зүрх сэтгэлээсээ бясалгахыг хүсэхгүй байвал, түүнийг албадаж ирүүлэх гэсний хэрэг юу байгаа юм, тийм үү? Хэрэв тэр Будда болохыг хүсэхгүй бол, Будда хүртэл юу ч хийж чадахгүй. Зөвхөн хүн өөрөө юу хүсч, юу хийхийг хүсч байгаа нь л чухал юм. Гэхдээ түүнийг ирүүлэх нь бидэнд Фа тараахад тус болох юм шиг чамд санагддаг, чи үүнийг сайн гэж бодон, түүнийг бусдад туслахыг нь ятгадаг. Үнэндээ энэ нь заавал тэгэх албагүй. Гэртээ бясалгах, гадуур бясалгах нь адилхан.

Би сая бас өөр нэг асуудал харлаа, мэдээж чиний сая асуусан зүйл биш. Эх газрын Хятадад байгаа дээхэн үеийн олон хуучин сурагчид гарч бясалгал дасгалаа хийхээ больсон, гадаа бясалгал дасгал хийдэг бараг бүх хүмүүс миний Фа зааж байхад хэзээ ч сонсож байгаагүй хүмүүс, тийм хүмүүс их олон. Энэ бол манай Дафа-гийн тардаг хэлбэр, энэ хэлбэрийг та нарт үлдээсэн юм, мөн хойч үеийнхэн ч гэсэн энэ замаар хийх болно. Энэ бол маш сайн. Тэдгээр бясалгал дасгалаа гадаа хийхээ больсон, гэртээ хичээллэж байгаа хүмүүсийг сайн биш гэж хэлэх гэсэн юм биш, тэдний олонх нь аль хэдийн нилээд сайн бясалгасан. Тэдэнд дөнгөж бясалгаж эхэлж байгаа, Фа-гийн талаар гүнзгий ойлголтгүй сурагчидтай ярилцах нийтлэг зүйл байхгүй санагддаг, ийм байдал гардаг. Тэд бусад сурагчдын ярих дуртай зүйлийг зууралдсан сэтгэл гэж үздэг, тэдэнд таагүй сонсогддог. Энэ нь яагаад тэдний ирдэггүй болсон шалтгаан нь байж магадгүй, ийм учир шалтгаан байдаг. Ер нь, хүмүүс ямар нэг зүйлийг хийхдээ тэд зууралдсан сэтгэлтэй эсвэл зорилготой байдаг. Хэрэв хүн маш сайн бясалгасан бол, түүнд энгийн хүний зууралдсан сэтгэл байхгүй бол, тэр хүмүүсийн дунд байхыг тэвчихгүй. Тэрээр хүмүүсийн хэлсэн ганц өгүүлбэрийг ч

тэсвэрлэж чадахгүй, өгүүлбэр бүр нь, бодол бүр нь, мөн хүмүүсийн ухаан санаанд орсон бүх зүйлс зорилготой байдаг. Чиний сэтгэл санаа цэвэр, ариун, муу юу ч байхгүй бол чи бусдын бодож байгаа бүх зүйлийг мэдэх болно. Тэгээд чи бусдын ганц ч бодлыг, ямар ч үйлдлийг нь, ямар ч өгүүлбэрийг нь тэвчиж чадахааргүй болж, үнэхээр залхмаар санагдана. Чи тэдэнд энэ байдлаа тодорхой тайлбарлаж чадахгүй, тиймээс чи гадагш гарахгүй, ийм тохиолдол байдаг, гэвч бүгд ийм байхгүй. Гэхдээ би шинэ сурагчдыг гадаа дасгал хийсэн нь дээр гэж бодож байна. Яагаад? Учир нь энэ нь чамайг сайжрахад үнэхээр тусалдаг. Хэрэв чи гарч дасгал бясалгал хийхгүй, оронд нь гэртээ хичээллэж юмыг өөрөө ухамсарлах гэж чармайвал, мэдээж ухамсарлах боломжтой, гэхдээ энэ нь удаан байх болно, хэн үргэлж дээшлэхийг хүсэхгүй байх юм? Хэн хурдан сайжрахыг хүсэхгүй байх юм?

Асуулт: Бид ямар нэгэн зүйл хийхдээ, түүнийг хийх ёстой үгүйгээ мэдэхгүй бол Жэнь, Шань, Рэн-ийг хэрхэн удирдамж болгон ашиглах вэ?

Багш: Үнэндээ энэ нь ямар нэгэн зүйл хийх ёстой эсэх талаар биш юм. Хүмүүс ихэвчлэн тодорхой нөхцөл байдалд гацахаараа сайн, мууг цэгнэх чадваргүй болдгийг чи ухаараагүй. Би яагаад өнөөгийн хүн төрөлхтний хөгжлийн нөхцөл байдлын бүх асуудлыг харж чадаж байна вэ? Би бүх зүйлийг тайлбарлаж чадна, учир нь би үүний дотор биш. Чи асуудлыг авч үзэхдээ, дотор нь гацсан үедээ үүнийг битгий хар, тухайн асуудлын хүрээн дотор хязгаарлагдсан байдлаар үүнийг битгий цэгнэ. Үүнээс үсэрч гараад Жэнь, Шань, Рэн-тэй нийцэж байгаа эсэхийг сайтар ажигла. Сайн бясалгасан хүн, эсвэл Бурхан, Бодьсатва үүнийг хэрхэн зохицуулах байсан бэ? Үүнийг ингэж бодож үз, зөв бодол гарч ирмэгц чи ойлгоно.

Асуулт: Төвөгтэй хэцүү орчин өндөр түвшний хүмүүсийг бий болгодог. Эх газрын Хятадын орчин АНУ-аас хамаагүй илүү төвөгтэй, тиймээс эх газрын Хятадад бясалгахад илүү хурдан.

Багш: Хаана ч гэсэн төвөгтэй, янз бүрийн байдлаар төвөгтэй байдаг. Эх газрын Хятадын хүмүүсийн сэтгэлзүйн зөрчилдөөн үнэхээр хүчтэй, тэдний бие биенийхээ эсрэг явуулга маш ширүүн. Гэхдээ АНУ-д гадаргуйн соёл ноцтойгоор эвдэрсэн бөгөөд ад чөтгөрийн шинж байдал их хүчтэй. Тиймээс хэн ч хаана ч бясалгасан болно.

Асуулт: Агаар маш их бохирдолтой байна. Бясалгахад энэ нь муу юу?

Багш: Үгүй ээ, энэ нь бясалгагч бидний хувьд асуудал биш. Чиний бие аажмаар дээд энергийн бие бодиор солигдож байгаа болохоор, эдгээр зүйлс чамайг бохирдуулж чадахгүй.

Асуулт: Бясалгал гадаад орчин, мөн байгаль орчин, нийгмийн орчин, эсвэл бясалгагчийн өөрийнх нь нийгмийн хүрээлэл, амьдрах орчин бүгдэд нөлөөлж чадах уу, сайн сайхан руу Жэнь, Шань, Рэн-ий чиглэл дагуу явуулж чадах уу?

Багш: Энэ нөлөө гарч байна, гэхдээ маш нарийн бөгөөд амархан ажиглагдах боломжгүй юм. Чамтай холбоотой бүх зүйлд нарийн өөрчлөлтүүд гарч байгаа, хоёр төрлийн өөрчлөлт: нэг хэсэг нь чамаас улам бүр холддог, нөгөө төрөл нь чамтай улам бүр ойртдог, өөрөөр хэлбэл тэдгээр зүйлс нь улам бүр сайжирч байна. Зарим нь чамайг бүрмөсөн орхидог, сайн биш хангалтгүйнүүд нь салдаг, ийм зүйл болдог. Өөрчлөлтүүд нь маш нарийн байдаг.

Асуулт: Багшаа, хагас бадамлянхуа завилалтаар сууж бясалгах бүтэн бадамлянхуа завилалтаар сууж бясалгахаас үр дүнгийн хувьд харьцуулбал ямар ялгаатай вэ?

Багш: Бясалгалын үндсэн элемент, механизм байдаг. Манай бүтэн бадамлянхуа суултаар хийдэг дасгалын механизм нь яг л машин тоног төхөөрөмжтэй адилхан гэсэн үг. Машин төхөөрөмжийн арааг ийм байдлаар суурилуулах ёстой байтал, чи өөр байдлаар хүчээр суулгавал юу ч үйлдвэрлэх боломжгүй болно.

Гэхдээ энэ нь заавал ийм байх албагүй, учир нь зарим хүмүүст аажмаар сайжрах явц хэрэгтэй байдаг. Хэрэв чи одоо хөлөө давхар завилж чадахгүй бол, аажимдаа хийж чаддаг болохыг хичээ. Тиймээс бидэнд үүнийг зохицуулах арга замууд бий. Чи гүйцэж авахын тулд боломжийн хэрээр хичээх хэрэгтэй.

Асуулт: Бадамлянхуа завилалтаар сууж байхад амгаланд орж чадахгүй бол төвлөрч бас чаддаггүй. Энэ нь миний түвшин доогуур, мөн өндөр түвшинд хүрч чадахгүй гэсэн үг үү?

Багш: Хэрэв чи суумагцаа, гүн амгалан (дин)-д орж чадвал, чиний одоогийн түвшин аль хэдийн их өндөр гэсэн үг. Энэ талаар номонд бичигдсэн байгаа. Хэрэв чи үнэхээр гүн амгаланд орж чадахгүй байгаа бол, дарагдахгүй байгаа бодлыг өөр хүнийх гэж үз. Үнэндээ, энэ нь чи биш гэдгийг эхлээд хэлье, энэ нь төрсний дараахь олж авсан ойлголтууд, мөн бодлын нүглээс бүрддэг. Чи уг нь бясалган суугаад гүн амгаланд орохыг хүссэн, гэвч яагаад амгаланд орж өгөхгүй байна вэ? Энэ нь чамайг сонсохгүй байна, тэгвэл чинийх байж болох уу? Энэ бол нүгэл бужигнуулж байгаа юм, тиймээс чи үүнийг өөр хүнийх гэж үзэх хэрэгтэй. Зууралдсан сэтгэлүүдээ хөнгөвчлөхийн хэрээр, аажим аажмаар улам амгаланд ордог болно, чиний түвшин ч бас дээшилнэ.

Асуулт: Би дасгал хийхдээ үргэлж нойрмоглодог. Би унтах хэрэгтэй юу, эсвэл энэ нь чөтгөр байвал би түүнтэй тэмцэх ёстой юу гэдгийг хэлж өгнө үү?

Багш: Унтах нь өөрөө чөтгөр биш. Энэ бол хүн амрах ёстой хүчин зүйл юм. Энэ бол орчлон ертөнцийг бүрдүүлдэг зүйлсийн нэг хүчин зүйлс юм. Гэхдээ бясаллагчийн хувьд, хэрэв чи бясалгалын үеэр унтвал, энэ нь чөтгөрийн үүрэг гүйцэтгэж бясалгалд саад болно. Энэ бол өөрөө чөтгөр биш, гэхдээ тийм үүргийг гүйцэтгэж чадна. Нөгөө талаар, энэ нь чиний сэтгэлийн тэнхээг хүчтэй болгохыг шаардана. Чи сэтгэлийн тэнхээгээ бясалгах хэрэгтэй биш гэж үү? Чи сэтгэлийн тэнхээгээ хатуужууулах хэрэгтэй, мөн түүнийг хязгаарлах нь сэтгэлийн

тэнхээгээ хүчирхэг болгож байгаа хэрэг, энэ нь бас бясалгал юм. Дасгал хийж байхдаа нойрмоглох нь бас өөрөө бодлын нүглийн нөлөө байдаг.

Асуулт: Би энергийн механизм гэж яг юу болохыг асуумаар байна.

Багш: Энергийн механизм бол хүний харж чадахгүй гон-ы маш бичил бодисуудаас бүтсэн хөдөлгөөнт механизм юм. Эдгээр механизмууд хэлбэртэй, гэвч хүмүүс үүнийг харж чадахгүй. Ирээдүйд чиний бясалгал тодорхой хэмжээнд хүрэхэд, чиний тэнгэрийн мэлмий нилээд сайн нээгдэхэд, чи үүнийг харах боломжтой болно. Энэ нь бүслүүртэй төстэй, чиний биеийн эргэн тойронд ажиллаж байдаг цагаан бүслүүр. Энэ нь чиний дантиан дотор байдаг Фалунь-тай холбоостой. Чамайг дасгал хийхэд энэ нь байнга хүчирхэгжиж байдаг. Эдгээр механизмууд илүү хүчтэй байх тусам, дасгалыг чинь автоматаар удирдах нь илүү сайн болно. Энэ нь дасгал хийгээгүй байхад ч гэсэн эргэж байдаг, тэдгээр нь автоматаар дасгал хийхэд тусалж байдаг. Бидний заадаг таван дасгал бүгдэд эдгээр механизмууд ажиллаж байдаг. Хэдийгээр чи өөрийгөө энд хөдөлгөөнгүй зогсож байгааг харж байгаа боловч чиний биеийн механизмууд урагш хойш хөдөлж, бүхэл биеийн чинь хувиралтыг удирдаж байдаг.

Асуулт: Фалунь Диваажинд Фалунь дуу бий юу?

Багш: Энэ бол зар сурталчилгаа хийх, хүний хийдэг зүйл. Буддын Фа яаж тийм нухацтай бус байж болох юм?! Өнөөгийн хүмүүс Буддаг хүн мэт үзэж байна. Гэхдээ Буддууд бол зүйрлэшгүй аугаа Бурхад. Урьд өмнө хүмүүс Буддын тухай дурсахад тэдэнд хязгааргүй хүндэтгэл мэдрэмж төрдөг байсан. Өнөө үед хүмүүс хайхрамжгүйгээр ярьцгаадаг. Будда, Бодьсадва, Гэгээн Мария-гийн зураг хөргийг сийлж оршуулгын газарт тавьдаг- энэ бол зүгээр л Будда, Бодьсадва, Гэгээн Мария нарыг доромжилж байна. Тэд нас барагсдын булшны чулуугаар хүрээлэгдсэн байдаг. Хүмүүс юу хийж байгаагаа мэдэхгүй байна.

Тэд үүнийг зүгээр гэж боддог, Будда, Бодьсадва, Гэгээн Мария нарыг нас барагсдыг харж хандахыг хүсдэг, тэд яг л Бурханд тушааж байгаа юм шиг байдаг. Энэ нь тийм биш гэж үү? Чухамдаа эдгээр нь хүмүүсийн нүгэлт бодлоос төрсөн зүйл. Олон чигон бясалгал нь бүжиг, дуу гэгчийг хийдэг. Тэдгээр зүйлс нь бясалгалтай ямар хамаатай байх юм? Үүнээс гадна, тэд хүмүүсийн сэтгэл хөдлөлд автах зууралдсан сэтгэлийг өдөөж өгдөг (*чин*). Энэ бол Будда, Дао, Бурхдыг хүний бодол, хүний сэтгэлгээгээр харж байгаа явдал юм. Үнэндээ, хүний сэтгэлгээгээр тэдгээрийг бодож огт таарахгүй. Чи маш сайн бясалгаж, эдгээр хүний бодол чамд байхгүй болоход Төгс гэгээрэлд хүрч чадна.

Асуулт: Бид “санаснаараа болгох” гэсэн зарчмыг баримталж амьдарч байна. Бид эдгээр хүслийг өдөр тутмын амьдралдаа үгүй болгох ёстой. Заримдаа би үүнд эргэлздэг, энэ нь намайг их бухимдуулдаг.

Багш: Чи бясалгаж байхдаа Фа-гийн тодорхой түвшний ойлголттой болсон гэж мэдэрдэг, тиймээс сайжрах хэрэгтэй, зарим муу бодлоосоо ангижрах ёстой гэж боддог, гэхдээ тэр бодол нь байсаар байгаа нь чамайг мухардмал байдалд оруулдаг, “Яагаад надад ийм бодол байсаар байна вэ?” гээд өөртөө зөрчил үүсгэдэг. Тийм үү? Би чамд хэлье, би энэ талаар сүүлийн удаа тайлбарласан, хэрэв бид өдөр тутмын амьдралыг дэмждэг хүний бүх бодлоо арилгавал чи энгийн хүмүүсийн дунд нэг өдөр ч байж чадахгүй байх байсан. Хүмүүсийн хийдэг бүх зүйл зууралдсан сэтгэлд хөтлөгдсөн байдаг болохоор чи хүний нэг ч бодлыг тэвчихгүй байх байсан. Ийм бодлууд чамд байхгүй бол хүмүүсийн дунд байхад ямар мэдрэмж төрдгийг чи төсөөлөх ч үгүй. Тиймээс чамайг энгийн хүмүүсийн дунд бясалгуулахын тулд зөвхөн Төгс гэгээрэлд хүрэхэд чиний хамгийн гадаргуй хувирч бүх зууралдсан сэтгэл чинь арилах болно.

Асуулт: Цагаан арьст хүмүүс Төгс гэгээрэлд хүрсний дараа, аль диваажинд очих вэ?

Багш: Энэ асуултыг аль хэдийн ярилцсан шүү дээ. Бидний зарим нь Жуан Фалунь дахь Будда нарын дүр төрхийг харж байсан байх, зарим нь Жуан Фалунь-ий Англи хувилбараас Гэгээн Мария эсвэл Есүс шиг хувцасласан Бурхадьг, цагаан арьстны дүртэй Бурхдыг үг болгонд харсан байх. Хэдийгээр чи манай Дафа-д бясалгаж байгаа ч гэсэн... бид Буддын системийнх гэж хэлсэн, гэхдээ би бүхэл бүтэн сансар ертөнцийн мөн чанар, сансар ертөнцийн зарчмууд, сансар ертөнцийн Фа-г зааж байна. Мэдээж өөр Бурхдыг бас багтаасан байгаа. Тэгвэл цагаан арьст хүн Төгс гэгээрэлд хүрвэл, түүний биед бясалгасан гон нь мөн цагаан арьстны дүр төрхтэй байна, мөн тэр Төгс гэгээрэлд хүрсний дараа Цагаан арьстнуудын диваажинд очих болно, тэдний бясалгасан нялх хүүхдүүд (инхай) бүгд далавчтай байдаг. Мэдээжийн хэрэг, Дао системийн хувьд, мөн адилхан байна.

Асуулт: Амь хороосон нүглийг яаж төлөх вэ?

Багш: Бясалгаж байх явцад зарим аюултай тохиолдлуудтай тулгарч байсан бидний олон шавь нар байдаг - автомашины осол, өндрөөс унах, гэх мэтчилэн бусад олон тохиолдлууд. Үүний дараа, манай сурагчид аз жаргалтай байдал мэдэрдэг бөгөөд үүнд баярлах нь аргагүй юм. Мэдээжийн хэрэг, би Фа-д тайлбарласны дагуу, энэ нь урьд өмнө бий болсон асар их хэмжээний нүглийг төлөхтэй тэнцэх бөгөөд тэр ч байтугай амийг төлсөнтэй тэнцэх болно. Хэрэв тэр амийн өр үнэхээр төлөгдсөн бол, чи тэр амины өрийг аль хэдийн төлчихсөн болохоор чиний нэр тамаас хасагдах болно.

Үнэндээ, ослын дараа чамд юу ч болсонгүй гэж битгий бод, нүглээс бүрдсэн чи үнэхээр үхсэн. Түүнээс гадна, тэр биед чиний муу нүглээс бүтсэн бодол, зүрх, үе мөч байсан, энэ нь ослоор үхсэн, энэ нь бүхэлдээ нүглээс бүрдсэн байсан юм. Бид чамд ийм асар сайн зүйлийг хийж өгсөн, ийм асар их хэмжээний нүглийг чинь арилгаж, түүгээр амины өрийг төлсөн, өөр хэн ч үүнийг хийдэггүй. Бид чамайг бясалгалаар хичээллэж чадаж байгаа болохоор үүнийг хийдэг. Үүнийг чи ухамсарлавал надад талархлаа илэрхийлэх аргаа олохгүй.

Асуулт: Бид хэрхэн Төгс гэгээрэлд хүрэх вэ?

Багш: Бид хүний биеийг (*бенти*) Буддын бие болгон хувиргахын тулд бидний энэхүү Фа-г заан тараадаг. Энэ бол бидний туулах зам, бид Нирваны замаар явахгүй, мөн Гэрэлт хувирал, эсвэл Дао-гийн хулс модыг хүний бие болгон хувиргаж авсанд хийдэг “Цогцос-ангигжруулалт” гэх мэт арга хэрэглэхгүй. Чиний бие махбодь хэдийнээ өөрчлөгдөн хувирсан байх тул, бид чамайг Төгс гэгээрэлд хүрч байгааг чинь хүмүүст ил тодоор, эрхэмсэг дээдээр харуулах болно.

Асуулт: Багш энгийн хүмүүсийн дунд бясалгахын хажуугаар энгийн хүний ажлаа сайн хийх хэрэгтэй гэж хэлсэн... Би их цаг зарцуулдаггүй сайн хийж чадах ажил олохыг хүсч байгаа, тэгвэл би бясалгалдаа илүү цаг заваа зориулж чадна.

Багш: Бид бүгдээрээ ийм бодолтой байдаг. Та бүгд амархан ажил олохыг хүсдэг, ингэснээр та нар бясалгалдаа илүү их цаг зарцуулж чадахаас гадна сайн ажил хийх боломжтой болно гэдэг. Бодол бол эцсийн эцэст зүгээр л бодол юм. Чиний хандлага чинь бясалгалаар хичээллэхийн төлөө л байх. Гэхдээ ихэнхдээ бидний хүссэнээр болохгүй байж магадгүй, учир нь хүн бүрийн нөхцөл байдал өөр. Чамд үүнийг тодорхой байдлаар хийх гэж зүтгэсэн ямар нэгэн хүчтэй зууралдсан сэтгэл байхгүй л бол, миний Номын бие (*Фашэнь*) чамд бүх зүйлийг маш сайн зохицуулж өгнө. Чи ердийн ажилтай байгаад ч бас бясалгаж чадна, адилхан.

Асуулт: Зарим хүн уламжлалт ханзаар бичигдсэн Жуан Фалунь-ийг унших нь хялбаршуулсан ханзаар бичигдсэнийг уншихаас өөр байдаг, өөр мэдрэмж төрдөг гэдэг.

Багш: Энэ нь тийм гэсэн үг биш юм. Энэ нь адилхан байх ёстой. Нэг зүйл бий: Хятад дахь "Соёлын хувьсгал"-аас хойш хүмүүсийн сэтгэлгээнд асар их өөрчлөлт орсон. Зүүн өмнөд Ази болон бусад бүс нутагт байгаа Тайвань, Хятад хүмүүс энэ талаар

ярихдаа арай өөр бодолтой байдаг. Энэ нь чиний уламжлалт ханзаар бичигдсэн Жуан Фалунь-ийг уншдаг байсан хандлагатай холбоотой, хялбаршуулсан ханзаар уншингуут Хятадын чамд нийцгүй байдаг зүйлстэй холилдсон мэт сэтгэгдэл төрдөг үү? Энэ бол үнэндээ чиний сэтгэл санааны саад тотгор юм.

Асуулт: Заримдаа Жуан Фалунь-ийг уншиж байхдаа номоо тавихыг хүсдэггүй, уншаад л баймаар байдаг, бас дасгалаа ч хийхийг хүсдэггүй.

Багш: Хэрэв чи Жуан Фалунь-ийг уншихдаа номоо тавихыг хүсэхгүй байвал үргэлжлүүлэн унш, зүгээр. Дасгалаа дараа нь хийсэн ч болно. Номыг их унших тусам сайн, Фа сурах нь тэргүүн чухал зүйл юм.